

**ХУУЛЬ
САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛЬ**

**МОНГОЛЫН
ХУУЛЬЧ
ЭРДЭМТДИЙН
ХОЛБОО**

**МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО**

**ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ
ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ**

**2015 №3 (53)
13 дахь жилдээ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Н.ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ДОКТОРАНТ

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.МӨНХЗУЛ
МАГИСТР

Гарчиг.....

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Криминологическая характеристика убийств по законодательству монголии.....Мягмарцэрэн Думбурай, Отгонбаяр Монхоо
- Baby box буюу хүүхдийн хайрцгийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага.....И.Мөнхсонор

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт (Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн жишээн дээр).....О.Зоригт, С.Гантулга
- Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх ял тэнсэх институцийн тухай.....А.Баасанцэрэн, Б.Мөнхзул

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Нотлох ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний ач холбогдол, өнөөгийн байдал, чиг хандлага.....Л.Цогтбаяр
- Особенности хранения имущества, на которое наложен арест по УПК РФ и Монголии.....Жалбуу Ганбатор

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Монгол бичигт хийх шүүх шинжилгээний адилтгалын мөн чанар.....З.Сүлд
- Гар бичмэлийн оношилгооны шинжилгээ.....Б.Отгондалай

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Зөвшөөрлийн тогтолцоонд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, эрх зүйн үндэс.....Д.Булган
- Цагдаагийн байгууллага, албан хаагчаас галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....Ш.Чулуун
- Терроризм гэж юу вэ?.....Б.Баянмөнх
- Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь.....Г.Бямбадорж

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Өлсгөлөн зарлах эрх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....Б.Нармандах, Г.Хулан
- Ипотекийн эрх зүйн зохицуулалт ба түүний үүсэл хөгжил.....Ц.Мөнхдэлгэр
- Понятие земли (почвы) в законодательстве Российской Федерации: отдельные правовые аспекты..... Воронцова Оксана Викторовна
- Төрийн албан хаагчийн аюулгүй байдалд төрийн албаны тогтвортой байдал нөлөөлөх нь.....З.Дашдаваа

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



МЯГМАРЦЭРЭН Думбурай.

*Доктор (Ph.D), дэд профессор, Эрүүгийн тагнуулын тэнхимийн эрхлэгч,
цагдаагийн хурандаа.*

ОТГОНБАЯР Мөнхөө

Докторант, цагдаагийн хурандаа

КРИМИНОЛОГИЧЕСКАЯ ХАРАКТЕРИСТИКА УБИЙСТВ ПО ЗАКОНОДАТЕЛЬСТВУ МОНГОЛИИ

Аннотация: статья посвящена криминологической характеристике умышленной убийстве и структурному изменению убийств с отягчающими обстоятельствами

Ключевые слова: убийство, криминологическая характеристика, динамика,

Abstract: the article is devoted to the criminological characteristics of intentional homicide end structural change of homicide with [aggravating circumstances](#)

В соответствии со ст.16 Конституции Монголии [1] жизнь гражданина и человека является высшей ценностью для государства. И исходя из этой посылки преступления, направленные против личности, расположены в особенной части уголовного кодекса на приоритетных местах. Поскольку высшими и истинными ценностями, которые находятся под охраной, в том числе и уголовного законодательства могут быть лишь жизнь человека, его здоровье, его неотъемлемые права на свободу передвижения, честь, достоинство, половая неприкосновенность и половая свобода.

Современное уголовное законодательство (ст.91 УК Монголии)[2] под убийством понимает только умышленное причинение смерти другому человеку. В ч.1 ст.91 УК Монголии предусмотрена ответственность за простое убийство - без отягчающих и смягчающих обстоятельств, а в ч.2 ст.91 УК Монголии - ответственность за убийство при

отягчающих обстоятельствах. Кроме того ст.92 закрепляет - убийство матерью новорожденного, ст.93 - убийство, совершенное в состоянии аффекта, ст.94 - причинение смерти по неосторожности. Убийство, совершенное при превышении пределов необходимой обороны как указанное в ст.108 УК РФ монгольском уголовном кодексе нет. Действующем уголовном кодексе от 2002 года декриминализирован понятие превышения необходимой обороны.

Доля насильственных преступлений в структуре преступности Монголии невелика. Взятая в целом тяжкая насильственная преступность занимает в структуре всей преступности Монголии пока достаточно скромное место. На долю умышленного убийства приходится всего лишь 1 процента в общей совокупности всех уголовно наказуемых деяний в Монголии.[3]

Преступления рассматриваемого типа в криминальной структуре Монголии составляют лишь около 3%,[4] поэтому они в общественном сознании ассоциируются у нас с понятием «преступность». В этом особый аспект их общественной опасности.

Начиная с середины 70-х гг. В Монголии отмечается интенсивный рост их числа, а в 1991-1999 гг. происходили и существенные качественные изменения в связи количественными и качественными изменениями происшедшими в обществе иначе говоря с демократизацией общественного строя в Монголии. В 1999 г. по сравнению с 1986 г. число насильственных преступлений против человека выросло почти в 2 раза: с 102 до 210, а число выявленных лиц, совершивших данные преступные деяния, соответственно.

Однако необходимо также учитывать, что умышленные убийства и иные преступления, наносящие вред здоровью, имеют немалую латентную (скрытую) часть.[5] Увеличивалось число лиц, совершивших убийство, но оставшихся при этом не выявленными и не наказанными, так как в течение ряда лет последовательно снижался процент раскрываемых тяжких насильственных преступлений. По зарегистрированным умышленным убийствам он не превышал 89.3%. Значительная часть умышленных убийств при отягчающих обстоятельствах оставалась не раскрытой и в уголовной статистике отражалась с иной предварительной квалификацией (убийства без отягчающих, обстоятельств. В Монголии совершаются убийства бытового характера, которые чаще всего раскрывались. Эти преступления, совершенные в отношении лиц из ближайшего окружения (родственников, членов семьи, соседей, приятелей), причем среди виновных были почти исключительно лица, злоупотреблявшие алкоголем, характеризовавшиеся аморальным образом жизни и, как правило, известные правоохранительным органам. Наиболее тяжким преступлением против жизни является умышленное убийство. В 1990-2014гг. число зарегистрированных умышленных убийств увеличилось в 3 раза. После кратковременного его снижения в 2002г. — после принятия нового УК Монголии и частичного изменения статистической отчетности в 1990-2000 гг. вновь отмечен рост числа умышленных убийств. Последние 10 лет число умышленных

убийств стабильно стоит в пределах 300 [6] способы и мотивы, совершения убийств расширяется. Убийства совершаются изощренными способами и жестокостью.

В Монголии наблюдаются большие региональные различия в уровнях преступности (схема №2) показатели убийств заметно растут по числу увеличения числа населения в населенных пунктах. Интересно отметить, что хотя общий уровень преступности и убийств в абсолютном выражении стабильна, распределение этих показателей по регионам осталось относительно равноуровневым, доказывая тем самым, что существует пространственно-региональная структура преступности, связанная централизацией населения в развитые населенные пункты.

Однако в 2005 г. в Монголии сокращается число убийств. Данные статистические данные опубликованы в бюллетени ГИЦ ГУП Монголии. Динамика убийств за последние 10 лет отличается определенной положительной стабильностью, то есть их количество постоянно уменьшается, остаток нераскрытых сокращается, а раскрываемость увеличивается с 77% до 89.3%. В 2005г. в Монголии зарегистрировано почти 349 убийств, что на 7.2 процентов больше, чем за 2014.

Динамика насильственных преступлений характеризуется весьма неблагоприятными тенденциями:

- началом убийств жестокого характера;
- увеличением удельного веса преднамеренных насильственных преступлений (тех, что предварительно тщательно планируются);
- увеличением удельного веса насильственных преступлений, совершаемых с применением всякого вида оружия.

Более 86% убийств и покушений на убийство совершаются лицами мужского пола. Примерно 6% анализируемых преступлений совершаются несовершеннолетними (14 лет), около 45% — взрослые в возрасте 18-24 лет. 50-60% рассматриваемых преступлений совершаются группой лиц. Более 75% убийств и покушений на убийство совершаются лицами без постоянного источника дохода, около 20% — рабочими, 75% — безработными, более 45% — лицами не совершавшими преступления. До 70% рассматриваемых преступлений совершаются в состоянии алкогольного опьянения.

По мотивам и целям рассматриваемые преступления объединяют в три основные группы: 1) совершенные в сфере семейно-бытовых отношений; 2) уличные; 3) другие.

В субботу и воскресенье совершается 42% убийств, в будние дни – 28%, в праздники государственного значения – 10%, в пятницу – 18%.

В промежутки времени между 22 и 24 часами совершается наибольшее количество убийств – 40%; с 24 до 6 часов – 20%; с 19 до 22 часов — 20%; с 14 до 19 часов – 10%; с 6 до 9 часов — 10%.

В последние годы значительно вырос удельный вес холодного оружия, используемых при совершении преступлений против личности. Более 30% убийств совершается с применением холодного оружия, около 15% — с помощью предметов, используемых в качестве орудий совершения преступления.

Были особые случаи, когда потерпевшим становились лица из числа лиц, ранее судимых и женщины при сексуальных контактах, сопровождаемых причинением тяжкого вреда здоровью, а нередко убийством садистского характера, еще были убийства детей с разложением трупа, заказ на убийство и так далее.

Из выше сказанного следует, что в Монголии начинается (качественное) изменение структур преступлений в пользу отягчающих обстоятельств. Убийства совершенные последние годы в Монголии показывают наглядное изменение структуры убийств в пользу отягчающих обстоятельств.

Библиографический список:

- [1] Конституция Монголии.
- [2] Уголовный кодекс Монголии.
- [3] Бюллетень ГИЦ Монголии за 2014 год. УБ.стр.11
- [4] Состояние преступности в Монголии. Итоговая коллегия ГУП Монголии. Из доклада начальника ГИЦ ГУП Монголии. Аналитические материалы.
- [5] Долгова А. И.. Преступность в России в конце девяностых годов и борьба с ней // Криминальная ситуация на рубеже веков в России. М., 1999. С.97.
- [6] Схема№1

Использованные материалы

Ж.Авхиа “Преступления против личности борьба с ними ” УБ.1982.,
Ж.Авхиа “Методика раскрытия и расследования убийств”УБ.1987.,
Учебник Уголовного права, часть особенная.УБ.1979., авторский коллектив под руководством Ж.Авхиа
Г.Совд “Курс Уголовного права Монголии, часть особенная”УБ.1965.
С.Жанцан “Уголовное право Монголии.Часть особенная, в схемах. Вопросы квалификации”УБ.2002.
С.Нарангэрэл “Уголовное право Монголии.Часть особенная”УБ.1998.
Ж.Болдбаатар “Уголовное право Монголии”УБ.2011.
Ю.Н.Кручин “Монгольско русский словарь”М.УБ.2004.
www.legalinfo.

Приложения

Схема №1

Статистические данные за последние 10 лет





Схема №2 Число убийств за 2013-2014 год





Б.Мөнхзуул

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч*

И.Мөнхсонор

*Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн
мөрдөн байцаагч, цагдаагийн дэслэгч*

“BABY BOX” БУЮУ “ХҮҮХДИЙН ХАЙРЦАГ”-ИЙГ НЭВТРҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Эцэг, эхдээ баяр баясгалан, аз жаргал, гэрэл гэгээ нь болж ирэх ёстой хүүхдүүд нийгэм, эдийн засгийн байдал, хувь хүний ухамсар зэргээс шалтгаалан зовлон дагуулсан амьтан, амьдралын гай зэргээр хүний хэл эвлэмээргүй нэр зүүж хайр, энхрийлэл бус үзэн ядалт хүлээж байна.


Нийгмийн хүнд хэцүү байдал, хүсээгүй жирэмслэлт, хувь хүний ухамсаргүй байдал зэрэг нь үр хөндөлт хийлгэх, зориуд дутуу төрүүлэх, төрснийх нь дараа хаях, санаатайгаар амь насыг нь хөнөөх зэрэг гэмт явдлыг бий болгож байгаа нь харамсалтай.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хүүхэд хаях, төөрүүлэх зэрэг гэмт хэргийн гаралт нэмэгдэж, нярай болон бага насны хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж, олон нийтийг түгшээх болсон.

Иймд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан, нөхцлийг судалж тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох зорилгоор энэхүү асуудлыг сонгог судлав.

Монгол Улс дахь эх нярай хүүхдээ алах, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал

Сүүлийн 3 жил буюу 2012, 2013, 2014 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд заасан “Хүүхэд хаях, төөрүүлэх” гэмт хэрэг нийт 39 удаа бүртгэгдсэнээс 14 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, прокурорын хяналтад шилжүүлжээ. Харин Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйл буюу “Эх нь нярай хүүхдээ алах” гэмт хэрэг 44 бүртгэгдэж, 10 хэргийг прокурорын хяналтанд шилжүүлсэн байна. Үүнээс графикаар үзүүлбэл:



Эндээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

Зөвхөн 2013 онд Хүүхдийн төв сувилалд эцэг, эхдээ хаягдсан 10 нярай ирсэн байна. Эдгээр нярай хүүхдүүд 3 нас хүртлээ тус төвд эмчлүүлэн, сувилуулж, дараагаар нь 58 дугаар цэцэрлэгт шилжин очдог. Харин эцэг, эх нь хаясан хүүхдээ буцаан авсан тохиолдол огт байхгүй¹.

Гадаадын зарим оронд эх нярай хүүхдээ алах, хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлж буй туршилага

Дэлхийн зарим оронд хүүхдээ хаях, төөрүүлэх тохиолдол их бүртгэгддэг. Тухайлбал, хүн ам ихтэй БНХАУ, Арабын Нэгдсэн Эмират улс, Энэтхэг улс, ОХУ, АНУ зэрэг улсад олон мянган хүүхэд гудамж талбай, орц, хонгил, хогийн сав, айлын үүдэнд хаягддаг.

Гэвч эдгээр улс орнууд эцэг, эхдээ төрөл бүрийн шалтгааны улмаас хаягдсан нярай хүүхдүүдийг “BABY BOX” буюу “ХҮҮХДИЙН ХАЙРЦАГ”-ийн тусламжтайгаар тэдний амь нас, эрүүл мэндэд хор уршиг учруулалгүйгээр аварч, улсын болон хувийн асрамжийн газарт хүргэн өсгөн хүмүүжүүлж, иргэн болгон төлөвшүүлж байна.

Дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй ихэнхи орнуудад “BABY BOX” хөтөлбөр хэрэгждэг бөгөөд хүүхдийн хайрцгийг төрөх эмнэлгүүд болон цагдаагийн газар, хүүхдийн асрамжийн газар, цэцэрлэг болон тухайн улс орны өөрийн нөхцөл байдалд тохирсон ямар ч газарт байрлуулж, хүүхдээ өсгөхийг хүсээгүй, эсвэл өсгөх боломжгүй эцэг, эхчүүд өөрсдийгөө мэдэгдүүлэхгүйгээр хүүхдээ энэ хайрцагт орхиж, улмаар орхигдсон хүүхдүүдийг улсын асрамжид авч өсгөж хүмүүжүүлдэг байна.

Манай хоёр хөрш болох ОХУ болон БНХАУ-д энэхүү “Хүүхдийн хайрцаг” хөтөлбөрийг 2011 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд бусад орнуудад энэ хөтөлбөрийг нэлээд эртнээс хэрэгжүүлж, ирээдүй хойч үе болсон хүүхдүүдээ аварч байна. Тухайлбал, ОХУ-ын Сочи хотод жил бүр 100 гаруй хүүхэд эцэг, эхдээ хаягддаг ба хотын төрөх эмнэлгийн хананд 3 ширхэг “Хүүхдийн хайрцаг” байрлуулсан байна. Үүний дүнд нярайн

¹<http://mongol.tv.mn/>

амь нас, эрүүл мэндэд хор уршиг учрахаар урьдчилан сэргийлж чадаж байна. Иймээс энэхүү төслийг тус улсын бусад хотуудад хэрэгжүүлж эхэлжээ².

Мөн Хятадын зарим хотод энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Тухайлбал, 2011 оноос Шижиажуан хотод “хүүхдийн хайрцаг”-ийг байрлуулснаар 1700 хүүхэд хүлээн авч асрамжид шилжүүлсэн байна.³

Монгол Улс “Хүүхдийн хайрцаг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай. Учир нь манай орны эрс тэс уур амьсгалаас шалтгаалан эцэг, эхдээ хаягдсан нярай амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал цөөнгүй тохиолддог. Эдгээр хүүхдийн дотор хичнээн суут ухаантан, ирээдүйн боловсон хүчин, хичнээн олимпын аварга байгааг тааварлах боломжгүй.

Цагдаагийн байгууллага нярай хүүхдээ алсан, хүүхдээ хаясан, төөрүүлсэн эцэг, эхчүүдийг олж тогтоон, улмаар шүүхээс гэмт буруутай этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг боловч төрүүлсэн хүүхдээ хаях, төөрүүлэх, алах болсон шалтгаан, нөхцөлд төдийлөн анхаарал хандуулж, энэ чиглэлд арга хэмжээ авдаггүй. Эдгээр эцэг, эхчүүдэд ганцхан буруу өгөх аргагүй юм.

Иймд олон улсад хэрэгжүүлж буй “BABY BOX” буюу “ХҮҮХДИЙН ХАЙРЦАГ” хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын санаачлагаар төрийн болон төрийн бус байгууллагууд, эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэх нь энэхүү гэмт хэргийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, нярайн амь нас, эрүүл мэндийг хамгаалах хамгийн үр дүнтэй арга юм.

Энэхүү хөтөлбөрт шаардлагатай судалгааг явуулж, гадаадын орнуудын туршлагыг судлан, техник, технологийн дэвшлийг ашиглан хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүүхдийн хайрцгийг зохион бүтээж, улмаар зөв шийдэлтэйгээр зөв газарт байрлуулснаар уг хөтөлбөр үр дүнтэйгээр хэрэгжих боломжтой.

²<http://news.niigem.mn/>

³www.assa.mn

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЯЛЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ (ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

О.Зоригт
ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.),
цагдаагийн хурандаа

С.Гантулга
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн ахлах багш, доктор (Ph.), цагдаагийн хошууч

Ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн хууль батлан гаргах зүй ёсны шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийг боловсруулж, УИХ-д өргөн бариад байна. Энэхүү хуулийн төслөөс үзэхэд, Монгол Улсын ялын бодлого, ялын тогтолцоонд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт оржээ. Тухайлбал,

Нэг. Ялын бодлогын талаар:

- Санкц нь ялын төрөл, хэмжээг илэрхийлдэг тул аливаа ял нь гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруу, хувийн байдалд тохирсон байх учиртай.⁴ Ялангуяа хорих ялын санкцын хэмжээ нь тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдлаас шууд хамааралтай хуульчлагдаж ирсэн байдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд хорих ялын хэмжээ нэгээс арван таван жил, онцгой тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаатай байгаа бол хуулийн төсөлд долоо хоногоос хорин жил хүртэл хугацаатай, эсхүл бүх насаар нь хорихоор (одоогийн хуульд цаазаар авах оногдуулахаар заасан гэмт хэрэгт) тусгажээ. **Эндээс үзэхэд, хорих ялын хэмжээг урьд байгаагүйгээр зөөлрүүлсэн нь гэмт хэргийг тогтоон барихад ялын хатуу чанга нь бус гарцаагүй байх нь чухал бөгөөд шийтгэлгүй өнгөрөх бол уу гэсэн найдлага дагуулсан хатуу ялаар шийтгэгдэх айдсаас хөнгөн боловч гарцаагүй шийтгүүлнэ гэсэн мэдрэмж илүү нөлөөтэй гэсэн онол, олон улсын хандлагатай нийцэж байна.**

- Харин хуулийн төсөлд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг гэсэн бүлгийг шинээр тусгасан бөгөөд хүүхдийн эсрэг үйлддэг хүчирхийлэл, албадлагын шинж чанартай гэмт хэргүүдийн ялын бодлогыг чангатгасан нь мөн л олон улсын хандлагыг харгалзан үзсэн явдал юм. Тухайлбал, АНУ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсын эрүүгийн хууль тогтоомжоос үзэхэд, энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял харьцангуй өндөр, ялын бодлогын хувьд чанга байна.

⁴ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Ялын тухай сургаал) II боть. УБ., 2014. 142 дахь тал

Мөн хуулийн төсөлд эдийн засгийн гэмт хэрэг гэсэн шинэ бүлгийг орчин үеийн нийгмийн харилцааны онцлог, олон улсын хандлагыг харгалзан оруулж, тухайн бүлэгт хууль бусаар өрсөлдөх, зах зээлийн үнэд хууль бусаар нөлөөлөх, зах зээл дэх давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, зохиомлоор, эсхүл зориуд дампуурах, банк, санхүүгийн үйл ажиллагаа хууль бусаар эрхлэх, аж ахуйн үйл ажиллагааны нууцад халдах, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх, хууль бусаар нийгмийн халамжийн үйлчилгээ, даатгалын нөхөн төлбөр авах зэрэг шинэ гэмт хэргийг тусгасан.⁵

Хоёр. Ялын төрлийн талаар:

- Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой⁶ холбогдуулан цаазаар авах ялын төрлийг хасч, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялын төрлийг хуулийн төсөлд тусгажээ. **Бүх насаар хорих ял цаазаар авах ялыг орлох боломжтой, илүү үр нөлөөтэй гэж олон улс хүлээн зөвшөөрч байна.**⁷ Учир нь бүх насаараа торны цаана сууж, бусдын эрхшээлд байхыг хэн ч хүсдэггүй бөгөөд энэ нь түүний зовлон гачаалын төгсгөл биш, харин эхлэл болох учраас тэр ажээ. Харин зарим хүмүүс үхлийг мөнхийн амгалан, зовлон бэрхшээлээс гарах шалгарсан арга гэж үздэг⁸. Иймд бүх насаар хорих ял цаазаар авах ялаас илүүтэй бусдад нөлөөлж, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чаддаг.

- Ялын үр нөлөө бага, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй баривчлах ялыг мөн ялын төрлөөс хасч, хуулийн төсөлд тусгасан. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуульд баривчлах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд **ганцаарчилан** эдлүүлэхээр заасан⁹ боловч санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан баривчлах ял шийтгэгдсэн 4-10 ялтан хамт байрлаж, хуульд заасан нөхцөл, журмын дагуу хэрэгжихгүй байна.

- Олон улсын туршлага, зөвлөмж, хөгжингүй зарим улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг судалж үзсэний үндсэн дээр хуулийн төсөлд **зорчих эрхийг хязгаарлах** ялын шинэ төрлийг нэмсэн. Монгол Улсын хэмжээнд 2002-2012 онд нийт 40.119 хүн хорих ял эдэлж суллагдснаас 19.000 хүн буюу 47% нь дахин гэмт хэрэг үйлджээ.¹⁰ Эндээс үзэхэд, хорих ялын үр нөлөө хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах эрүүгийн хариуцлагын зорилго хангагдахгүй байгаа нь харагдаж байна. Иймд хорих ял оногдуулах явдлыг багасгаж, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлалгүйгээр нийгэмд нь хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх боломж бүрдэнэ гэж төсөөлж байна. Зорчих эрх хязгаарлах ял нь олон улсын жишгийн адил гэмт хэрэг үйлдсэн хүнийг оршин суух газраас явах болон тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон замаар зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суугаа газраа өөрчлөх, зорчих үүргийг тодорхой хугацаагаар даалгах хэлбэрээр хэрэгжих юм.

⁵ Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. УБ., 2015

⁶ 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар соёрхон баталсан.

⁷ Дэлхийн 144 улс цаазаар авах ялыг хуулиараа эсхүл практикт халсан байна. “Death Penalty,” 2014.09.20-нд үзсэн, <http://www.amnestyusa.org/our-work/issues/death-penalty>.

⁸ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай (орч Г.Эрдэнэбат). УБ., 2009. 87 дахь тал

⁹ //Төрийн мэдээлэл. 2002. №5

¹⁰ “Давтан гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгааны тайлан. ЦЕГ, ХЗҮХ. УБ., 2012. 62 дахь тал

Харин хуулийн төсөлд тусгагдсан зорчих эрхийг хязгаарлах ял болон албадлагын арга хэмжээ, өсвөр насны хүнд оногдуулах ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх институтын бүтэц, нэгжийг шинээр зохион байгуулах, түүнийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нэн даруй шийдвэрлэх шаардлагатай. **Төрийн байгууллагын хайхрамжгүй, назгай байдал, санхүүгийн боломжгүй байдлаас шалтгаалан хуулийн хэм хэмжээ хэрэгжихгүй байх тохиолдол цөөнгүй байдаг.** Тухайлбал, УИХ-аас 2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 69.2-т *“Насанд хүрээгүй этгээд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсаны дараа засарч хүмүүжихгүй байвал шүүх уг арга хэмжээг насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно”* гэж заасан. Гэтэл төрөөс одоог хүртэл насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагыг байгуулаагүйн улмаас хуулийн заалт хэрэгжээгүй.

- Ялын төрлөөс эд **хөрөнгө хураах ялыг** хасч, албадлагын арга хэмжээний төрөлд тусгасан. Учир нь гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд ногдох эд хөрөнгийг хураах нь хүний эрхийг зөрчиж буй явдал бөгөөд харин гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг хураах албадлагын арга хэмжээ мөн.

Гурав. Албадлагын арга хэмжээний талаар:

- Хуулийн төсөлд тэнсэхийг албадлагын арга хэмжээний төрөлд оруулж, хуульд заасан үндэслэлийг хангасан тохиолдолд тухайн зүйл, хэсэгт заасан **ялыг оногдуулахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар тэнсэхээр** заажээ. Өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдсэн, хуульд заасан үндэслэл хангасан этгээдэд хорих ял оногдуулж, улмаар тодорхой хугацаагаар тэнсэн харгалздаг байсан бол хуулийн төсөлд ял оногдуулахгүйгээр тэнсэхээр тусгасан нь олон улсын жишигтэй нийцэж байна.

Шүүх тэнсэгдсэн хүнд хүлээлгэх үүргийг нэг бүрчлэн хуулийн төсөлд тусгасан. Энэ нь тэнсэгдсэн хүнийг хариуцлагажуулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, улмаар эрүүгийн хариуцлагын зорилго хангагдах боломж бүрдүүлнэ.

Дөрөв. Ял оногдуулах талаар:

- Хүүхэд гэнэн томоогүй зан, өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн агуулга, мөн чанарыг ойлгохгүй, бусдын нөлөөнд амархан автдаг зэргээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байдаг. Иймд анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг нийгмээс тусгаарлахгүй, архаг ялтнуудын хортой нөлөөнд автуулахгүй байлгах зорилгоор хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Шүүхээс 2010 онд 68, 2011 онд 63, 2012 онд 132, 2013 онд 76, 2014 онд 62 хүүхдэд энэхүү арга хэмжээг хэрэглэсэн байна.¹¹ Эндээс үзэхэд, сүүлийн 2 жилд шүүхээс хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байдал буурсан үзүүлэлттэй байна.

Хуулийн төсөлд **өсвөр насны хүнд** оногдуулах ялын төрөл, ял оногдуулах журам, түүнд хэрэглэх албадлагын арга хэмжээг тусгай бүлгээр зохицуулж өгсөн. **Ингэснээр өсвөр насны хүний бие, сэтгэл зүйн онцлогийг харгалзан насанд хүрэгчдээс ялгамжтай ял оногдуулах, аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэглэж, нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж бүрдэнэ.**

¹¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Ялын тухай сургаал) II боть. УБ., 2014. 337 дахь тал

Хуулийн төсөлд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар, шүүх ердийн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авахаар тусгасан.¹²

- Хуулийн төслийн 8 дугаар бүлэгт **“Хуулийн этгээдэд ял оногдуулах тусгай журам”-ыг** тусгасан. Сүүлийн жилүүдэд Монгол дахь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр экологийн гэмт хэргийн гаралт өсч, хүрээлэн буй орчинд их хэмжээний хохирол учруулах болсон. Энэ төрлийн гэмт хэрэгт цөөн тооны албан тушаалтан эрүүгийн хариуцлага хүлээж, хуулийн этгээд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж, байгаль орчныг сүйтгэсээр байдаг. Хуулийн төсөлд хүрээлэн буй орчны болон олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг зарим гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд торгох (торгох ялын хэмжээ иргэнд оногдуулах торгох ялын хэмжээнээс харьцангуй өндөр), тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, хасах, түүнчлэн татан буулгах ял оногдуулахаар заасан нь энэхүү практикт тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэх боломж олгоно.

- Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд гэмт хэргийг тодорхой шалгуураар 4 ангилж, шүүхээс оногдуулах ялын төрөл, хэмжээг гэмт хэргийн ангилалд нийцүүлэн “хайрцаглаж” өгсөн байдлыг өөрчилсөн. **Өөрөөр хэлбэл, шүүх ял оногдуулахдаа гэмт хэргийн ангилалыг харгалзалгүй гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирлын шинж болон бусад байдлыг харгалзан үзэхээр хуулийн төсөлд тусгав.**

- Эрүүгийн эрх зүйн онолоор санкцыг туйлын тодорхой, харьцангуй тодорхой, сонгох, заах, тодорхой бус гэсэн төрөлд хуваан судалдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн санкц харьцангуй тодорхой байгаагаас шүүхээс ял оногдуулахад бэрхшээлтэй байгаа болох нь төрийн болон төрийн бус байгууллагын хийсэн судалгааны үр дүнгээс харагддаг¹³. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 91-97, 108, 112, 126, 145.4, 146.4, 147.1, 2, 3, 150.3, 181.3 дугаар зүйлүүдэд сонгох ялгүйгээр хорих ял оногдуулахаар заасан учраас шүүх зөвхөн хорих ял хэрэглэхэд хүргэж байна. Иймд шүүхээс энэ хуулийн тусгай ангид хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд болон доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр гэмт хэргийн ангилал, шүүхээс оногдуулах ял хоорондоо уялдаагүй, хатуу хязгаарын хүрээнд гэм буруугийн шинжид тохирохгүй ял оногдуулдаг гэсэн шүүмжлэл багасч, шударгаар хэргийг шийдвэрлэхэд дөхөм болно гэж үзэж байна.

- Хуулийн төслийн 6.7-д **“Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд ял оногдуулах тусгай журам”-ыг** тусгажээ. Энэ нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэнд анхны зохицуулалт бөгөөд хүнд гэмт хэрэг үйлдсэн боловч гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, хохирлоо нөхөн төлсөн, нөхөн төлөхийг илэрхийлсэн, хохирогчтой эвлэрсэн зэргийг харгалзан шүүх тухайн зүйл, хэсэгт заасан ялын хэмжээг тодорхой хувиар багасгаж ял оногдуулахаар заасан. **Ингэснээр шүүх эрх**

¹² Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. УБ., 2015

¹³ Гэмт хэргийн ангилал ба ялын тохироо. судалгааны тайлан. ХЗҮХ. УБ., 2005. 25 дахь тал

мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажлын ачаалал буурах, хохирол нөхөн төлөлт нэмэгдэх зэрэг эерэг ач холбогдолтой.

- Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн болон гэмт хэрэг давтан үйлдэх талаар заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгасан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд гэмт хэргийг давтан үйлдсэн, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заажээ. Энэ нь нэг хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн “Non double jeopardy” зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг зохимжгүй гэж үзээд дээрх нөхцөл байдлыг хуулийн ерөнхий ангид “ял хүндрүүлэх нөхцөл байдал” гэсэн хэсэгт тусгасан.

Дүгнэлт

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан мөрдөгдөж эхлэхтэй холбоотойгоор шинээр хэд хэдэн ялын төрөл нэмэгдэж, ялын үр нөлөө бага, хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй хэд хэдэн ялын төрөл хасагдаж, зарим ялын санкцын хэмжээг багасгаж, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд хуульд зааснаас хөнгөрүүлж ял оногдуулах, өсвөр насны хүн, хуулийн этгээдэд ял оногдуулах тусгай журам, ял оногдуулахдаа гэмт хэргийг ангилалыг харгалзалгүй гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруу, учруулсан хохирлын шинжийг харгалзан үзэж ялгамжтай оногдуулах, шүүхээс энэ хуулийн тусгай ангид хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах өргөн боломжтой, хорих ялын дээд болон доод хэмжээг сунгаж, харьцангуй уян хатан байдлаар хуулийн төсөлд тусгасан зэрэг олон улсын чиг хандлагад нийцсэн, дэвшилттэй зохицуулалт бүрдүүлж чадах юм.

Монгол Улсын ялын тогтолцоо, ялын бодлогод орж буй өөрчлөлтийг нийтэд нь харвал ялын бодлого зөөлөрч, хүний суурь эрхийг баталгаажуулах, хохирогчийн эрхийг сэргээн тогтоох, шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх эрх зүйн үндсийг улам бэхжүүлж, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхах нөхцөл бүрдэхээр байна.


МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЯЛ ТЭНСЭХ ИНСТИТУЦИЙН ТУХАЙ



*А.Баасанцэрэн
ОХУ-ын Дотоод хэргийн яамны Омскийн академийн адъюнкт
цагдаагийн дэд хурандаа*

Өнөөдөр дэлхийн дийлэнх улсын ялын бодлогод өөрчлөлт орж, хорих ялаас аль болох татгалзаж, бусад төрлийн ялыг түлхүү хэрэглэх болжээ.

Улсын хэмжээний статистик мэдээнээс үзэхэд, манай улсад мөн адил хорих ялыг биечлэн эдлүүлэх явдал жил ирэх тутам багассан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2010 онд шүүхээс хорих ял оногдуулсан 7292 ялтны 2444 буюу (33.6%), 2011 онд 8210 ялтны 3084 буюу (37.5%), 2012 онд 8324 ялтны 3217 буюу (38.6%), 2013 онд 8065 ялтны 3342 буюу (41.4%), 2014 онд 8178 ялтны 3396 (41.5%) ялтанд оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзжээ. Үүнийг хүснэгтлэн үзүүлбэл:



Үүнээс үзэхэд, сүүлийн жилүүдэд хорих ялыг биечлэн эдлүүлэхгүй тэнсэж буй байдал нь нэмэгдэх хандлагатай байна.

Ял тэнсэх институц нь XIX зууны 40-өөд оны үед Английн шүүгч Бирмингама Метью Хилл анх өвчтэй ялтнуудад өвчнөө эмчлүүлэх боломж олгох үүднээс биеэр эдлэх хорих ялаас чөлөөлөх, хорих ялыг торгох ялаар солих саналыг тавьсан ба 1879-өөс 1887 оны хооронд Английн шүүхийн практикт хэрэглэж ирсэн байна¹⁴.

XIX зууны 60-аад оноос Англиас салбарлан, АНУ-д анх Массачусетс мужийн шүүх хэрэглэсэн байна. 1899 он гэхэд Америкийн ихэнхи муж, Миннесота, Иллинойс, Род-Айленд, Вермонте, Нью-Джерси, Нью-Йоркт хэрэглэж эхэлжээ. 1911 он гэхэд 41 мужиар тархан хэрэглэж байсан бол 1920 он гэхэд Хойд-Америк, Англи, Шотланд, Канад, Австрали, Шинэ Зеланд, Өмнөд-Америкийн орнуудад ял тэнсэх институцийг өргөн хэрэглэх болсон байна¹⁵.

Англиас АНУ-д салбарласан бол Европт Бельги, Франц, Германаар дамжин Оросод орж иржээ. 1894 онд Оросын эрдэмтэн А.А. Пионтковский анх “Ял тэнсэж хянан харгалзах тогтолцоо” гэсэн анхны нийтлэл гаргасанаас хойш 1900 онд ял тэнсэх асуудлыг Оросын хууль цаазын бичигт урьдчилсан байдлаар нэмэлт оруулан хэрэглэж болохыг Төрийн зөвлөлөөс баталжээ.

Оросын эрдэмтэн Н.И. Фалеева 1904 онд “Бидний цаг үед манай эрүүгийн тогтолцооны гажуудлыг засах туршилтын бүтээгдэхүүн бол ял тэнсэх явдал юм. Хэрэв хууль сахиулах арга хэрэгсэл нь төгс бус байвал түүнийг зайлшгүй засч сайжруулах шаардлагатай байдаг. Энэ дүгнэлтээс ял тэнсэх нь ялыг бие даасан төрөл болсноор орчин үеийн хорих ялын дутагдалтай талыг арилгана”¹⁶ гэж бичсэн байна.

1907 оны 1 дүгээр сарын 21-нд хуулийн төсөл боловсруулах тусгай комисс байгуулагдсан байна. Энэ комисс нь нэгдүгээрт ял тэнсэх институцийн хуулийн төсөл, хоёрдугаарт шүүхийн шинэчлэлийн хуулийн төслийг тус тус боловсруулж, улмаар 1909 оны 10-11 дүгээр сарын хооронд Бүх Оросын Төрийн Думаар батлуулсан байна.

ОХУ-д XIX зууны сүүл XX зууны эхэн үеэс ял тэнсэх асуудлыг эрдэмтэн, судлаачид шинжлэх ухааны түвшинд судалж иржээ. Тухайлбал, А.А. Пионтковский, Н.И.Фалеева, Н.С.Таганцев, И.П. Люблинский нар ял тэнсэх институцийг судалсан томоохон төлөөлөгчид мөн.

Монгол Улсад 1921 онд Ардын хувьсгал ялж, улмаар 1924 онд бүгд найрамдах засаглалыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хуулиа баталж, улмаар 1926 онд анхны шүүх цаазны бичгийг баталсан. Энэ хуулийн 8 дугаар зүйлд “Шүүх гэмт этгээдэд оногдуулсан ялаа биечлэн эдлүүлэхийг түдгэлзэн тэнсэж гурваас таван жил хүртэл хугацаагаар хянан харгалзах бөгөөд уг хянан харгалзсан хугацаанд шийтгүүлсэн этгээд түрүүчийн үйлдсэн хэргийн нэг төрлийн гэмт хэрэг үйлдээгүй бол ялыг эдлүүлэхгүй” гэж заажээ. Гэвч уг хуульд чухам ямар ялыг тэнсэж болохыг тодорхойлоогүйгээс гадна хянан харгалзах хугацаанд түрүүчийн үйлдсэн хэргээс өөр төрлийн хэрэг үйлдсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх асуудлыг тодруулан заагаагүй нь дутагдалтай байсан байна¹⁷.

Монгол Улсын тэргүүлэх эрдэмтэн, судлаачид ял тэнсэх талаар өөр өөрсдийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, нэрт эрдэмтэн Б.Содовсүрэн: “Шүүх ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн зохих зүйл, ангийг баримтлан, хорих, засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэхээр шийтгэсэн ялыг тодорхой хугацааны дотор биечлэн

¹⁴П.И.Люблинский. Журнал< Право и жизнь> Условное осуждение. г Москва 1924 г .С.5

¹⁵П.И.Люблинский.Дурьдсан зохиол. Москва.,1924., 6 дахь тал

¹⁶Н.И. Фалеева Условное осуждение (новая область его применения) г Москва 1904 г С.43.

¹⁷С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2014, 307 дахь тал

эдлүүлэхээс түдгэлзүүлэхийг тэнсэх гэнэ”¹⁸. Тэнсэх нь ял биш шүүхийн тогтоол биелүүлэх онцгой журам гэж үзсэн бол доктор /Sc.D/, профессор Г.Совд: “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг тэнсэж, тусгай хугацаагаар хянан харгалзаж хүмүүжүүлэх явдал эрүүгийн эрх зүйн зарчмын нэг бодит илрэл. Тэнсэх бол ял шийтгэлийн хүмүүжүүлэх зорилгыг оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэлгүй хэрэгжүүлж байгаа арга хэрэгсэл”¹⁹ гэж энэ институцийн хууль зүйн учир холбогдлыг өндрөөр үнэлсэн билээ.

Хуульч Т.Дэндэв: “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан хорих, засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ялыг түдгэлзэж, хянан харгалзах талаар гаргасан шүүхийн шийдвэр бол шүүгдэгчид итгэл хүлээлгэж, энэрэнгүй хандаж байгаа явдал”²⁰ гэж тэмдэглэсэн байна.

Академиц С.Нарангэрэл: Ял тэнсэх нь хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биелүүлэх онцгой журам²¹ гэж үзжээ. Харин доктор /Sc.D/, профессор С.Жанцан: “Ял тэнсэх нь тэнсэгдэж байгаа этгээдийг олон нийтээс тусгаарлах шаардлагагүй гэсэн дүгнэлтэд шүүх хүрвэл тодорхой нөхцөл тавьж итгэл хүлээлгэх замаар шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг тодорхой хугацаагаар биелүүлэхгүй түдгэлзэж байгаа хэрэг юм”²² гэжээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд ял тэнсэхтэй холбоотой

- Оногдуулсан хорих ялыг ял тэнсэх /Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйл/
- Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах /Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйл/ гэсэн 2 өөр инстицуц байгаа бөгөөд бид ял тэнсэх тухай ойлголтыг хөндөж байгаа билээ.

Улаанбаатар хотын 250 шүүгч, прокурор, мөрдөн байцаагчаас ял тэнсэх тухай хэрхэн ойлгож буй талаар судалгаа явуулахад 71 буюу 28.4% нь эрүүгийн ялын төрөл, 41 буюу 16.4% нь ялаас чөлөөлөх хэлбэр, 51 буюу 20.4% нь тэнсэх нь ял биш, 48 буюу 19.2% нь ялыг биелүүлэх онцгой журам, 29 буюу 11.6% нь ялыг түдгэлзэх хэлбэр, 23 буюу 9.2% нь ялын бус арга хэмжээ гэж тус тус хариулсан.



Дээрхээс дүгнэхэд, ял тэнсэх гэдэг нь шүүхээс хорих ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд хорих ялаас чөлөөлж буй явдал биш бөгөөд ялыг

¹⁸БНМАУ-ын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1969. 134 дэх тал

¹⁹Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс. УБ, 1973. 405 дахь тал

²⁰Т.Дэндэв. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн ялын асуудал. УБ, 1975.123 дахь тал

²¹С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2008.658 дахь тал

²²С.Жанцан Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол / ялын тухай сургаал/. УБ, 2014.311 дэх тал

хэрэгжүүлж буй нэг хэлбэр мөн. Хууль зүйн үр дагавар нь тэнсэгдсэн этгээд тодорхой хугацаанд ялтайд тооцогдохоор илэрнэ хэмээн үзэж болохоор байна.

Ял тэнсэх ойлголтын талаар практик байгууллагын ажилтнууд нэгдсэн нэг мөр ойлголтгүй байгаа нь уг хэм хэмжээг буруу хэрэглэх эсхүл хэрэглэхгүй байхад хүргэнэ. Харин ял тэнсэх асуудлыг нэг мөр ойлгож зөв хэрэглэснээр гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгэгдсэн этгээдэд засарч хүмүүжих боломж олгох, алдаагаа ухамсарлах, засах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг олон талын ач холбогдолтой бөгөөд цөөн хүн амтай Монгол Улсын тухайд хэтэрхий шоронжих сөрөг үр дагавраас сэргийлэх юм.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



НОТЛОХ АЖИЛЛАГАА ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Л.Цогтбаяр

Орхон их сургуулийн багш, докторант

- Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний үүрэг, ач холбогдол
- Шүүхийн шинжилгээний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, чиг хандлага

Түлхүүр үг: Шүүхийн шинжилгээ, хүний эрх, мөрдөн шалгах ажиллагаа, мэргэжлийн ур чадвар, нотлох ажиллагаа, хууль зүйн бодит шийдвэр.

Хүн төрөлхтөн оюун ухаан хийгээд нийгмийн амьдралын хувьд урд өмнө төсөөлж байгаагүй техник-технологи, хэрэглээний хөгжлийн шинэ эрин үед амьдарч байна.

Хөгжлийг түүчээлсэн шинэ эринтэй зэрэгцэн нийгмийн сөрөг үзэгдэл болсон гэмт хэрэг түүний бүтэц, хэлбэр, хамрах хүрээ хязгаар, хохирогч, хохирлын шинж чанар түүнчлэн гэмт хэрэг үйлдэгдсэний улмаас үүсдэг өөрчлөлт, ул мөрний хувьд ч мөн адил өөрчлөгдөн шинэ нөхцөл байдлыг бий болгож байгаа нь шинжлэх ухааны уламжлалт мэдлэг, эрх зүйн тогтолцоо, арга барил, зан үйл, харилцах харилцаанд ч нэгэн адил нөлөөлөх болсон.

Өнөөгийн нийтийн амьдрал үйл ажиллагааны үнэт зүйл нь зөвхөн хүн болсон төдийгүй хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол байгааг судлаач нар нэгэн зэрэг хүлээн зөвшөөрч эхэллээ.

Эрхийг хамгаалах энэхүү тогтолцооны зорилго, бодит шалгуур нь хүн түүнтэй хамаарал бүхий эрх ашигийг хангах, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээхээс өөр зүйлгүй гэж тодорхойлж болно.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, олон улсын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал, түншлэл, техник-технологи, эрх зүйн хөгжлийн өнөөгийн бодит байдал нь урд өмнө байгаагүйгээр эрс өөрчлөгдөж улс орны хөгжлийн хандлагыг хүний эрх, эрх чөлөөний үнэлэмжээр тодорхойлж байгаа билээ.

Үүний гол хүчин зүйлийн нэг нь хүний эрхийн асуудлыг улс орон бүхэн дотоод, гадаадхарилцааны чухал хэмжүүр болгон үнэлэмж тогтоох болсон.

Өнөө үеийн амьдрал үйл ажиллагааны бүхий л хэв маягыг илэрхийлэх хүчин зүйл нь хүний эрх учир түүнийг зөрчсөн хамгийн хүнд хэлбэр нь нэг талаас гэмт хэргийн улмаас хохирсон хүний тухайд ч хүний эрх, нөгөө талаас хохироосон хүний тухайд ч хүний эрхийн асуудал тухайн улс орны төдийгүй олон улсын асуудлыг нэг гэж тодорхойлогддог.

Хүний эрхийн асуудал 19 дүгээр зууны дунд үеэс эрчимтэй яригдан улмаар 20 дугаар зуунд хүний эрхийг хамгаалах бодит тогтолцоо Үндэстнүүдийн лиг /холбоо/ түүний залгамж Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүчин чармайлтын дүнд өнөөдөр бодит биелэлээ олжээ.

Энэхүү тогтолцооны бүрэлдэхүүнийг дараахь байдлаар тодорхойлогдоно:

Нэг. Үндэсний тогтолцоо

- Үндэсний эрх зүйн тогтолцоо

- Үндэсний бодит тогтолцоо

Хоёр. Олон улсын тогтолцоо

- Олон улсын эрх зүйн тогтолцоо

- Олон улсын бодит тогтолцоо

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн Хуулийн Хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг тунхаглан баталгаажуулсан ба хүний эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулийн эрх зүйн томоохон институт болсон билээ.

Тухайлбал Үндэсний эрх зүйн тогтолцооны тухайд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, бодлогын суурь баримт бичиг, хуульчилсан акт байх бөгөөд үүний дагуу байгуулагдсан байгууллага түүний эрх бүхий алба хаагч гэж үзнэ.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2 дугаар бүлэг 14 дүгээр зүйл “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, “...Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт “...төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”, 13 дахь хэсэгт “...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, 14 дэхь хэсэгт “...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй.

Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” 18 дахь хэсэгт “...улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно”, **18 дугаар зүйл** “...Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно”, “...Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална” гэж хүний эрхийг хангаж, хамгаалах үндсэн тогтолцоог хуульчлан баталгаажуулсан.

Үүнээс гадна Эрүүгийн хууль, ЭБШХ, ШШГТХ, ШШТХ, цагдаа, прокурор, Шүүхийн багц хууль, Хуульчийн эрх зүйн байдлын хууль, Хүний эрхийн комиссын тухай хууль зэрэг тулгуур хууль, бодлогын баримт бичгийг үндэсний хэмжээнд боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Харин олон улсын эрх зүйн тогтолцооны тухайд НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, бодлогын суурь конвенц, гэрээ, баримт бичиг, байх бөгөөд үүний дагуу байгуулагдсан байгууллага түүний эрх бүхий албан хаагч гэж үзнэ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйл “...Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой”, 2 дугаар зүйл “...Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй”, 3 дугаар зүйл “...Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 4 дүгээр зүйл “...Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно”, 5 дугаар зүйл “...Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”, 6 дугаар зүйл “...Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй”, 7 дугаар зүйл “...Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй”, 8 дугаар зүйл “...Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, 9 дүгээр зүйл “...Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, 10 дугаар зүйл “...Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”, 11 дүгээр зүйл “...Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь

хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй” гэж олон улсын түвшинд хүний эрхийн асуудлыг баталгаажуулсан.

Үүнээс гадна хүний эрхийн суурь 8 конвенцийг үндсэн баримт бичигт тооцож нэгдэн орсон улс орон бүр үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлж байдаг.

Ийнхүү хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоо, мэдлэг, ур чадвар арга барил, техник технологи урд өмнө байгаагүйгээр өөрчлөгдөж байгаа энэ цаг үед хуулийн дагуу чиг үүрэг бүхий байгууллага түүний алба хаагч, ажилтан нар мөн адил мэдлэг, ур чадвар арга барилаа хөгжүүлэх шаардлагатайг цаг үе шаардаж байгаа учир илтгэлийн сэдвийн хүрээнд:

-Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний үүрэг, ач холбогдол,

-Шүүхийн шинжилгээний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал,

-Чиг хандлагын тухай гэсэн асуудлын хүрээнд илтгэн, Та бүхэнтэй санал бодлоо солилцох байна.

1. Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа дахь шүүхийн шинжилгээний үүрэг, ач холбогдол

Өнөөдөр нийтийн амьдрал үйл ажиллагааны үнэт зүйл нь хүн, түүний эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхол гэж тодорхойлж байгаа учир аливаа гэмт хэргийн улмаас хохирсон хийгээд ямар нэгэн байдлаар холбогдсон хүний эрхийн асуудалтай холбоо бүхий нэршил, утга зүйг анхаарахгүй зөвхөн тухайн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны талаар тодорхойлох боломжгүй юм.

Иймд үйлдэгдсэн гэх гэмт хэрэг болон мөрдөн шалгах ажиллагааны оролцогч тэдний эрх, үүрэг, шүүхийн шинжилгээний нэршил, утга зүйн тухай цөөн үгээр тайлбарлах шаардлагатай.

Мөрдөгчийн үйл ажиллагааны тухайд: Хуулийн дагуу мөрдөн шалгах үүрэг хүлээсэн, энэ үүргээ биелүүлэхээр хуульд заасан тусгай эрх эдэлж байгаа мөрдөгч нь ертөнцийн бүхнийг мэдэж бодит үнэнийг тогтоогч биш зөвхөн бодит байдалтай холбоотой баримтуудыг олж цуглуулж, шинжлэн судлуулж, үнэлж дүгнэх эрхээр хангагдсан тусгай чиг үүрэг бүхий алба хаагч мөн.

Тухайлбал гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хуулиар зөвшөөрсөн тусгай арга, хэрэгсэл, үйл ажиллагаа явуулах эрх хийгээд хангамжаар хангагдсан алба хаагч.

Түүнээс биш бусдын эрхийг хууль бусаар зөрчигч, хүнлэг бусаар харьцагч биш гэдгийг сайтар ухамсарлаж ажиллахыг үндэсний болон олон улсын хууль, тогтоомжоор хуульчилсан.

Үйлдэгдсэн гэх гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа буюу ЭБШ ажиллагаа нь эрүүгийн эрх зүйг /гэмт хэргийн хууль/ хэрэглэх үйл явцын үндсэн хэлбэр гэж тодорхойлж болно.

Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны тухайд: Аливаа хэрэг, маргаантай холбоотой “эд мөрийн баримтын шинжилгээ” нь тухайн гэмт хэрэг, маргааны баримтад цугларсан эд мөрийн баримт нэг бүрийг шинжлэх ухааны салбарын тусгай мэдлэг, тусгай арга зүй, тусгай багаж хэрэгслийг ашиглан шинжлэн судлах, шалгах, үнэлэх үйл ажиллагааны нийлбэр байдлаар тодорхойлж болно.

Криминалистикийн буюу Шүүхийн шинжилгээг улс орон бүр янз бүрээр нэрлэж ирсэн түүхтэй.

Тухайлбал,

- ✓ Европ, Азийн зарим улс оронд Forensic science-Шүүхийн шинжилгээ
- ✓ АНУ зэрэг улс оронд Investigation forensic science-Цагдаагийн шинжилгээ
- ✓ Азийн нилээдгүй улс оронд Police science-Мөрдөн шалгах шинжилгээ
- ✓ ОХУ-д криминалистикийн шинжилгээ гэж нэрлэх хандлагууд ажиглагдаж байна.

Тодорхой гэмт хэргийн хувьд нотолгооны зүйл буюу нотолбол зохих асуудлуудбичгийн баримтанд цугларсанэд мөрийн баримтыг шинжлэх хүрээнд цогц байдлаар гүйцэтгэгдэхээс гадна түүний гарцаагүй эх сурвалж тус бүр нь тухайн хэрэгтхамааралтай, үнэн зөв, эргэлзээгүй, бүрэн дүүрэн,ач холбогдолтойг хуульд заасан үндэслэл, тогтоосон журмын дагуу тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэн шалгаж, хууль зүйн үнэлэж, дүгнэх өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий үйл ажиллагааг хамаарч явагдана.

Учир нь аливаа баримтын тоон ба чанарын асуудал энгийн танин мэдэхүйгээр мэдэх боломжтой ч гэсэн заавал шинжлэх ухааны салбарын тусгай мэдлэгийн ухаан, тусгай батлагдсан арга, тодорхой багаж хэрэгсэл ашиглан үнэн бодитой мэдээлэл гарган авахад чиглэгдэнэ.

Тодорхой баримтад шинжилэх ажиллагааг гүйцэтгэхэд мөрдөн шалгах ажиллагааны болон нотлох ажиллагааны өргөн мэдлэг зайлшгүй шаардлагатай байдаг.

Гэмт хэргийн эд мөрийн баримтын шинжилгээг үнэн зөв, бодитой хийхгүйгээр хэргийн байдлыг талаас бүрээс нь бүрэн бодитой тогтоох, зөв зүйлчлэх, шүүхийн мэтгэлцээнийг хууль, ёс зүйн хүрээнд мэргэжлийн ур чадвартайгаар явуулах, бодит байдалд нийцсэн үнэн зөв, тохирсон шийдвэр гарах бололцоогүй.

Эрүүгийн хэрэгт нотлох баримтын шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах дээрх ажиллагааг эрүүгийн хэргийг мөрдөх өмгөөлөх, яллах өмгөөлөх, хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх субъект бүр хуулиар олгогдсон тус тусын эрх хэмжээ, чиг үүрэг, ёс зүй, үндсэн ба тусгай зарчмуудыг чанд сахиж, бодитой хэрэгжүүлэх үүрэгтэй.

Харин ямар арга, тактик, техник хэрэгсэл ашиглан гэмт хэргийн эд мөрийн баримтын шинжилгээг бүрэн, үнэн зөв гүйцэтгэж, хууль зүйн дүгнэлт гаргаж чадсах эсэх нь тэдний шинжлэх ухааны мэдлэг, амьдрал үйл ажиллагааны туршлага, ур чадвар, хамтын ажиллагаа, сэтгэхүйн онцлог зэргээс ихээхэн хамааралтай.

Шинжлэх үйл ажиллагаа явуулахгүйгээр эцсийн шийдвэр гаргах нь нэг талдаа бусдын эрхийг хамгаалж чадахгүй зөрчиж ял завшуулна нөгөө талаас бусдыг хууль бусаар шийтгэж хүний эрхийг зөрчих гэсэн хаашаа ч зөрчлийн тойргыг үүсгэнэ.

Үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны 90 гаруй хувь, үлдсэн хувь нь мэдээллийг мэдүүлгээр авч байж л бодит үнэнд нийцсэн шударга шийдвэр гарах учиртай.

Эрх зүйн хийгээд ёс зүйн тогтолцоогоор тэргүүлэх Англи, Герман, Франц, АНУ, Япон, Солонгос, Сингапор зэрэг улс оронд гарцаагүй нотлох баримттай буюу ухаалаг техник технологийн дэвшлийн үр дүнд хялбархан нотлох боломжтой хулгайлах, дээрэмдэх, хөдөлгөөний аюулгүй байдал, зарим нэгэн хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд түүнд холбоотой хүн хуулийн эсрэг маргахгүйгаар өөрөө гэмшин гэм буруугаа бодитой тайлбарласан, энэ нь нотлогдох илт баримттай тохиолдолд удаан хугацаанд мөрдөн шалгах аас зайлсхийж илт байгаа нотлох баримтыг үндэслэн Шүүх

шийдвэрлэдэг харин маргалдах тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа буюу шүүхийн шинжилгээгээр нотлох ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалттай байна.

Манай улсад мөрдөн шалгах ажиллагааг мэдүүлгэн мэдээлэл авах буюу байцаалтын аргыг голлон хэрэглэж байгаа бөгөөд шүүхийн шинжилгээний үүрэг, ач холбогдолыг цөөн тооны гэмт хэрэг мөрдөн шалгахад тохиолдолд дам баримт цуглуулах байдлаар үнэлж байгаа нь учир дутагдалтай төдийгүй нөгөө талаар хүний эрхийн асуудал ямар байгааг илэрхийлнэ.

Эрүүдэн шүүх явдалтай тэмцэхийн тулд эрх зүйн орчинг сайн бүрдүүлэхээс гадна мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарыг криминалистикийн техник, тактик, арга арга зүйн ухааныг эзэмшүүлэх, энэ чиглэлээр дорвитой ажлыг зохион байгуулах, хүний эрхийн баталгааг хангахад криминалистикийн гүйцэтгэх үүргийн чухлыг ойлгуулах хэрэгтэй байна.

Нэгэн жишээ. Хүн төрөлхтөн өнөөгийн хөгжилд хүртэл аливаа зүйлийг танин мэдэхдээ заавал шинжлэн судлаж, шинжилгээг ямар нэгэн түвшинд гүйцэтгэж ирсэн нь ойлгомжтой. Үүний нэг нь хүн өвчиллөө гэхэд шинжилгээ хийхгүйгээр зөвхөн бусдын аман яриа, өөрийнх нь яриагаар дүгнэж, эмчлэх боломжгүй, сайн үр дүнд хүрнэ гэдэг эргэлзээтэй харин ч эсрэгээрээ ихээхэн алдагдалд орох нь ойлгомжтой, маш бидний өдөр тутам хэрэглэдэг автомашин эвдэрлээ гэхэд оношлож байж л сайн үр дүнд хүрнэ.

Гэмт хэргийг мөрдөн шалгаж, оновчтой зөв шийдвэрлэх хамгийн сайн арга нь шинжлэх ухааны тусгай мэдлэг, арга, багаж хэрэгслийг ашиглан гүйцэтгүүлэх шүүхийн шинжилгээний үр дүн байсаар атал шинжилгээнд тулгуурлахгүй гаргаж байгаа аливаа шийдвэр бүр эцэстээ том алдагдал.

Энэ нь шүүхийн шинжилгээний талаархи сургалт, түүнийг ашиглаж сурах сэтгэлгээ хоцрогдсон, ач холбогдол үр дагаврыг нь ойлгож шийдвэр гаргах чадваргүй, бусдын дамжуулсан хийсвэр мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргадаг явдалд дүгнэлт хийх цаг нэгэнт болсоныг анхаарах хэрэгтэй байна.

Хамгийн үнэн зөв баримт бол хийсвэр нөлөөллөөс татгалзсан бодит байдалтай холбогдон гарах шүүхийн шинжилгээний бодит үр дүн мөн.

Иймд болж өнгөрсөн үйл явдлын бодит үнэнийг тогтоож, бодитой шийдвэр гаргахад шүүхийн шинжилгээний үүрэг, ач холбогдол нь үнэт баталгаа болно.

2. Шүүхийн шинжилгээний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнаас хүний эрх, эрх чөлөөг хөндсөн олон шийдвэрийг гаргадаг. Эдгээр шийдвэр нь бодит байдалд нийцсэн, нотлох баримтад үндэслэсэн бол тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хүний эрхийг хуулийн дагуу хязгаарлаж байгаа зүй ёсны явдал.

Харин шийдвэр нь бодит нотлох баримтад үндэслээгүй бол хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар зөрчиж буй хэрэг болно. Иймд хууль зүйн үйл ажиллагаа хууль ёсны байхын тулд мөрдөгч, прокурор, шүүгч нарын гаргаж байгаа шийдвэр криминалистик буюу шүүхийн шинжилгээний үр дүнд буй болгосон бодит нотлогоонд үндэслэсэн байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл криминалистикийн шинжлэх ухааны мэдлэгийн үндэс нь байгаль, техник, нийгмийн бодит зүй тогтолд суурилсан байдаг тул криминалистик бодит нотолгоо гаргадаг.

Криминалистикийн шинжлэх ухаанд түшиглэн хүний эрхийг хангах нь криминалистик буюу шүүхийн шинжилгээтэй нягт холбоотой бөгөөд гэмт хэргийг шинжлэх ухааны үүднээс нотлож буй ажиллагаа гэж тодорхойлж болно.

Криминалистикийн /шүүхийн шинжилгээ/-ний үүслийн талаар:

Криминалистик /шүүхийн шинжилгээ/ нь хүн төрөлхтөний түүхтэй адил бөгөөд энэ салбар нь хүн төрөлхтөний аж байдал, амьдралын хэв шинж, сэтгэлгээтэй салшгүй холбоотой хөгжиж улмаар өнөөгийн шинжлэх ухааны шинж олсон нь 200-аад жилийн өмнө. Энэ шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийн дээд хэмжүүр гэж үзэх үндэстэй.

Манай улсын хувьд шинжийг шинжлэх ухаан их хөгжсөн, амьдрал үйл ажиллагаа нь үргэлж сэтгэлгээнд тулгуурлаж явагддаг өвөрмөц хэв шинжтэй ард иргэд билээ. Энэ нь тэр чигээрээ л шинжилгээний эх ундрага гэсэн үг. Тухайлбал, монгол хүүхэд багаасаа л оньсон тоглоом, малын гаралтай /шагай гэх мэт/ тоглоом, байгалийн гаралтай мод, чулуун тоглоомоор тоглож өсөхдөө хэрэглээ бүр нь /гэр, малын эмээл хазаар, хашаа хороо гэх мэт/ сэтгэлгээний урлаг гэдэг үүднээс монголчуудыг шинжийг шинжлэх ухаанаар тэмдэглэн билиг оюунаа хөгжүүлж, аргыг голлон амьдрах ард түмэн харин өрнөдийн ард түмэн бол аргыг тэмдэглэн оюунаа хөгжүүлж шинжийг тэмдэглэн амьдардаг гэж үзэхээр байна.

Энэ үүднээс манай иргэд нялхасаас эхлэн өтгөс буурлууд хүртэл аливаа асуудлыг шинжлэх зөн билиг, авъяас төгөлдөр шинж бүрдмэл учир юмс үзэгдлийг шинжиж, оньсогоор туршиж учи р холбогдлыг тайлж, амьдрал ахуйдаа хэрэглэсээр ирсэн ард түмэн хэдий ч шүүхийн шинжилгээ манай улсад өнөөгийн шинжлэх ухаан шинжээр хөгжиж эхэлсэн нь 1924-1928 он гэх боловч эрх зүйн зохицуулалтын хувьд 2009 он хүртэл хуулиар зохицуулаагүй салбарын /ДЯЯ, НАХЯ гэх мэт/ сайдын тушаалаар зохицуулж ирсэн нь ихээхэн сул талтай.

Харин 2009 онд Монгол Улсын Их Хурал "Шүүхийн шинжилгээний тухай" хуулийг баталсан нь эрх зүйн тогтолцооны хувьд шинэ эргэлт бий болсон. Гэвч энэ хууль шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, шинжээчийн эрх зүйн байдал, заримтөрлийн шинжилгээний онцлогтой холбоотой харилцааг зохицуулж байгаа болохоос шүүхийн шинжилгээ гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулаагүй учир үйл ажиллагааны хууль үгүйлэгдэж байна.

Ийнхүү хуулийн нарийн зохицуулалтгүй байсан нь гэм бурууг хуулийн дагуу шүүхээс тогтоох бус хэн нэгэн хүний хүсэл зоригын асуудал болж хүний эрх зөрчих, 1937 оны хэлмэгдүүлэлт болж байсан байх магадлалтай.

Үүний тод жишээ нь Шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутай тооцож болохгүй гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмын эсрэг нэг зарчим бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийн гэм буруугаа өөрөө хүлээсэн бол хамгийн нотолгооны үнэмлэхүй дээд хэлбэр, үнэт нотлох баримт мөн гэсэн үзлийг хийсвэрээр бий болгож 1930-1950 аад сүүл үе хүртэл ЗСБНХУ-ын хууль хяналтын байгууллага, улмаар гадаад хэргийн яамыг толгойлж байсан Андрей Януарьевич Вышинский гэгч социалист гэгдэж байсан улс орнуудыг нөмөрсөн аймшигт хэлмэгдүүлэн яргалах үйл ажиллагааны тулгуур баримт бичгийг боловсруулан, гардан гүйцэтгэсэн.

Иймд хүний эрх, эрх чөлөөг дээдлэсэн өнөөгийн хүмүүнлэг нийгэмд гэмт хэргийг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, аргагүй байдалд оруулж хэрэг хүлээлгэж хэргийг шийдэх биш харин гэмтний үлдээсэн мөр, үйл

ажиллагааны үр дүнд бий болсон өөрчлөлт бүрээр нь буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох” нь хүмүүнлэг ёсны илэрхийлэл.

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг тогтоохын тулд гэмтний үлдээсэн мөрөөр нотлох нь ялыг шударгаар оногдуулах, эсвэл гэм буруугүй этгээдийг хилсээр шийтгэхээс урьдчилан сэргийлж чадна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газарт гэмт үйлдлийн мөр, ямар нэгэн өөрчлөлт үүсэх нь зайлшгүй гэдгийг хүний эрхийг дээдэлдэг олон орны криминалистууд санал нэгтэй хүлээн зөвшөөрч байгаа учир хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагаанд ихээхэн анхаардаг бөгөөд сэжигтэн этгээдийн гэмт үйлдлийн мөр илрээгүй бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактад заасан үзэл баримтлалын дагуу түүнд ял оногдуулахгүй байх зарчим үйлчилдэг байна.

Мөрдөн шалгах тодорхой ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотой, ач холбогдол бүхий баримтуудыг 2-оос доошгүй гэрчийг оролцуулан тусгай арга, хэрэгсэлээр бэхжүүлэн авч, тодорхой шаардлага хангасан нөхцөлд савлан шинжилгээнд хүргүүлэх эрх зүйн зохицуулалт өнөөгийн ЭБШХуульд хуульчилсан ч, өнөөгийн амьдрал үйл ажиллагааны явцад огт хэрэгжихгүй байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо батлагдаж, 1987 оны оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон гишүүн бүх улс орон даган мөрдөж байгаа билээ.

ОУ-ын Эмнести интернэшнл байгууллагаас конвенцийн заалтыг хэрэгжүүлэх зорилготойгоор улс орнуудад судалгаа явуулж, тусгай хөтөлбөр батлан мөрдүүлж байгаа ба 12 заалтад хөтөлбөрийн удиртгал хэсэгт “эрүү шүүлт нь бидний дунд оршсоор, дэлхий даяар түүнийг хэрэглэсээр байна.

Үүнд Олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллагын арга туршлага, хууль эрх зүйн хамгаалалт ч дутаж байна”, /Эмнести интернэшнл байгууллагаас гаргасан Эрүү шүүлтээс сэргийлэх 12 заалтад хөтөлбөр/ 2013 онд нийт 44 улс оронд эрүүдэн шүүлтийн нөхцөл байдлыг судалгааны үр дүнд Азид эрүүдэн шүүлт харьцангуй их байна гэж дурьдсан нь манай улсад ч туйлын хамааралтай асуудал.

Ийнхүү сүүлийн үед хүний эрхийн асуудал нэг улсын асуудал бус нийт хүн төрөлхтний асуудал гэж олон улсын хэмжээнд үзэж улс орны сургалт, эдийн засаг, хүмүүнлэгийн чиглэлээр хандах хандлагад нөлөөлсөөр байна.

“Манайд хорих, цагдах явдал хэт хавтгайрсан, хэрэг хүлээлгэх гол хэрэгсэл болсон ба энэ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын «Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй» гэсэн заалтыг шууд, илтээр зөрчиж байгаа харуулж байна”/“Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтын эмхтгэл., УБ., 2008., 61 дэх тал/

“Манай улсын өнөөгийн практикт тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт цуглуулахгүйгээр сэжигтнийг яаран баривчилж, цагдан хорьж, өөрийг нь байцааж хэргийг нь хүлээлгэдэг хуучирсан арга барил бүрэн арилаагүй байна” гэж дурьджээ.”/“Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтын эмхтгэл., УБ., 2008., 61 дэх тал/

Түүнчлэн 2010 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Швейцарын Женев хотод болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит 9 дүгээр хуралдаанд Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи үндэсний илтгэл, ХЭҮК болон Монголын ТББ-уудын

форумын мэдээллүүдийг хэлэлцүүлэх үеэр Их Британий төлөөлөгч “Монгол Улс Олон Улсын гэрээ, конвенийн заалтыг дотоодын хууль тогтоомжиндоо ягштал тусгаснаар эрүү шүүлттэй бүрэн төгс тэмцэж чадахгүй байна. Тодорхой бодит ажил зохиож хэрэгжүүлэх шаардлагатай” гэж хэлсэн.

Судлаач Б.Жаргалсайханы 2008 оны 2 дугаар сард ШШҮТ-ийн криминалистикийн хэлтэст ирүүлсэн 388 экспертизийн материалд судалгаа хийж үзэхэд нотолгооны шаардлага ханган савлаж битүүмжилсэн объект огт байхгүй, 75 объектыг буюу 19.3 %-ийг зүгээр л цаасанд боож ирүүлсэн, үлдсэн 80 орчим хувийг буюу 313 объектыг задгайгаар ирүүлжээ.

Үүнээс үзвэл учралын газрын үзлэгээр илрүүлсэн бүх нутлагааны дийлэнхийг савлаагүй байна. Хэн, хаанаас, хэзээ, хэрхэн илрүүлж, бэхжүүлж, битүүмжилснийг батлаж чадахгүй, задгай объектод экспертиз явуулан гэм бурууг тогтоож, эсвэл үгүйсгэж байгаа нь хүний эрх, эрх чөлөө, шударга ардчилсан ёсыг дээдэлсэн манай хуулинд байж огт болшгүй зүйл гэж дурьдсан байна.

Хүний эрхийг зөрчиж байгаа дотоод, гадаад нөхцөл байдал нь зөвхөн хүнтэй холбоотой болохоос биш байгаль цаг уур, бүсийн онцлогтой ямар ч холбоогүй учир шүүхийн шинжилгээний байгууллага талаар баримтлаж байгаа бодлогыг авч үзэх хэрэгтэй.

Нэг. Шүүхийн шинжилгээний салбарын эрх зүйн тогтолцоо

Хоёр. Салбарын мэргэжилтэн нарыг бэлтгэж байгаа тогтолцооны хүрээнд.

Салбарын ерөнхий хууль 2009 онд батлагдсан хэдий ч үйл ажиллагааны эрх зүйн тогтолцоо огт бүрдээгүй байна тухайлбал үхлийн шалтгаан, гэмтлийн зэрэг тогтоох, нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ явуулах зэрэг хамтарсан тушаал, цөөн тооны зааврын хүрээнд л эрх зүйн зохицуулалттай байна гэж тодорхойлогдоно.

Энэ эрх зүйн зохицуулалтын байдал нь өнөөгийн цаг үед таарахгүй байхаас гадна, дотоод бүтэц, хэрэглэж байгаа техник хангамж, арга-зүй арга барил зэрэг цаашдын хөгжлийн хандлагад ч тохирохгүй эрх зүйн ядуу зохицуулалттай байгаа нь харамсалтай байна.

Энэ салбарын мэргэжилтэн бэлтгэж байгаа сургалтын тогтолцооны талаар:

Улам бүр иргэншиж, улам бүр даяаршиж буй нийгэмд мэдлэгтэй, чадварын үзүүлэлтээс гадна “иргэншсэн, хүнлэг” гэсэн шалгуур үзүүлэлт хэрэглэх боллоо.

Ингэхэд хөгжил дэвшлийг сайн боловсрол эзэмшсэн ШУ”ны мэдлэгтэй, иргэнлэг, хүнлэг хүн л манлайлахаас биш эрдэм сурсан нэр зүүсэн атлаа шуналтай, догшин ширүүн, бусдыгаа үл тоодог, хүндэлдэггүй, амиа хичээсэн хүн огтоос хэрэггүй байж болошгүй.

Өнөөгийн дэлхий нийтийн сэтгэлгээний чиг хандлага тийм болж байна. Монголын боловсролын тогтолцооны шинэчлэл үүнийг баримжаалах хэрэгтэй мэт ойлгогдоно.

Өнөөдөр мэргэжилтэн бэлтгэж байгаа үндэсний тогтолцоо чамлахааргүй байгаа хэдий ч эрх зүйн зохицуулалтын тухайд Боловсролын тухай хууль 2002.05.03, Дээд боловсролын тухай хууль 2002.05.03, ШУТех хууль 2006.12.28, Монгол Улсын Их Хурлаас “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” 1995, 2008 оны бодлогын баримт бичиг, Засгийн газраас "Боловсрол" Үндэсний хөтөлбөр (2010-2021 он) 2010.02.03 хууль, бодлогын суурь тогтолцоо байгаа боловч өөр хоорондын уялдаа байхгүй, эрэлт нийлүүлэлтийн тэгш харьцаа алдагдсан, ихэнх заалт нь тунхагын шинжтэй байна.

Үүний нэг нотолгоо нь Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007.10.10-ны 36 дугаар тогтоолоор MNS5323-39:2007 их, дээд сургуулийн сургалтын стандарт батлагдан 2008.09.01-нээс хэрэгжихдээ хуулийн сургуульд Криминалистик, Нотолгооны онол зэрэг хамгийн чухал судлагдахууныг хассан нь боловсролын салбарт хандаж байгаа гамшиг гэж хэлж болохоор байна.

Уг нь энэ хоёр судлагдахуун нь хууль сахиулах албаны хамгийн чухал чиглэл бөгөөд эдгээр байхгүй бол ямар нэгэн үйл ажиллагааг явуулахад хүндрэл учирхаас гадна авто машинаар бол моторгүй кабин л гэсэн үг, энэ чиглэлийн ухааныг үйл ажиллагаандаа цаг тутам хэрэглэж, харилцан хөгжиж байх жамтай чиглэл.

Учир нь гэмт хэрэг, зөрчил, маргааны бүтэц, шинж, харилцан хамаарал зэрэг маш олон үзүүлэлт эрс өөрчлөгдсөн өнөө үед уламжлалт гэх хоцрогдсон арга барилаар ажиллах ямар ч боломжгүй.

Гэвч хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 13 сургуулийн 10 сургуульд энэ 2 салбарын ухааныг заавал сургах горимоор 5, сонгох горимоор 5 сургуульд 1-3 багц цагаар сургаж байгаа нь аврал хайсан цэцэрхэл л болж байна.

Эдгээр сургуулиудын дундаас ХСИС-ийн үе үеийн удирдлагууд, эрдэмтэн багш, судлаач нарын хүчин чармайлтаар арга буюу хэд хэдэн шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Тухайлбал: ЦЕГ-ын даргын 2008.11.17-ны өдрийн 568 тоот тушаалаар ЭБШ эрх зүй ба Криминалистикийн тэнхим болгон өргөтгөж, шүүхийн шинжилгээний тэнхимийг тусад нь байгуулжээ.

Засгийн газрын 2011 оны 229, 243 тоот тогтоолоор Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг татан буулгаж, Хууль зүй, Дотоод хэргийн Яамны харъяанд Дотоод хэргийн их Сургуулийг байгуулснаар Цагдаагийн сургуулийн Криминалистикийн тэнхим байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаад Хууль сахиулах их сургууль болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Цагдаагийн сургуулийн Криминалистикийн тактикийн тэнхимтэй ажиллах болсон.

Мөн Орхон их сургуулийн Хууль зүйн сургуульд 2008 оны 12 дугаар сард Криминалистикийн сургалтын танхим байгуулан ажиллаж байгаагаас сургалтын тогтолцоо бүрдүүлсэн сургууль ховор байгаа нь бодлогын алдаа гэж харамсаж байна.

Ийм нөхцөл байдалтай байхад хууль сахиулагч нарыг гэмт хэргийг шуурхай илрүүл, нотолгоо, шинжилгээ, хүний эрхийг хангах хэрэгтэй гэх мэт зүйл ярих нь харамсалтай зүйл юм.

Эрх зүйн хийгээд хүний нөөцийг бэлтгэн сургаж байгаа эрх зүй, бодит тогтолцоо нь нэгдмэл бодлогогүй хөөс байдалтай байгаа нь энэ салбарын хөгжилд ихээхэн саад болж байгаа тулгамдсан хүчин зүйл болох нь тодорхой.

3. Чиг хандлага

Хууль сахиулагчид, хуульчид криминалистик /шүүхийн шинжилгээг/ гэдгийг зөвхөн “криминалистикийн шинжилгээ” гэж ойлгож тусгай зүйл мэт төсөөлдөг нь энэ шинжлэх ухааны мэдлэгийн хийгээд үйл ажиллагааны ач холбогдлыг бууруулна.

Криминалистикийн тухай цөөнгүй тодорхойлолт байдаг тухайлбал: “Үйлдэгдсэн гэмт хэрэг, маргаантай холбоотой юмс үзэгдэл, өөрчлөлт түүний зүй тогтлыг судлаж, түүнд үндэслэн гэмт хэргийг мөрдөж шалгах, нотлох баримт гарган авах аргачлалыг боловсруулдаг шинжлэх ухаан” гэж болно. Энэ үүднээсээ криминалистикийн ШУ нь

хүний эрхийг бодитойгоор хангах, хамгаалахын тулд бодит амьдралын шаардлагаар үүссэн ухаан гэж ойлгож болно.

Шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарын зайлшгүй эзэмшсэн байх ёстой мэдлэгийн нэгэнд криминалистикийн шинжлэх ухааны мэдлэг зүй ёсоор багтана. Учир нь криминалистикийн ШУ-ны боловсруулсан зөвлөмж, аргачлалыг ашиглахгүйгээр гэмт хэргийг мөрдөж нотлох гэсэн ойлголт байхгүй.

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн тулгуур баримт бичигт баталгаажуулсанаар хууль сахиулагчийн үйл ажиллагаа хууль ёсны байхын тулд мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нарын гаргаж байгаа шийдвэр криминалистикийн шинжлэх ухаанаар гарган авсан бодит нотолгоонд үндэслэсэн байхыгцаг үе шаардаж байна.

Өнөөгийн хүмүүнлэг нийгмийн цаг үед хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь туйлын чухал болсон учир үйлдэгдсэн гэх гэмт хэргийгмөрдөн шалгаж, нотлохдоо байцаах, хорих зэрэг хоцрогдсонхэрцгий аргаар сэжигтэн, яллагдагчийг айлгах зэрэг арга барилаас зайлсхийж гэмт хэрэг үйлдэгдсэний улмаас үүссэн өөрчлөлтийг шинжлэх ухааны үүднээс нотлохыг цаг үе шаардаж байна ингэх ч ёстой.

Өнөөдөр Монгол Улсад хүний эрхийг хангах механизмд криминалистикийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн нэн чухал хэрэгцээтэй байгааг хүн бүхэн ойлгох цаг болсон.

Иймд хүний эрхийг хангах, хамгаалах өргөн хүрээний үйл ажиллагаанд криминалистикийн шинжлэх ухааны ач холбогдол, чиг үүргийг ойлгуулах, таниулах, цаашлаад мөрдөгч, шүүх, прокурор, өмгөөллийн төдийгүй хууль сахиулах /татвар, гааль, иэргэжлийн хяналт, онцгой байдлын, байгал орчны хяналт гэх мэт/ байгууллага түүний алба хаагчдын үйл ажиллагаанд илүүтэйгээр нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Сүүлийн үед хууль зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиудад криминалистикийн ШУ-ны чиглэлийн сургалт хангалтгүй байгаа нь үе үеийн шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, шинжээч нар хүний эрхийг хангах, хамгаалах үйлдэгдсэн гэмт хэргийг нотлох ажиллагаандаа шүүхийн шинжилгээ /криминалистик/ үндсэн чиг үүрэг, ач холбогдол зэргийг ойлгож анхаарахгүй байгаа нь илт мэдрэгдэж байна.

Тухайлбал: гэмт хэрэг үйлдэгдсэн газар явуулах үзлэгийн ажиллагааны стандарт мөрдөлгөө байхгүй, шинжилгээ хийхэд хэрэглэх хэмжих хэрэгслийг стандарт, хэмжилийн этолон баталгаажуулалт байхгүй, хангамж байхгүй байна. Энэ нь орчин үеийн үаардлагын хэмжээнд хүрэхгүй өдөр өдрөөр хоцрох хандлагатай байна.

Энэ бодит нөхцөл байдал нь цаашлаад тархийг сэтгэхгүй болгох, залхуу болгох, ШУ-наас зугтаадаг, хүчирхийлэгч болгож улмаар хүний эрхийг зөрчил рүү түлхэх шалтгаан болно. Үндсэндээ өмгөөлөгч нар мэргэжлийн ур чадвар гарган өмгөөлөх сэтгэлгүй байгаа нь ч үүнтэй холбоотой агаад зөвхөн мөрдөн байцаагч, сэжигтэн, хохирогч, прокурор, шүүгч нарын хооронд зуучлагч хийж байгаа нь нууц биш.

Эдгээр оролцогч нар криминалистикийн ШУ-ны талаар өргөн мэдлэгтэй байдаг бол хууль өмгөөлөл, зүйн туслалцааны үйл ажиллагаа сэтгэл зүйн хувьд жинхэнэ утгаар нь төгөлдөржинө. Эрх зүйн хөгжилөөр давуу зарим орнуудад криминалистикийн өмгөөлөл илүү өндөр хөгжсөн байдаг.

Тухайлбал АНУ-д криминалистикийн шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг хууль зүйн товчоод үйл ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрсөн байх жишээтэй.

Ингэж хэвшиж чадах аваасгэм бурууг бодитоор нотлон, ялыг шударгаар ногдуулж, гэм буруугүй хүнийг шийтгэхээс урьдчилан сэргийлж үнэн зөвөөр ажиллаж, амьдрах болно. Ер нь үнэт баялаг болсон хүний олон эрхийг бүдүүлгээр зөрчдөг эрүү шүүлтийн

үндсэн болсон байцаах, хорих, залхаах, тарчлаах, айлгах, түгшээх гэсэн ойлголтыг мөрдөгч, шүүгч, прокурор нарын сэтгэхүйгээс арилгах цаг нэгэнт болсон.

ДҮГНЭЛТ

Өнөөгийн хүн төрөлхтний хэв шинж хурдатай өөрчлөгдөж дэлхийн даяаршил бодит үйл явц болсон тул аливаа хүн бүрийн эрх, язгуур эрх ашгийг хангах, хамгаалахад улс орон бүр онцгой анхаарал хандуулж олон улсын, бүс нутгийн, үндэсний тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Энэ цаг үед гэмт хэрэг, маргаан уламжлалт шинжтэй байхаас гадна бүтэц шинж, хамаарах хүрээ нь өөрчлөгдөж олон улс орон дамнасан нөхцөл байдалд үйлдэгдэх боллоо.

Энэ нөхцөлд гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүй, тогтолцоо, арга барил, техник хэрэгслээ өөрчлөн тэмцэх нь гарцаагүй, хэрэв ийм алхам хийж чадахгүй бол уламжлалт аргаараа эрүүдэн шүүж, бусдыг хууль бусаар шийтгэж, хэн нэгэнд чл завшуулсаар байх болно.

Иймд хууль сахиулах нийт байгууллага түүний алба хаагч нар үүсэн бий болсон бодит нөхцөл байдлын танин мэдэх, нотлох ажиллагаа явуулж бодит баримт гарган авах зорилгын хүрээнд КШУ-ны мэдлэг, арга арга зүй, техник хэрэгсэл, тусгай тактикийн мэдлэгийг заавал эзэмшиж улмаар өөрийн үйл ажиллагаандаа ашиглаж байх шаардлагатай болсоныг өнөө цаг үе шаардаж байна.

Манай улсад үндэсний эрх зүй хийгээд бодит тогтолцоо хэдийгээр тодорхой хэмжээнд цөөн тооны хууль, байгууллага, алба хаагч нар байгаа боловч орчинх үеийн шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Олон улсын эрх зүйн хийгээд бодит тогтолцоо хангалттай бүрдсэн байгаад бодит дүгнэлт хийж тогтвортой хөгжих тулгуур бодлого, эрх зүйн тогтолцоо, техник хангамж төдийгүй сургалтын орчин шаардлагатай байна гэж дүгнэлтэнд хүрээ.

Дээрхи бодит нөхцөл байдлаас дүгнэн дараах саналыг дэвшүүлж байна.

- Криминалистикийн шинжлэх ухаан, шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцооны “нэршил” “томъёолол”-ын талаар нэгдсэн ойлголтой болох ажлыг эрдэмтэн, судлаач нарын дунд яаралтай зохион явуулж нэгдсэн дүгнэлт гаргах,
- Шүүхийн шинжилгээний талаар баримтлах бодлогын баримт бичиг батлуулан мөрдүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах,
- Үндэсний эрх зүйн тогтолцоог олон улсын эрх зүйн хандлагад нэгдмэл байдлаар төсөл боловсруулан батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах,
- Байгууллагын тогтолцоо, бүтэц, техник хангамж, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх тогтолцоог бүрдүүлэх /үйл ажиллагаа эрх зүйн дагуу бүрдүүлэхдээ энэ талаархи дэлхийн чиг хандлагад хандуулах/
- Хүний нөөцийн талаар тавигдах шаардлага, сургалтын тогтолцоонд өөрчлөлт оруулан батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах,
- Сургалтын орчныг их бүрэн бүрдүүлэх тогтолцоог бий болгох /үндсэн ном сурах бичиг, гарын авлага, техник хангамж, сургалтын бичлэгүүд/
- Сургуулиуд болон хүрээлэнгүүдийг түшиглэн ажлын байрны дараах сургалтын төвүүдийг байгуулах тогтолцоог бүрдүүлэх,
- Хууль сахиулах албаны хүний нөөцийг бэлтгэх сургалтын тогтолцооноос гадна ажлын байрны дараах сургалт /алба хаагч нар жил бүр багц цагийн сургалтанд хамрагдаж байх/-ын эрх зүйн тогтолцоог яаралтай бүрдүүлэх гэсэн саналтай.

Ном зүй

Хууль, эрх зүй

- Монгол Улсын Үндсэн хууль.,УБ.,1992.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010.48 дугаар тогтоолын хавсралт,
- Боловсролын тухай хууль .,УБ.,2002.05.03
- Дээд боловсролын тухай хууль .,УБ.,2002.05.03,
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль .,УБ.,2006.12.28,
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль .,УБ.,2001.12.27,
- Эрүүгийн хууль .,УБ.,2002.01.03,
- Эрүүгийн байцаан шийтгэх хууль .,УБ.,2002.01.03,
- Цагдаагийн албаны хууль .,УБ.,2013.07.05,
- Тагнуулын байгууллагын тухай хуулийн .,УБ.,1999.07.08,
- Төрийн нууцын тухай хууль .,УБ.,1995.04.18,
- Байгууллагын нууцын тухай хууль .,УБ.,1995.05.16,
- Хувь хүний нууцын тухай хууль .,УБ.,1995.04.21,
- Монгол Улсын Их Хурлаас “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” 1995, 2008 оны бодлогын баримт бичиг,
- Харилцаа холбооны тухай хуулийн .,УБ.,2001.10.18,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль .,УБ.,2011.06.16,
- Шүүгчийн эрх зүйн байдлын .,УБ.,2012.03.07
- Шүүхийн захиргааны тухай .,УБ.,2012.05.22
- Прокурорын байгууллагын тухай .,УБ.,2002.07.04
- Шүүхийн шинжилгээний тухай .,УБ.,2009.12.3,
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал .,УБ.,1946.12.10,
- “Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтын эмхтгэл., УБ., 2008.

Интернет орчин, сайт

- <http://www.medee.mn>
- www.news.mn
- Criminology.mn
- www.ps.ru.ru
- Alex Filges, Die gemeinsame Ausbildung von Richtern und Rechtsanwälten Wandel der Zeit, Koeln Muenchen 2009,
- <http://www.justiz.nrw.de>
- <http://moj.mn>
- www.un.org/webcast.

ОСОБЕННОСТИ ХРАНЕНИЯ ИМУЩЕСТВА, НА КОТОРОЕ НАЛОЖЕН АРЕСТ ПО УПК РФ И МОНГОЛИИ



*Жалбуу Ганбатор. Адъюнкт кафедры уголовного процесса
Омской академии МВД России*

Конституции РФ и Монголии относят к числу признаваемых и защищаемых государством основных прав человека и гражданина – право на свободное использование своего имущества для любой не запрещенной законом деятельности и право частной собственности – иметь имущество в собственности, владеть, пользоваться и распоряжаться единолично либо совместно с другими лицами. При этом никто не может быть лишен своего имущества иначе, как по решению суда (ч. 3 ст. 35 Конституции РФ²³), права собственника могут быть ограничены лишь на основании, указанном в законе (ч. 3 ст. 5, п. 3 ч. 1 ст. 16 Конституции Монголии²⁴).

Как указал Конституционный Суд РФ, конституционное право частной собственности может быть ограничено законом при обязательном соблюдении принципов необходимости, пропорциональности и соразмерности²⁵.

Необходимостью ареста имущества как вида ограничения права собственности при осуществлении уголовного судопроизводства, обусловливается предоставление в РФ – суду (в Монголии – прокурору) полномочия разрешать по ходатайству следователя или дознавателя вопрос о наложении ареста на имущество на период предварительного расследования и судебного разбирательства по уголовному делу.

²³ Конституция Российской Федерации (принята на всенародном голосовании 12 декабря 1993 г.) (с учетом поправок, внесенных Законом РФ о поправке к Конституции РФ от 21 июля 2014 г. N 11-ФКЗ) // Собрание законодательства Российской Федерации от 4 августа 2014 г. N 31 ст. 4398.

²⁴ Конституция Монголии (принята 13 января 1992 г.) [Электронный ресурс]. Режим доступа: <http://worldconstitutions.ru/?p=33>

²⁵ Постановление Конституционного Суда РФ от 31 января 2011 г. N 1-П "По делу о проверке конституционности положений частей первой, третьей и девятой статьи 115, пункта 2 части первой статьи 208 Уголовно-процессуального кодекса Российской Федерации и абзаца девятого пункта 1 статьи 126 Федерального закона "О несостоятельности (банкротстве)" в связи с жалобами закрытого акционерного общества "Недвижимость-М", общества с ограниченной ответственностью "Соломатинское хлебоприемное предприятие" и гражданки Л.И. Костаревой" // Собрание законодательства Российской Федерации от 7 февраля 2011 г. N 6 ст. 897.

К понятию «имущество» относятся как вещные права, так и права требования. К числу объектов гражданских прав ст. 128 ГК РФ²⁶ относит вещи, (наличные деньги и документарные ценные бумаги), иное имущество (безналичные денежные средства). Безналичные денежные средства – обязательственное требование к кредитной организации, в которой открыт данный счет, на определенную сумму.

Права потерпевших от злоупотреблений властью и иных преступлений охраняются законом одинаково как в РФ, так и в Монголии, о чем сказано в конституциях обоих государств (ст. 52 Конституции РФ, ст. 16 Конституции Монголии). Вводимые в порядке реализации конституционного предписания меры, которые направлены на защиту имущественных прав граждан, имеют характер ограничений в отношении по владения, пользования и распоряжения имуществом, которое явилось предметом преступного посягательства. Поэтому такие меры включают в том числе такую меру превентивного характера как наложение ареста на денежные средства в рамках уголовного процесса, в том числе денежные средства, похищенные со счета лица, признанного потерпевшим по уголовному делу²⁷.

В ст. 134 УПК Монголии²⁸ наложение ареста на имущество выступает в качестве отдельного следственного действия. В указанной норме предусмотрен порядок исполнения решения о наложении ареста на имущество и хранения арестованного имущества.

Так, согласно ст. 134.6 Уголовно-процессуального закона Монголии, арестованная собственность передается в соответствии с постановлением дознавателя или следователя обладателю собственности или взрослому члену его/ее семьи или другому приемлемому лицу для хранения, такому лицу объясняются его обязанности по хранению собственности в сохранности. В случае необходимости, арестованная собственность может быть временно изъята (ст. 134.7).

Аналогичные нормы содержатся в УПК РФ²⁹. Так, согласно ч. 6 ст. 115 УПК РФ имущество, на которое наложен арест, может быть:

- 1) изъято;
- 2) передано на хранение собственнику или владельцу этого имущества;
- 3) передано на хранение иному лицу

По УПК РФ изъятие или передача на хранение указанным лицам производится по усмотрению лица, производившего арест, которые должны быть предупреждены об ответственности за сохранность имущества, о чем делается соответствующая запись в протоколе. Как следует из статьи 115 УПК РФ, наложение в рамках производства по уголовному делу ареста на имущество состоит в запрете, адресованном собственнику или владельцу имущества, распоряжаться и в необходимых случаях пользоваться им, а также в изъятии имущества и передаче его на хранение.

²⁶ Гражданский кодекс Российской Федерации (часть вторая) от 26 января 1996 г. N 14-ФЗ // Собрание законодательства Российской Федерации от 29 января 1996 г. N 5 ст. 410.

²⁷ Постановление Конституционного Суда РФ от 10 декабря 2014 г. N 31-П "По делу о проверке конституционности частей шестой и седьмой статьи 115 Уголовно-процессуального кодекса Российской Федерации в связи с жалобой закрытого акционерного общества "Глория" // Собрание законодательства Российской Федерации от 22 декабря 2014 г. N 51 ст. 7528.

²⁸ Уголовно-процессуальный закон Монголии [Электронный ресурс]. Режим доступа: <http://law.edu.ru>.

²⁹ Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18 декабря 2001 г. N 174-ФЗ (ред. от 8 июня 2015 г. N 140-ФЗ) // Собрание законодательства Российской Федерации от 24 декабря 2001 г. N 52 (часть I) ст. 4921.

Как видно из приведенных норм УПК двух государств, в Монголии общим правилом является передача арестованного имущества на хранение обладателю собственности или взрослому члену семьи или другому приемлемому лицу и только в исключительных случаях (как сказано в УПК Монголии – «в случае необходимости») производится временное изъятие арестованного имущества. По УПК РФ изъятие имущества и, соответственно, передача изъятых имущества на хранение в специализированную организацию, причислено к первоочередной мере, затем следуют передача на хранение собственнику или владельцу имущества или иному лицу.

В Монголии, если хранение арестованной собственности в целостности и сохранности невозможно в соответствии со ст. 134.6 УПК, орган дознания или следствия несут ответственность за такую собственность.

Только сам следователь определяет судьбу арестованного имущества – либо изымает его, либо передает на хранение. На практике в большинстве случаев описанное имущество оставляется по месту его нахождения, с передачей на хранение самому владельцу, т. е. обвиняемому, либо его родным и близким. Естественно, что при такой ситуации опасность утраты описанного имущества возрастает³⁰. Причем эти факты достаточно распространены, так как в законе нет запрета о передаче описанного имущества на хранение самому обвиняемому, его родным, близким, т. е. заинтересованным лицам³¹. Здесь нужны соответствующие законодательные изменения.

В регулировании порядка хранения арестованного имущества – как в РФ, так и в Монголии – велико значение подзаконных нормативных правовых актов, поскольку нормами УПК детально данные вопросы не урегулированы. Например, в РФ соответствующие разъяснения были даны в подготовленном управлением методического обеспечения совместно с НИИ проблем укрепления законности и правопорядка при Генеральной прокуратуре Российской Федерации Методических рекомендациях (письмо Генеральной прокуратуры РФ от 30 марта 2004 г., N 36-12-04)³².

В указанных Методических рекомендациях указано, что по усмотрению следователя арестованное имущество при его изъятии может храниться при уголовном деле – аналогично хранению вещественных доказательств, либо передано на хранение собственнику этого имущества, его родственнику или иному лицу (например, местной администрации представителю жилищно-эксплуатационной организации).

Следователь принимает меры, необходимые к сохранению имущества, подвергнутого аресту и перечисленному в описи. При необходимости арестованные предметы могут быть опечатаны, о чем делается отметка в протоколе. Место, где будет храниться арестованное имущество также должно быть указано в протоколе. Лица, которым арестованное имущество передано на хранение, вручается копия протокола, они должны быть предупреждены об уголовной ответственности по ст. 312 УК РФ за незаконные

³⁰ Колоколов Н.А. Типичное нарушение закона при наложении ареста на имущество // Уголовный процесс. - 2012. - № 10. - С. 56-57.

³¹ Ханов Т.А. Некоторые проблемы, связанные с наложением ареста на имущество, находящегося у других лиц // Уголовный закон: проблемы теоретического моделирования и правоприменения материалы Международной научно-практической конференции: Сборник. – Омск, 2008. - С. 61-64.

³² Методические рекомендации "Основания и порядок применения временного отстранения от должности, наложения ареста на имущество и ценные бумаги, денежного взыскания" (письмо Генеральной прокуратуры РФ от 30 марта 2004 г., N 36-12-04) [Электронный ресурс]. Режим доступа: http://www.innovbusiness.ru/pravo/DocumShow_DocumID_90910.html.

действия в отношении имущества, подвергнутого описи или аресту либо подлежащего конфискации, о чем в протоколе делается отметка.

Такое лицо наделяется полномочиями по владению этим имуществом и его хранению, несет ответственность за его сохранность и обязано его выдать по требованию уполномоченного органа. При определенных условиях допускается использование имущества, но без его передачи, отчуждения, повреждения или уничтожения. Имущество может передаваться для хранения специализированным организациям (включая коммерческие). О передаче арестованного имущества на хранение составляется расписка. Изъятые деньги и иные ценности, на которые наложен арест, подлежат передаче на хранение финансовым органам. Указанное имущество доставляется в кредитную организацию не позднее следующего рабочего дня и подлежат зачислению на специальный счет.

Если арест наложен на дом, дачу, строения, находящиеся в собственности – недвижимое имущество, документы, подлежащие исполнению, направляются в отдел местной администрации, орган по государственной регистрации прав на недвижимое имущество.

О наложении ареста сообщается нотариусу по месту нахождения арестованного имущества для того, чтобы исключить возможность совершения сделок с арестованным имуществом. В решении о наложении ареста на денежные средства, которые хранятся в кредитной организации, следует указать, на какие суммы и имущество накладывается арест.

При наложении ареста на счета в кредитной организации понятые приглашаются из числа ее работников. Следователь вручает руководителю организации копию постановления, предупреждает об уголовной ответственности по ст. 312 УК РФ, разъясняет, что не запрещаются банковские операции, связанные с привлечением и размещением денежных средств на указанном счете.

При наложении ареста по месту учета прав владельца или хранения ценной бумаги, то в каждом месте составляется отдельный протокол, копия вручается должностному лицу организации или владельцу ценных бумаг

Копия постановления и копия протокола о наложении ареста на ценные бумаги, которые требуют специального учета прав их владельца, должны быть направлены держателю реестра ценных бумаг, эмитенту и депозитарию, которые, не могут совершать операции, связанные с отчуждением ценных бумаг, получив указанные документы.

Поскольку наложение ареста на ценные бумаги влечет ограничение прав их собственника, организация, осуществляющая учет этих прав, обязана официально зафиксировать ограничение по распоряжению ценными бумагами и обеспечить соблюдение этого ограничения³³.

После наложения ареста на ценные бумаги следователь изымает их и передает на хранение владельцу или в специализированную организацию, имеющую соответствующую лицензию.

Если следователь сомневается в надежности организации и, что она не выполнит условия ареста, он может передать их на хранение профессиональному участнику рынка ценных бумаг. Достаточно сложно выбрать надежную организацию: возникают трудности в получение согласия на хранение арестованных ценных бумаг, оплаты услуг за хранение, учета, ведения операций с арестованными бумагами. Следовательно нелегко определить, в

³³ Багаутдинов Ф.Н. Наложение ареста на имущество и ценные бумаги по УПК РФ // Юрист. - 2003. - № 1. - С. 41-47.

какую именно организацию поместить их более выгодно с тем, чтобы существенно не уменьшилась их рыночная стоимость. Это может повлечь иски со стороны владельца ценных бумаг, которому в результате ненадлежащего их хранения вред не будет возмещен полностью. Поэтому для решения указанных вопросов целесообразно использовать помощь специалиста.

Если признаки ценной бумаги имеют доказательственное значение, они могут храниться при уголовном деле. Однако если нет сомнений в подлинности ценных бумаг, лучше всего передать их на хранение собственнику либо в специализированную организацию³⁴.

В Монголии «депозит должен быть запечатан в количестве, равном оплате, которая будет заплачена, и счет организации должен быть заморожен для сделок» (ст. 134.9 УПК Монголии).

Как в РФ, так и в Монголии изъятие имущества и передача его на хранение собственнику либо иному лицу могут быть осуществлены только в отношении материальных объектов гражданских прав, в том числе наличных денег; что касается безналичных денежных средств, то в случае их ареста кредитная организация, открывшая счет, на котором они находятся, обязана полностью (или частично – в РФ) прекратить по данному счету любые банковские операции.

Это означает, что до вынесения приговора лицо, признанное потерпевшим и гражданским истцом, либо лицо, на счете которого находятся денежные средства подвергнутые аресту – не вправе пользоваться и распоряжаться арестованными денежными средствами. Это также обязывает должностных лиц кредитной организации следить за сохранностью арестованных денежных средств на соответствующем счете.

Арест находящихся на счете в кредитной организации денежных средств представляет обращенное к кредитной организации предписание о недопущении совершения операций с этими денежными средствами; безналичные денежные средства, будучи записью на счете, отражающей обязательственные отношения между кредитной организацией и ее клиентом - владельцем счета, не могут быть переданы на хранение какому-либо лицу в том смысле, как это определено ч. 6 ст. 115 УПК РФ, регулирующей отношения, возникающие при наложении ареста на материальные объекты.

Кредитная организация является лицом, которое может непосредственно обеспечить сохранность денежных средств, если на них наложен арест, что требует прекращения операций по соответствующему счету. В РФ в случае неисполнения кредитной организацией данного требования Центральный банк РФ вправе отозвать у нее лицензию. Кроме того, ст. 312 УК РФ устанавливает уголовную ответственность за осуществление служащим кредитной организации банковских операций с денежными средствами, на которые наложен арест. Аналогичная норма содержится в УК Монголии (ст. 244 и др.).

Действующее в сфере оборота безналичных денежных средств правовое регулирование создает, таким образом, систему достаточных гарантий надлежащего исполнения кредитной организацией вытекающей из ч. 7 ст. 115 УПК РФ (ст. 134.9 УПК Монголии) обязанности обеспечивать сохранность находящихся на открытых в ней счетах денежных средств.

Требование о недопущении совершения банковских операций кредитной организацией с находящимися на счете денежными средствами, на которые наложен арест, является мерой, достаточной для обеспечения их сохранности. Различия в регулировании

³⁴ Налимов Д.Ф. Наложение ареста на имущество при производстве следственных действий: проблемные вопросы // Право и государство: теория и практика. - 2008. - № 2. - С. 134-136.

последствий наложения ареста на объекты вещных прав в порядке ч. 6 ст. 115 УПК РФ (ст. 134.6 УПК Монголии) и на безналичные денежные средства в порядке ч. 7 той же статьи УПК РФ (ст. 134.9 УПК Монголии) обусловлены различной природой соответствующих объектов гражданских прав. Указанные различия также не могут расцениваться как нарушающие Конституцию, в том числе закрепленный принцип равенства.

Вместе с тем, наложение ареста на денежные средства, находящиеся на счете в кредитной организации, повышает риск возникновения убытков для законного владельца этих денежных средств. Такие убытки могут быть связаны с инфляцией, и с упущенной выгодой, ведь фактически арестованные денежные средства выводятся из оборота.

Институт наложения ареста на имущество – наиболее эффективное средство обеспечения исполнения приговора в части имущественных взысканий. Вместе с тем нарушение норм о наложении ареста на имущество влечет негативные последствия как для лиц, имущественные интересы которых были нарушены, так и для государства, из бюджета которого возмещается ущерб в связи с необоснованными действиями должностных лиц по применению наложения ареста на имущество.

Поэтому в настоящее время остро стоит вопрос о повышении эффективности деятельности органов, призванных защитить имущественные интересы участников уголовного судопроизводства. И в качестве одного из вариантов решения данной проблемы следует рассмотреть вопрос о передаче полномочий по реализации решения о наложении ареста на имущество на предварительном расследовании службе судебных приставов – в России (Маршалльской службе – в Монголии).

Исполнение решения о наложении ареста на имущество на предварительном расследовании следует исключить из полномочий следователя и дознавателя. Это, как отмечает И.Б. Тутьнин, освободит следователя от выполнения данного процессуального действия, которое носит второстепенный характер³⁵.

Участие должностного лица исполнительного производства при аресте имущества упростит работу по осуществлению исполнения приговора в части имущественных взысканий. Получив копию протокола, пристав (судебный исполнитель, маршал) может принять своевременно меры к пресечению действий по растрате, сокрытию или отчуждению имущества и уменьшить вероятность замены описанных вещей менее ценными.

Кроме того, в следственной практике имеются случаи, когда аресту подвергается имущество супругов, вследствие чего необходимо обращаться к нормам гражданского, семейного и исполнительного законодательства, что относится к сфере деятельности службы судебных приставов (в Монголии – маршалов), ее должностных лиц, именно поэтому их участие становится необходимым при проведении ареста имущества и обеспечении сохранности имущества, на которое наложен арест.

Список литературы

1. Конституция Российской Федерации (принята на всенародном голосовании 12 декабря 1993 г.) (с учетом поправок, внесенных Законом РФ о поправке к Конституции РФ от 21 июля 2014 г. N 11-ФКЗ) // Собрание законодательства Российской Федерации от 4 августа 2014 г. N 31 ст. 4398.

³⁵ Тутьнин И.Б. Исполнение судебного решения о наложении ареста на имущество следует полностью возложить на судебных приставов // Российский следователь. – 2009. – № 13. – С. 7-9.

2. Конституция Монголии (принята 13 января 1992 г.) [Электронный ресурс]. Режим доступа: <http://worldconstitutions.ru/?p=33>

3. Уголовно-процессуальный закон Монголии [Электронный ресурс]. Режим доступа: <http://law.edu.ru>.

4. Уголовно-процессуальный кодекс Российской Федерации от 18 декабря 2001 г. N 174-ФЗ (ред. от 8 июня 2015 г. N 140-ФЗ) // Собрание законодательства Российской Федерации от 24 декабря 2001 г. N 52 (часть I) ст. 4921.

5. Гражданский кодекс Российской Федерации (часть вторая) от 26 января 1996 г. N 14-ФЗ // Собрание законодательства Российской Федерации от 29 января 1996 г. N 5 ст. 410.

6. Методические рекомендации "Основания и порядок применения временного отстранения от должности, наложения ареста на имущество и ценные бумаги, денежного взыскания" (письмо Генеральной прокуратуры РФ от 30 марта 2004 г., N 36-12-04) [Электронный ресурс]. Режим доступа: http://www.innovbusiness.ru/pravo/DocumShow_DocumID_90910.html.

7. Постановление Конституционного Суда РФ от 31 января 2011 г. N 1-П "По делу о проверке конституционности положений частей первой, третьей и девятой статьи 115, пункта 2 части первой статьи 208 Уголовно-процессуального кодекса Российской Федерации и абзаца девятого пункта 1 статьи 126 Федерального закона "О несостоятельности (банкротстве)" в связи с жалобами закрытого акционерного общества "Недвижимость-М", общества с ограниченной ответственностью "Соломатинское хлебоприемное предприятие" и гражданки Л.И. Костаревой" // Собрание законодательства Российской Федерации от 7 февраля 2011 г. N 6 ст. 897.

8. Постановление Конституционного Суда РФ от 10 декабря 2014 г. N 31-П "По делу о проверке конституционности частей шестой и седьмой статьи 115 Уголовно-процессуального кодекса Российской Федерации в связи с жалобой закрытого акционерного общества "Глория" // Собрание законодательства Российской Федерации от 22 декабря 2014 г. N 51 ст. 7528.

9. Багаутдинов Ф.Н. Наложение ареста на имущество и ценные бумаги по УПК РФ // Юрист. - 2003. - № 1. - С. 41-47.

10. Колоколов Н.А. Типичное нарушение закона при наложении ареста на имущество // Уголовный процесс. - 2012. - № 10. - С. 56-57.

11. Налимов Д.Ф. Наложение ареста на имущество при производстве следственных действий: проблемные вопросы // Право и государство: теория и практика. - 2008. - № 2. - С. 134-136.

12. Тутынин И.Б. Исполнение судебного решения о наложении ареста на имущество следует полностью возложить на судебных приставов // Российский следователь. - 2009. - № 13. - С. 7-9.

13. Ханов Т.А. Некоторые проблемы, связанные с наложением ареста на имущество, находящегося у других лиц // Уголовный закон: проблемы теоретического моделирования и правоприменения материалы Международной научно-практической конференции: Сборник. - Омск, 2008. - С. 61-64.

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



МОНГОЛ БИЧИГТ ХИЙХ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ АДИЛТГАЛЫН МӨН ЧАНАР


3.Сүлд

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн магадлахуйн
тэнхимийн багш, хууль зүйн магистр,
цагдаагийн ахмад*

Монголын төрт ёс, бичиг соёлын түүхэнд онцгойлон тэмдэглэх үйл явдлын нэг бол найман зууны тэртээ Их эзэн Чингис хаан монгол бичгийг ивээн соёрхож, төрийн бичгээр өргөмжилсөн явдал билээ. Монголын эзэнт гүрэн байгуулагдахаас олон зууны тэртээ монгол нутагт улс гүрнээ байгуулж байсан монгол аймгууд бичиг үсэгтэй байсан бөгөөд Чингис хаан болон түүнийг залгамжлагч их хаад энэ нандин өвийг өвлөн авч цаашид улам хөгжүүлэн дэлгэрүүлсэн байна. Монголын нэгдсэн гүрэн бүрэлдэн буй болж улмаар түүнд нэгдэн орсон олон овог, аймгууд улс төр, эдийн засаг, соёл, ахуйн заншил, шашныхаа талаар ойртож ирэхийн зэрэгцээ төрийн хийгээд ард түмний нэгдмэл бичгийн хэл зайлшгүй шаардлагатай болсон мөн Чингис хааны улс төрийн тулгуур бодлогын нэг болох бутарсан монгол аймгуудыг хураан нэгтгэж, нэг хаантай, нэг төртэй, нэг хуультай, нэгдмэл үсэг бичигтэй, нэгдмэл хүчирхэг армитай болох явдал байв. Шинэ тутам гарч ирсэн энэхүү шаардлага, зорилтуудыг хангахын тулд урьд цөөн зарим аймгийхний дунд хэрэглэгдэж байсан уйгаржин монгол бичгийг нийт монгол аялгуунуудын дундын байдлыг адил тэгш тусгасан, илүү боловсронгуй болгон хэрэглэх хэрэгтэй байлаа. Үүнд

нэг цохон тэмдэглэмээр зүйл бол Чингис хаан Уйгар бичгийг монгол хэл аялгуунд тохирох үсэг болохыг зөвөөр ойлгосон явдал юм³⁶.

Энэхүү бичгийн үүслийг нэгэн хэсэгтээ XIII зуунд хамааруулан үздэг байсан нь түүхэн сурвалжид Чингис хаан Найманыг дагуулж, Тататунга хэмээх бичгийн түшмэлийг барьж өвөрт нь байсан тамгаас үүдэн бичиг гэдэг зүйлийг анх мэддэг болсон, түүнээс уламжлаж бичигтэй болсон, тэр бичиг нь уйгур гаралтай гэж таамаглан үзэх болсонтой холбоотой. Монгол бичиг зохиогдсон нь монголын түүхэнд гарсан бичиг соёлын том нээлт болж Чингис хааны бичмэл хууль, хөх дэвтэр зэрэг нь хөтлөгдөх боломж бүрджээ.³⁷ Дэлхийн бүх бичиг үсгийг хэлбэр дүрс, зохиомжийн талаас нь хэвтээ ба босоо гэж хуваан авч үздэг. Монгол бичиг бол гагцаар дээрээс доош нуруу дагуулж бичдэг авианы босоо хэлбэрт бичиг болно. Дэлхийн олон хэлийг тэмдэглэсэн авианы бичиг нь латин, санскрит, араб, крил, монгол гэх маш цөөхөн байдаг. Үүнээс араб үсгийг зүүнээс баруун тийш өөрөөр хэлбэл, хойноос урагш хөндлөн бичдэг бол монгол бичгийг дээрээс доош босоо бичдэг. Бусад нь цөм баруунаас зүүн тийш хөндлөн бичдэг. Харин Хятад, Япон зэрэг авианы бус, утга дүрсийн бичгийг хэвтээ ч, босоо ч бичиж болно. Авианы анхны үсгийн гарал үүслийг нэгтгэн тоймлож зураглавал:



Хүн төрөлхтөн түүхэндээ:

1. Санаа бичиг
2. Зураг бичиг
3. Утгат бичиг,
4. Үет бичиг зэрэг олон бичиг үсэг хэрэглэж өнгөрчээ.

Санаа бичиг



Зураг бичиг



Латин	Кирилл	Уйгур	Монгол	Түб	Хятад	Япон	Корей
А	А	人	人	人	人	人	人
Б	Б	女	女	女	女	女	女
В	В	耳	耳	耳	耳	耳	耳
Г	Г	馬	馬	馬	馬	馬	馬
Д	Д	魚	魚	魚	魚	魚	魚
Е	Е	山	山	山	山	山	山
Ж	Ж	日	日	日	日	日	日
З	З	月	月	月	月	月	月
И	И	雨	雨	雨	雨	雨	雨
Й	Й	雲	雲	雲	雲	雲	雲

Утгат бичиг



Үет бичиг

Хүн төрөлхтөний нийтээр сурч хэрэглэхэд хамгийн амар дөхөм, хүний санаа бодол, сэтгэхүйн нарийн үйлдлийг төгс илэрхийлж чадах, хэл хэлнээ нийтлэг өргөн хэрэглэж болох тийм бичиг үсгийг эрэлхийлсний үр дүнд сая цагаан толгойн үсэг хэмээх хэлний авиаг үсгээр тэмдэглэдэг авианы бичиг гэгчийг зохиожээ. Эдүгээ хүн төрөлхтөний ихэнх нь энэхүү авианы бичгийг хэрэглэж байна. Шинэ үсгийн гар бичмэл нь зөвхөн нэг төрөл байдаг бол монгол бичгийн гар бичмэл нь

- ❖ хичээнгүй бичиг,
- ❖ гүйлгэн бичиг,

³⁶ Ш.Нацагдорж. “Чингис хааны цадиг”. УБ., 1991. 191-192 дахь тал

³⁷ Ч.Далай. “Монголын түүх” Их монгол улс 1206-1260 / 2 дугаар дэвтэр. УБ., 1994. 64-65, 209 дахь тал

³⁸ Д.Баттогтох.”Монгол бичгийн гайхамшиг оршвой”. УБ., 2001. 23 дахь тал

❖ таталган бичиг гэсэн хэлбэртэй.

Монгол бичгийн цагаан толгой нь эгшиг 7, 16 гийгүүлэгч, харь үг бичих 6 үсэг, бүгд 29 үсэгтэй. Мөн нг, лх, гэсэн нэмэлт хоёр үсэг бий.

Женев хотод байрладаг олон улсын стандартын байгууллага монгол бичгийн стандартыг 2002 онд баталж, НҮБ-ийн соёлын байгууллага ЮНЕСКО 1991 онд монгол бичгийг хүн төрөлхтний оюуны өв санд бүртгэж авсан. Үндэсний монгол бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогыг олон улсын зүгээс дэмжиж, 1991 онд монгол бичгийг олон улсын оюуны өмчөөр бүртгэн авч, 2000 оны 2 дугаар сард Женев дэх олон улсын стандартын байгууллага монгол бичгийн кодыг баталсан байна. 1995 оны 6 дугаар сарын 25-нд УИХ-ын 43 дугаар тогтоол гарч, Монгол Улсын Их Хурал “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Дэлхийд данстай монгол бичгийг сонирхон судлах явцад түүнд Шүүх шинжилгээний бичгийн дахин давтагдашгүй онцлог шинж тэмдэг хадгалагдаж байсан юм.

Монгол бичгийн цагаан толгойн дармал үсгийн стандартыг стандарчлал хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлийн гишүүдийн 1996 оны 9 дүгээр сарын 24-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталжээ.³⁹ Энэ стандарт нь монгол бичгийн хичээнгүй, эвхмэл, татлангүй зэрэг бусад хэлбэрт хамаарахгүй гэдгийг уг стандартын тайлбарт заажээ. Монгол бичгийн дармал, хэвлэмэл баримт бичгэнд шүүх шинжилгээ хийх үед энэхүү стандартыг харгалзаж болох юм.

Монгол бичгийн шинжилгээ нь өөрийн гэсэн тогтсон нэр томьёотой байх шаардлагатай. Бичгийн хэв гэснээс бичгийн тиг, гарын үсгийн тиг гэх мэт нэрлэж хэлж занших нь илүү зөв, бичгийн хэв гэх бус бичгийн тиг гэдэг нэр томьёо хэрэглэх нь зүйтэй. Монгол бичгийн тийн ялгалын нөхцөлүүдийг тусад нь бичдэг. Цөөн хэдэн тохиолдолд шууд залгаж бичдэг. Эдгээр тиг зурлагыг хэрхэн нэрлэх нь тодорхогүй байгаа юм. Ингэхлээр монгол бичгийн шинжилгээний нэр томьёоны тухайд нарийвчлан судлаж тохирсон нэршлийг зөв тогтоон боловсруулах шаардлагатай байна.

Доктор, профессор Ж.Хурцгэрэл криминалистикийн бичиг баримт судлал, бичгийн хэл, бичгийн хэлний шинж тэмдэг, бичгийн хэвийн шинж тэмдэг зэрэг⁴⁰ үндсэн нэр томьёо хэрэглэсэн бол доктор, дэд профессор Б.Бат-Эрдэнэ бичиг баримт судлал, криминалистикийн бичиг судлал, криминалистикийн бичиг техник судлал, бичгийн хэлний шинж, бичгийн хэвийн шинж, бичгийн хэв зэрэг нэр томьёог бүтээлдээ хэрэглэжээ.⁴¹ Доктор Д.Баттогтох монгол бичигтэй холбогдуулан монгол бичгийн тиг ёс, бичмэл тиг, үсгийн тиг, хэлбэр ба харьцаа хичээнгүй, гүйлгэн буюу гүймэл, таталган бичгийн тиг ёс, үсгийн махбодь, үсгийн толгой гэдэс, хөл, үсэг, дүрс урвах үсэг, дүрс үл урвах үсэг, уламжлалт бичлэгтэй үгс⁴² монгол бичгээр монгол хэлээр, өвөр монголд хэвлэгдсэн бичиг материалын шалган байцаалт номд хятад үсгийн тухайд гарын тиг гэсэн нэр томьёо хэрэглэжээ. Үүнд: Гарын тиг- энэ бол тодорхой, хүний бичилтийн хөдөлгөөний дадлаар би болж тогтсон үсэг гэж тодорхойлж байна. Үсэг бичиг нь авиа агуулга, хэлбэр тигтэй байна.

Монгол үсгийн цагаан толгойн сурах бичигт, бичмэл үсэг, дармал үсэг, монгол үсгийн ёс, үсгийн хэв зурлага, үсгийн тиг зурлага, үгийн тиг, тодорхой хүний бичгийн тиг,

³⁹ Монгол бичгийн цагаан толгой, дармал үсэг MNS 4333-96 үндэсний стандарчлал хэмжил зүйн үндэсний төв. УБ., 1996

⁴⁰ Ж. Хурцгэрэл. “Криминалистик 1. УБ., 2002. 402-406 дахь тал

⁴¹ Б.Бат-Эрдэнэ. “Криминалистикийн лекцүүд 1”. УБ., 2003. 77-87 дахь тал

⁴² Д.Баттогтох. Дурдсан бүтээл. УБ., 2001. 85-120 дахь тал

гарын үсгийн тиг, шилбэт үсэг, титэмт үсэг, дэвсгэрлэх үсэг, үл дэвсгэрлэх үсэг, зөөлөн дэвсгэр, хатуу дэвсгэр, хамаатуулах ёс, балархай эгшиг, хувилах үсгийн дүрэм, хувилах ба үл хувилах үсэг, богино эгшиг бичээд уртаар дуудах үгс, хэлбэр ижил дуудлага ба утга өөр үгс, үгийн эхэн, дунд, адагт орох хэлбэрүүд гэх зэрэг нэршлүүд хэрэглэж байна.

Монгол бичиг бол үсгийн хэв, тиг зурлага, үсэг холбох ёс, бичих чиглэл зэргээрээ өвөрмөц юм. Монгол криминалистикийн эрдэмтэн судлаачдын тогтоосон крилл бичгийн шинжилгээнд хэрэглэгдэх нэр томьёо болон бичгийн хэвийн ерөнхий болон хувийн онцлог шинжийг монгол бичгийн шинжилгээнд тэр хэвээр нь хэрэглэх нь боломжгүй. Монгол бичгийн гар бичмэлд шүүх шинжилгээ хийх үед монгол бичгийн сурах бичгийн цагаан толгойн үсгүүдийн тиг, зурлага болон нэршлийг үндсэн загвар болгож авах нь зүйтэй.

Бичгийн тигийн төрлийг кирил монгол бичлэгт элементэн бичлэг, дармал бичлэг хэмээн ангилдаг бол монгол бичигт

1. Тогтуун бичсэн
2. Гүйлгэн бичсэн /хурдан бичсэн/
3. Таталган бичсэн
4. Хичээнгүй бичиг
5. Эвхмэл үсгээр зурсан
6. Уран бичиг буюу угалзлах гэсэн үндсэн зургаан хэв маяг гэж ангилагдана.

Эдгээр нь бичгийн хэвийн бие даасан төрлүүд болох юм. Ийм учир кирил монгол бичгийн хэвийн төлөвшилтийн тогтсон ангилал нь монгол бичигтэй тохирохгүй.

Монгол бичигт шүүх шинжилгээ хийхэд кирил бичгийн ерөнхий ба хувийн онцлог шинж тэмдгүүдээс монгол бичигт огт тохирохгүй 7 онцлог шинж тэмдэг, зөвхөн монгол бичигт шинээр илэрч буй 4 шинж тэмдэг тогтоогдож байгаа юм. Үүнд:

Тохирохгүй байгаа шинж тэмдэгийн тухайд:

Бичгийн хурд: Кирил бичгэнд үсгийн тиг, зурлагыг хэдий чинээ таслалгүй бичсэн бол төдий чинээ хурдан бичсэн байна гэж үзсэн байдаг. Монгол бичиг нь үсэг, цаас салгалгүй гарын нэг л хөдөлгөөнөөр үйлдэгддэг дэлхийд хаа ч байхгүй хурдан бичиг юм. Ингэхлээр монгол бичигт бичгийн тигээ санаатайгаар өөрчилсөн болон анхлан суралцаж байгаа хүн, удаан хугацаагаар бичээгүй, бие махбодид нь тодорхой өөрчлөлт орсон/ өвдсөн, мансуурсан/ хүний бичвэрт л удааширлын шинж тэмдэг илэрнэ. Иймд монгол бичгийн хурдыг холболтоор бус хэлбэрээр тогтоох нь зүйтэй.

Хөдөлгөөний чиглэл: Урдаас хойш, хойноос урагш, эргэлтийн чиглэл нар зөв болон нар буруу эргэлттэй гэж ангилна. Монгол бичгийн тиг зурлагын эргэлт гадаад үг бичих “п”-ээс бусад үсэг бүгд нар зөв буюу баруун эргэлттэй бичигддэг. Гэтэл кирил бичгээр бичихэд үсэг бүрийн бичих тиг зурлага баруун, зүүн эргэлттэй хөдөлгөөн холилдоогийг анхаарах шаардлагатай.

Хөдөлгөөний холболт: **Нэмэлт зурлагын холболт** Монгол бичигт кирил бичгийн ерөнхий шинж болох холболт тохиромжгүй. Учир нь монгол бичиг холболттой бичигддэг ба хооронд тасалдал үүсдэггүй. Үндсэн үгээс салангид бичигддэг цацлага, м, л үсгийн эвэр, гэзэг нь холболт болно.

Бичгийн налалт: Монгол бичгийн тиг, зурлагыг налалтгүй, доош налалттай гэж 2 ангилан авч үзэх,

Бичгийн чадвар илэрхийлэх шинж тэмдэг: **Бичгийн хэмжээ** монгол хүний монгол бичиг бичих гарын тиг зурлагын хэмжээг бичвэрийн босоо тэнхлэгийн дагуу нэг түвшинд байрладаг гэдэс, богино шүд буюу ацаг шүдний хэмжээгээр тодорхойлох,

Хөдөлгөөний гүйлт буюу сүналт: /Тийн ялгалын нөхцөл болон ерөнхийлөн хамаатуулахын нөхцлийн гүйлт/: Үндсэн зурлага болох нурууны төгсгөлөөс дараагийн үгний эхлэлийн зурлага хүртэлх хоорондын зайгаар тодорхойлох,

Хөдөлгөөний маяг Харин Монгол бичигт ердийн болон хэтрүүлсэн гэж ангилах нь зүйтэй. Учир нь монгол бичигт хялбарчилж бичнэ гэсэн ойлголт байдаггүй. Энэ нь бичгийн тигийн бие даасан төрөл болох таталган бичигт хамаарагдах учиртай.

Монгол бичгийн гар бичмэлийн нэг онцлог бол бичвэрийн өндөр зурлага чадвартай хүмүүс сүүл, зурлага, эвэр, гээг үсгийн нэмэлт зэргийг хээнцэрлэн бичдэг. Энэ нь тухайн хүний бичлэгийн хувийн тамга мэт тийм өндөр хэмжээнд хэвшин тогтсон байдаг явдал юм.

Шинээр тогтоогдсон шинж тэмдэг:

Бичигчийн байршил тодорхойлох шинж тэмлэгт: Догол мөр + **Улаан мөр** /Сонгодог монгол бичигт одоогийн шинэ крилл үсэг шиг биш, шинэ санаа, хүндэтгэлийн үг хэллэг зэргийг онцгойлон заавал бичгийн цаасны дээд тал өндөрт бичдэг уламжлалтай. Жишээ нь Чингис хаан гэдэг үгийг ямагт дээр бичиж, бусад баганаас ялгадаг./

-Сүүлний тиг, зурлагын шинж: ,

-Үсэг хоорондын залгамал шинж /нуруу/,

-Орхиц буюу цацлын хэмжээ зэрэг шинж болно.

Дээрхи монгол бичгийн тиг зурлагын ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүд нь цогц байдлаараа дахин давтагдашгүй бөгөөд харьцангуй тогтвортой, хувирбартай байх тул монгол бичгийн гар бичмэлд шүүх шинжилгээ хийх адитгалын мөн чанар болно.

Иймд Монгол бичигт Шүүх шинжилгээг хийхдээ судалгаа, шинжилгээгээр тогтоогдсон бичгийн тиг зурлагын шинж тэмдгүүдийг ашиглах нь шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн бодитой хийгдэх нөхцөл боломжийг олгох юм. Энэ нь эцсийн дүндээ хүний эрхийг хангах баталгаа болох учиртай.

ГАР БИЧВЭРИЙН ОНОШИЛГООНЫ ШИНЖИЛГЭЭ



Б.Отгондалай

*Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч,
цагдаагийн ахлах дэслэгч*

Гэмт хэргийн илрүүлэлтийн явцад криминалистикийн техникийн гүйцэтгэх чиг үүргүүд тогтмол нэмэгдэж байдаг ба тэр дундаас зөвхөн криминалистикийн ч биш физик, механик, анагаах, биологи, сэтгэл судлал, сэтгэл зүй гэх мэт бусад төрлийн тусгай мэдлэгийн хүрээнд явуулдаг шинжилгээний чиг үүргүүд мөн өсөн нэмэгдэж байна.

Энэхүү чиг үүргийн хүрээнд Криминалистикийн шинжилгээ нь криминалистикийн болон байгалын шинжлэх ухааны олон аргыг ашиглаж байдаг. Криминалистикийн шинжилгээний явцад адилтгалын шинжилгээний чиг үүрэг биелэгддэг ба өөрөөр хэлбэл объектыг түүний шинж чанар, агуулга, байгаа байдал зэргээр нь бусад объектоор адилтгал буй эсэхийг тогтоодог.

Объектын адилтгалыг тогтоох гэдэг нь криминалистикийн шинжилгээний чухал чиг үүргүүдийн нэг юм. Уг үйл явцын гол агуулга нь “дэлхий дээрх бүх зүйлс дахин давтагдашгүй нэг ширхэг буюу **нэгж**⁴³ байна” гэсэн криминалистикийн алтан дүрмийн дагуу адилтгал хийнэ. Ийм төрлийн криминалистикийн шинжилгээг Адилтгалын шинжилгээ гэж нэрлэдэг. Тодорхой адилтгал хийдэггүй бусад шинжилгээг практикт “төрлийн болон бүлгийн адилтгалыг тогтоох шинжилгээ”, “бүлгийн хамаарлыг тодорхойлох шинжилгээ” гэж нэрлэдэг.

Шинжээчийн шийдвэрлэвэл зохих үүргүүд нь бичиг судлалын, адилтгалын, оношилгооны, нөхцлийн гэж ангилагдах ба энэ нь шинжээчийн эрх мэдлийн хүрээнд боломжит бүх асуултыг тавих мөн тодорхой, логикийн хувьд зөв шинжээчийн үүргийг ангилах боломж олгодог. Үүнээс гадна шинжээчийн энэ үүргийн ангилал нь криминалистикийн шинжилгээнд хэрэглэгдэж буй олон янзын мэргэшлийн үг хэллэг үүсэхээс сэргийлдэг.

§1. Гар бичвэрийн оношилгооны шинжилгээний судлах зүйл, зорилго, боломж.

Оношилгоо нь хүний танин мэдэх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм. Зарим төрлийн оношилгоо нь материаллаг дэлхийн юмс үзэгдэл, эд зүйлсийн байдал болон агуулгыг таних, түүнийг практикт судлах боломж олгоход чиглэсэн байдаг.

⁴³ Нэгж- дэлхий дээрх бүх зүйлс дахин давтагдашгүй нэг ширхэг байна гэсэн тодорхойлолт

Криминалистикийн оношилгоо нь эд юмсыг танин мэдэх үйл явц учир өөрийн судлахуйгаараа эд юмс, юмс үзэгдэл, хүнийг түүний мөн чанар, байгаа байдлаар нь тодорхойлж тэднийг төрөл болон бүлгээр нь харьцуулах боломж олгодог.

Онош, оношилгоо нь эд юмс, юмс үзэгдлийг танин мэдэх үйл явц учир энгийн мэдлэгээс эхлэн эцсийн бүх шинж тэмдгийг судлах үндсэн дээр байдаг. Оношилгооны үйл явцын эцсийн үр дүн нь болох *онош* нь үндсэндээ мөн чанар шинж байдлаар нь тодорхойлох тухайн юмс үзэгдэл, эд юмсын агуулгын тухай, шинжлэх ухаанаар тогтоож тодорхойлогдсон анги, төрөл, зүйлд эд юмс, юмс үзэгдлийн чухал шинж тэмдгүүдийн цогц логик үндэслэл болон хийсэн шинжилгээг (анализ, синтез) үндэслэн хамааруулан ойлгох *ерөнхий дүгнэлт* юм.

Оношилгоо нь шинжлэх ухааны танин мэдэхүйн үйл явц боловч өөрийн танин мэдэх зорилго, зорилт, чиг үүргээрээ танин мэдэхүйн үйл явцаас ялгардаг. Эд юмс, юмс үзэгдлийн талаар онош тавих нь шинжээч, байгалын болон нийгмийн хөгжлийн шинэ хуулийг тогтоодог, шинжлэх ухааны бус (хайлтын) шинжилгээ юм. Тусгай тохиол тохиолдол нь шинжлэх ухааныг бүрдүүлдэггүй. Шинжлэх ухаан нь хүн эд юмс, юмс үзэгдэлд ерөнхий, тогтмол, давтамжтай, чухал зүйлсийг судалдаг.

Криминалистикийн оношилгооны шинжилгээний объект нь (хүн, эд юмс, эд зүйл, юмс үзэгдэл бүхий) тодорхой объект байна. Тодорхой эзэнгүй захиаг шинжээч авсанаараа бичгийн хэвээр хувь хүний ерөнхий(нас, хүйс) болон (тодорхой гар бичвэрийн баримтын хувьд) нэгж мөн чанарыг тогтоодог. Ямар ч ерөнхий мөн чанар **нэгжийн** мөн чанарыг өөртөө агуулж чадахгүй, учир нь **нэгж** мөн чанар өөртөө ерөнхий болон нэг бүрийн мөн чанарыг агуулна. Бичиг судлалын шинжлэх ухааны объект нь бичгийн хэв юм. Тодорхой гар бичвэр бүр нь шинжилгээний болон ерөнхийг нэгтгэх нэгж болно. Эрдэмтэн-судлаач нь шинэ мэдлэгийг судлаж, шинжилж, нэгтгэж, боловсруулдаг бол шинжээч нь энэ мэдлэгийг өөрийн практик ажилдаа ашиглана. Үүний үндсэн дээр оношилгооны явцад бид объектын тухай ямар нэгэн шинэ мэдлэг олж авахгүй харин өмнө тодорхой байгаа мэдээллийг олж мэдэн тогтооно. Үүнээс үндэслэн шинжлэх ухааны бус мэдлэгийн явцад өргөн утгаараа “тухайн объектын доторхи мэдээлэл”-ийг “бидэнд хэрэгтэй мэдээлэл” болгох шилжүүлэг хийдэг буюу өөрөөр хэлбэл “мэдлэггүй байдал” нь “бүрэн бус (хагас) мэдлэг” болон өсөж дараа нь арай их, түүний дараа бүрэн бүтэн мэдлэг бий болно.

Шинжилгээний явцад шинжээч нь нийгэм болон байгальд ямар нэгэн шинэ зүйлийг нээдэггүй харин зөвхөн бичиг судлаач-эрдэмтдээр боловсруулагдсан гар бичвэр дэх бичгийн хэвээр хувь хүний тодорхой байдал, чанар, мөн чанарыг тогтоодог. Жишээ нь: Гар бичвэр үүсэх үеийн бичвэр гүйцэтгэгчийн нас хүйс болон байдлыг тогтоох.

Хэрвээ объектын ямар нэгэн мөн чанарыг тогтоох боловсруулагдсан лавтай арга зүй байхгүй тохиолдолд эдгээр мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм. Үүнээс үндэслэн объектын тухай ямар нэг юм хэлж болох өмнө тодорхойлогдсон цогц шинж тэмдэг байгаа үед объектын мөн чанар байдлыг оношилж болно. Жишээ нь, Бичгийн хэвээр зан тодорхойлогч нар бичгийн хэвээр хүний зан ааш (үзэн ядалт, үнэнч байдал, уур хилэн, сайхан сэтгэл, харамч байдал)-ийг тодорхойлж болно гэж баталдаг. Гэхдээ энэ бүх батлал нь шинжлэх ухааны үндэслэлгүй, учир нь лавтай арга зүй болон түүнд нь нийцсэн тодорхой бус хүний занг бичгийн хэвээр нь тодорхойлж болох шинж тэмдгийн цогц байхгүй юм.

Оношилгооны үр дүн нь танин мэдэх объектын агуулгын тухай дүгнэлт юм. Оношилгоо нь танин мэдэхүйн үйл явцын онцгой хэлбэр ба оношилгооны төрөл бүр

өөрийн онцлогтой байдаг, гэхдээ ямар ч оношилгоонд ерөнхий зүйлийг заавал тооцох ёстой.

Криминалистикийн оношилгооны арга зүй нь өөртөө нотлох баримтыг судлах багц үйл явцыг агуулна.

Шинжээч нь хоорондоо харилцан хамаарал бүхий тодорхой дарааллыг баримтлана. Үндсэн 3 үе шат байдаг:

1. Урьдчилсан шинжилгээ
2. Нарийвчилсан шинжилгээ
3. Явагдсан шинжилгээнд үнэлэлт өгөх, дүгнэлт үүсэх, дүгнэлт өгөх

Урьдчилсан шинжилгээгээр шинжилгээний зорилгыг тодорхойлж, шинжилгээнд ирүүлсэн материалтай танилцаж, түүндээ үзлэг хийж, шинжилгээний объектын тухай мөр үүсэхэд нөлөөлж болох лавтай мэдээллүүдийг бүгдийг тогтоож, шинж тэмдгийг шинжлэх явцад түүнийг нь тодорхойлох нь лавтай байхыг тогтооно. Жишээ нь, бичгийн хэвээр хүний ямар нэг мөн чанарыг оношилоход эзэнгүй бичвэрийг бичсэн гүйцэтгэгчийн талаар, бичигдсэн үеийн нөхцлийн талаар байж болох бүхий л мэдээллийг мэдэх хэрэгтэй. Энэ нь шинжээчид тухайн гар бичвэрийг судлах явцад гарж ирсэн шинж тэмдгийг бодитойгоор дүгнэн, түүний үлдсэн нь баттай эсэхийг тодорхойлоход дөхөм болно.

Нарийвчилсан шинжилгээний шатанд шинжээчид тавигдсан асуултанд хариулж болох объектын бүх шинж тэмдгийг ялгана. Энэ хэсэгт хамгийн олон төрлийн шинжилгээний аргууд ашиглагдана. Жишээ нь, баримт судлал дээр зохиогч-бичигчийн тухай мэдээлэл олж авахын тулд бичгийн хэлний чиг үүргийг судлаж, бичвэрийн утгын болон агуулгын тал, бичих хэрэгсэл, бичгийн материалыг, гүйцэтгэгчийн нөхцөлдөх хөдөлгөөний дадлыг, албаар болон өөрөө өөрчлөгдсөн бичвэр байгаа эсэхийг тодорхойлохын тулд бичгийн хэвийн шинж тэмдгүүдийг судлана. Үүний дараа бичгийн хэвийн шинж тэмдгийг тодорхой оношилгооны арга зүйн дагуу дүгнэж үнэлнэ.

Оношилгоо нь голдуу нотлох баримтын тухай мэдээлэл (бичгийн материал, бичигч хэрэгсэл, баримтын утгын тал г.м) -ээс бусад хэргийн материалууд гүйцэтгэгчийн тухай хангалттай баттай мэдээлэл өгч чадахгүй, харьцуулах материал байхгүй тул адилтгалын шинжилгээ явуулах боломжгүй үеүдэд хийгддэг. Энэ шатанд шинжилгээний объектын үнэлгээ, анализ, синтезийг хийнэ. Түүнээс гадна объектод илэрсэн шинж тэмдгүүдийг магадлалын өгөгдөлүүдтэй харьцуулж ялгах шинжилгээг хийж болно.

Явуулсан шинжилгээнд үнэлэлт өгөх шатанд шинжилгээний объектын мөн чанар болон чанарыг тодорхойлох шинжээчийн арга зүйн дагуу илэрсэн шинж тэмдгүүдийг цогцод (симптомокомплексы) нь эхний 2 шатанд авсан өгөгдлийг тооцон үнэлдэг.

Явуулсан шинжилгээнд үнэлэлт өгөх нь зөвхөн тодорхой цогц шинж тэмдгүүдийн тухай мэдээ биш юм. Шинжээч шинжилгээний бүх шатанд авсан өгөгдлийг үнэлж, шинжилгээнд ирүүлсэн объектыг бүрэн судласны дараа хийж болох, тодорхой мөн чанар, байдлыг тодорхойлж танин мэдэх бололцоо олгодог, түүнгүйгээр шинжилгээний объектын тухай зөв дүгнэлт хийж чадахааргүй 3 дугаар шатанд төгсгөлийн шинжилгээний үр дүнг үнэлнэ. Энэ нь логик бодлын хууль болон аргын тусламжтай хийгддэг сэтгэн бодох үйл явц юм.

Явуулсан шинжилгээнд өгсөн үнэлэлт болон өөрийн дотоод итгэл үнэмшлийн дагуу шинжээч объектын мөн чанар, чанар байдлын тухай дүгнэлт боловсруулна. Шинжээчийн итгэл үнэмшил шинжилгээний явцад илэрсэн мэдээллийн үндсэн дээр үүсэх ба логикийн хуулийн дагуу байх ёстой:

1. Бие биендээ эсрэгцэж болохгүй, хэрвээ бие биенээ эсэргүүцэж байвал эдгээр нь шинжилгээний үр дүнгээр бодитой тайлбарлагдсан байх ёстой.
2. Илэрсэн шинж тэмдэг нь харьцангуй тогтмол, тодорхой ганц байна.
3. Шинж тэмдгүүд нь хоорондоо уялдаа холбоотой, харилцан хамааралтай, дүгнэлт үүсгэхэд хангалттай байна.

Цуглуулсан мэдээллийн үндсэн дээр шинжээч дүгнэлтээ товч, тодорхой бичнэ. Дүгнэлтэнд шинжилгээний объектын мөн чанар, шинж чанар, байдлыг тодорхой арга зүйн дагуу илрүүлж мэдээллийг болон объектыг тодорхой анги, төрөл, зүйлт хамааруулах тухай бичнэ.

Оношилгооны явцын логик схем болон криминалистикийн оношилгооны үе шатуудын чиг үүрэг дээр үндэслэн оношилгооны бичгийн хэвийн шинжилгээний явц нь дараах схемийн дагуу байна.

Адилтгалын болон оношилгооны шинжилгээний явцын харьцуулалт

Оношилгооны шинжилгээ		Адилтгалын шинжилгээ	
Тодорхой бус этгээд		Тодорхой бус этгээд	Гүйцэтгэсэн гэх этгээд
Шинжлэгдэж буй гар бичмэл	Тодорхой мөн чанар, шинж чанар, байдал гүйцэтгэсэн нөхцлийн онцлог	Шинжлэгдэж буй гар бичмэл	Бичгийн хэвийн харьцуулах загварууд
Илэрсэн бичгийн хэвийн шинж тэмдгүүд		Бичгийн хэвийн ерөнхий болон хувийн шинж тэмдгүүд	Бичгийн хэвийн ерөнхий болон хувийн шинж тэмдгүүд
Бичгийн хэвийн харьцуулалт		Шинж тэмдгүүдийг харьцуулах үйл явц	
Гар бичмэлд илэрсэн		Шинжилгээний үр дүнгийн үнэлэлт	
Гүйцэтгэгчийг тодорхой бүлэгт хамруулах дүгнэлт		Адитгал байгаа эсэх талаар дүгнэлт	

Оношилгооны шинжилгээ нь адилтгалын шинжилгээнээс ялгаатай нь шинжилж буй болон шинжлэгдэж буй объектуудын хоорондын холбоог судалдаг адилтгал тогтоох аргаар явагддаггүй, харин бие даасан объектын мөн чанарыг илрүүлэх аргаар түүнтэй төстэй бусад объектуудтай харьцуулалт хийдэгт байна. Үүнээс үндэслэн объектын ач холбогдолтой талыг танин мэдэх үндсэн дээр түүнийг олон болон нэг төрлийн объектоос ялгах ба нийцэх төрөл (зүйл, төрөл, ангилал)-д нь объектыг хамааруулна.

Дээр дурьдсанаас үндэслэн Криминалистик шинжилгээний оношилгоо нь материаллаг дэлхийн эд юмс, юмс үзэгдлийн байдал, чанар, мөн чанарыг материаллаг бэхжүүлсэн зураглалаар нь танин мэдэх, судлах зүй тогтол ба тодорхой бүлэг төрөл зүйлд нь хамааруулан ялгах онол юм.

Криминалистикийн оношилгооны шинжилгээ нь

- зарим тохиолдолд тавигдсан үүргийнхээ дагуу,
- зарим тохиолдолд цааш үргэлжлүүлэн шинжилгээ явуулах боломжгүй үед

төгссөн шинжилгээ болдог, харин бусад тохиолдолд дараагийн адилтгалын шинжилгээг явуулахад зориулсан урьдчилсан шинжилгээ болдог.

Бичгийн хэвийн оношилгооны чиг үүрэгт дараах зүйлсийг тодорхойлно:

1. Гүйцэтгэгчийн хувийн биеийн онцлог, нас, хүйс, өндөр, биеийн харьцаа, харааны байдал г.м
2. Хувь хүнийг ялгах чанар,
 - дээд мэдрэлийн үйл ажиллагааны төрөл (цэвэрч, цоглог, баттай байдал, зоригтой байдал, аймхай байдал г.м)
 - зан аашийн төрөл (холерик, сангвиник, меланхолик, флегматик)
 - мэдрэлийн үйл явцын шинж (сэргэх, тогтвортой байх, биеэ барих)
 - ажлын онцлог (ажилд хандах хандлага, хослуулах чадвар, ажлын стиль, байнгын харилцаанд байх г.м)
3. Бичвэрийг гүйцэтгэж байх үеийн хувь хүний сэтгэцийн болон биеийн байдал
 - сэтгэцийн байдал (сандрал, сэргэсэн байдал, ядарсан байдал, биеийн ядарсан байдал, согтуу болон хар тамхи хэрэглэсэн байдал, хүйтэн температурд бие хөрсөн байдал)
 - сэтгэцийн байдлыг бодвол урт удаан хугацаанд байх шинжтэй өвчний байдал (сэтгэцийн, мэдрэлийн, халдварт өвчнүүд, оюун ухааны хоцрогдол, хараа болон сонсголын буруу ажиллагаа, хөдлөх эрхтнүүдийн буруу ажиллагаа г.м)
4. Хувь хүний нийгмийн онцлог- (яс үндэс, амьдардаг дүүрэг, боловсролын зэрэг г.м)
5. Бичигчийн янз бүрийн дадал- (мэргэжлийн, зургийн, товчлол ашигласан г.м)

Оношилгооны шинжилгээний эдгээр чиг үүргүүд нь бичсэн байж болох магадлалтай хүмүүсийн тоог багасгахад чиглэсэн байдаг ба өөрөөр хэлбэл гар бичвэрийн бүлгийн шинжийг тогтооно. Шинэ шинж тэмдэг илрэх бүрт бичсэн магадлалтай хүмүүсийн тоо багасч байдаг.

Бичиг судлалын шинжилгээг чиг үүргээр нь 3 үндсэн шатанд хувааж болно.

1-рт. Гэмт хэрэг илрүүлэхэд хамгийн ач холбогдолтой нь адилтгалын шинжилгээ юм. Бичгийн хэвийн адилтгалын шинжилгээгээр тодорхой бичсэн этгээдийг тогтоож адилтгал хийнэ.

2-рт. Оношилгооны шинжилгээний үр дүнд бие хүний мөн чанар байдал болон бичвэрийг гүйцэтгэгчийн тухай бусад мэдээллийг тогтооно. Мөн объектын бүлгийн хамаарлыг тодорхойлно. Энэ тохиолдолд их мэдээллийг оношлох тусам бичвэрийг бичсэн магадлалтай хүний тоо цөөрнө. Үүний дараа 2-р шатанд бичвэрийг үлдээсэн байх магадлал бүхий хүмүүсээс адилтгалын шинжилгээ хийх зорилгоор загварын бичвэр авна.

3-рт. Нөхцлийн шинжилгээний үед объектын үйлдлийн нөхцөл байдал болон үйлдлүүдийн тухай мэдээллийг тогтооно, өөрөөр хэлвэл үйлдэл болох үед ямар байсан тэр нөхцлийг тогтооно. Харин бичгийн хэвийн хувьд хэрхэн яаж ямар нөхцөлд бичвэр үйдэгдсэнийг тодорхойлно. Энэ шинжилгээг фактын шинжилгээ гэж нэрлэж болно. Нөхцлийн шинжилгээ шинжилгээний хамгийн эхний шат бөгөөд энэ шинжилгээг хийснээр шинжээч бичвэрийг үйлдсэн хүнийг илэрхийлэхгүй боловч бичвэрийг гүйцэтгэх явцад нөлөөлсөн нөхцлийн улмаас үүссэн олон шинж тэмдгийг тайлбарлах боломж гарна. Зарим нөхцлийн шинжилгээг заавал явуулах шаардлагатай байдаг, жишээ нь албаар өөрчилж бичсэн (бичих дадалтай гараа сольж бичих, өөр хүний бичгийн хэвийг харж болон санаанаасаа дуурайлган бичих, бичмэл бичгийн хэвээр нуун бичих г.м) бичвэрийн фактыг тогтоох, учир нь нөхцлийн шинжилгээг явуулахгүйгээр гаргасан дүгнэлтгүйгээр оношилгооны болон адилтгалын шинжилгээг баттай үндэслэлтэй явуулах боломжгүй юм.

Оношилгооны болон нөхцлийн шинжилгээний чиг үүргийг ялгах нь чухал ач холбогдолтой бөгөөд тус бүрийн шинжилгээг явуулах чиглэл, түүний хүрээ болон баттай байдлыг тодорхойлж өгдөг

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



ЗӨВШӨӨРЛИЙН ТОГТОЛЦООНД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

*Д.Булган
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн магистр, цагдаагийн ахмад*

Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, нийгмийн амьдралын бүх хүрээнд ардчиллыг бэхжүүлэх, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх эрхэм зорилтуудыг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага улам нэмэгдсээр байна.

Монгол Улсын цагдаагийн байгууллагаас иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид зарим үйл ажиллагаа, эд зүйл ашиглах зөвшөөрөл олгох ажиллагаа олон жилийн уламжлалтай хийгдэж байгаа боловч энэхүү ажиллагааны эрх зүйн үндэс, механизмууд нь иж бүрэн хөгжих үндэс суурь нь саяхнаас бүрдээд байна.

Зөвшөөрөл олгох ажиллагаа нь төрийн чиг үүрэг, ашиг сонирхолтой тодорхой хэмжээгээр холбоотой байдаг бөгөөд зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон янзын аргыг ашигладгийн нэг нь төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас тодорхой зөвшөөрөл өгдөг явдал юм.

Зөвшөөрөл олгох ажиллагаа нь төрийн тодорхой байгууллагын тогтолцоогоор дамжин хэрэгжих бөгөөд энэ тогтолцооны бүрдэл бол төрийн захиргааны байгууллагууд байдаг.

Зөвшөөрлийг хууль зүйн талаас нь авч үзэх юм бол төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас олгодог тодорхой шийдэл, хууль зүйн үндэс юм. Ингэж эрх бүхий байгууллага албан тушаалтнаас зөвшөөрөл өгч байгаа харилцааг хууль тогтоомж, эрх зүйн актуудаар зохицуулж өгдөг.

Сүүлийн жилүүдэд хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт болон хууль сахиулах ажиллагааг зохион байгуулалтын хувьд шинэчилж, олон улсын жишигт нийцсэн хүний эрх, эрх

чөлөөг дээдэлсэн, хамгаалсан үйл ажиллагааг практикт бий болгох нь өнөөгийн тулгамдаж буй асуудлын нэг юм.

2013 онд Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн томоохон институци болсон бөгөөд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нилээдгүй шинэ заалт, ажил хийгдсэн. Энэхүү өөрчлөлтийн нэг бол Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд лицензийн төв байгуулагдаж, зөвшөөрөл олгох ажиллагааг цогц байдлаар шийдвэрлэх эхний алхам тавигдаж, ЦЕГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 777 дугаар тушаалаар тус төвийг байгуулсан.

Цагдаагийн албаны үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бусад албадыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, мэдээллийн бааз суурь, зөвшөөрлийн системийг төгөлдөржүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Ингэснээр цагдаагийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээг шуурхай, ил тод нээлттэй үзүүлснээр иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх ажээ.

Нэг. Зөвшөөрлийн тухай ойлголт, захиргааны эрх зүйн судлагдахуун болох нь. Зөвшөөрөл олгох замаар төрийн тодорхой зорилт чиг үүргийг хэрэгжүүлдэг. Нийтийн захиргааны эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгож захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаагийн хувьд энэ нь захиргааны эрх зүйн зохицуулалт, судлах зүйлд хамаарна.

Зөвшөөрлийг хэл зүйн үүднээс авч үзвэл: үгийн үндэс нь зөв. Зөв-аливаа юмны зүйтэй, зохистой; зөв ёс, зөв журам, зөв үзэл

Зөвшөөрөл - зөвшөөрөх үйлийн нэр нь зөвшөөрөлтэй хэрэг, зөвшөөрөл авсан, зөвшөөрөл олгох, зөвшөөрөн хүлээсэн хэрэг⁴⁴ хэмээн тайлбарлаж байна.

Зөвшөөрөл гэдэг нь Licentia буюу эрх зөвшөөрөл гэсэн утгатай латин үг⁴⁵ юм. Мөн АНУ-ын Англи хэл, Их Британи, Энэтхэг, Канад, Австрал, Шинэ Зеланд, Ирландын, эсвэл Өмнөд Африкийн Англи хэлэнд “зөвшөөрөл”, “зөвшөөрөл олгох баримт бичиг” гэсэн утгыг илэрхийлдэг.⁴⁶

License гэдэг үйл үг нь “тусгай зөвшөөрөл”, “лиценз зөвшөөрөл олгох” гэсэн үг, харин нэр үг нь “зөвшөөрөл” гэсэн утгыг агуулдаг.

Академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг⁴⁷”-тээ лиценз гэдгийг дараахь 2 утгаар тайлбарлажээ.

1. Дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу лиценз олгож, явуулбал зохих үйл ажиллагааны төрлийг хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны буюу нутгийн удирдлагын байгууллагаас тусгайлан олгодог зөвшөөрөл;
2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар буюу техникийн бусад ололтыг ашиглахаар лицензийн гэрээ, эсхүл шүүхийн буюу эрх хэмжээ бүхий төрийн байгууллагын захиргааны шийдвэрийг үндэслэн олгодог зөвшөөрөл; гэж тодорхойлоод патентын буюу патентын бус, энгийн, онцгой эрхийн, иж бүрэн гэж ангилжээ. Мөн тусгай зөвшөөрөл, албадан лиценз, нэг удаагийн лиценз, онцгой лиценз, экспортын лиценз гэж хуваажээ.

Хууль зүйн эрдэмтэн судлаачдын бүтээлээс харахад “зөвшөөрөл”, “зөвшөөрөл олгох”, “лиценз” нь төдийлөн судалгааны эргэлтэнд ороогүй сэдэв болох нь харагдана.

⁴⁴ Я. Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. 276 тал

⁴⁵ Российская Юридическая Энциклопедия. Изд-во инфра-М* Москва. 1999. с.492

⁴⁶ License. From Wikipedia, the free encyclopedia, <https://en.wikipedia.org/wiki/License>

⁴⁷ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. –УБ., 2008, 263 дахь тал.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн “Монгол Улсын захиргааны эрх зүй”, Монгол Улсын захиргааны эрх зүй ба захиргааны процессын ажиллагаа⁴⁸ гэсэн бүтээлдээ “зөвшөөрөл”, зөвшөөрлийн тогтолцооны талаар авч үзжээ.

Зөвшөөрлийн тогтолцоо-захиргааны эрх мэдэл бүхий субъектээс иргэн байгууллагад тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй ажиллагааны нөхцөл, журмын биелэлтэд хяналт тавихтай холбогдон эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцааны нийлбэр юм.

Зөвшөөрлийн тогтолцооны гол бүрдэл хэсэг

- Хууль тогтоомжоор олгосон тухайн асуудалд зөвшөөрөл өгөх бололцоо, зөвшөөрөл авах хүсэлтэд дурдсан үндэслэлийг урьдчилан судлах
- Чиг үүргийн эрх мэдэл бүхий субъектээс зохион байгуулалтын талаар өөрт харъяалалгүй хүн, байгууллагад зөвшөөрөл олгох ажиллагаа
- Харьцангуй хориглолт бий болгох. Тэр нь эрх зүйн хэм хэмжээнд шууд ба шууд бусаар тусгагдсан байна.
- Зөвшөөрөлтэй үйл ажиллагааны нөхцөл, журмын хэрэгжилтэнд хяналт тавих
- Зөвшөөрөлтэй ажиллагааны нөхцөл, журам зөрчигдсан тохиолдолд уул ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох
- Гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх, зөрчлөөс хохирол учруулсан бол түүнийг арилгуулах

Мөн хууль зүйн доктор П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” бүтээлдээ “Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа ба захиргааны шийдвэр гүйцэтгэл” гэсэн тавдугаар бүлэгт⁴⁹ захиргааны шийдвэр гаргах ажиллагааг “зөвшөөрөл олгох”-той холбож тайлбарлажээ. Тухайлбал, захиргаанаас ямар нэг акт гаргаж, гэрээ байгуулж байгаа болон өөр бусад арга хэмжээг хэрэгжүүлж байгаа үйлдэл бүрийг захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гээд дараахь төрөлд авч үзжээ.

а. ерөнхий буюу хэлбэржээгүй захиргааны шийдвэр гаргах ажиллагаа

б. хэлбэржсэн шийдвэр гаргах ажиллагаа

в. хяналт шалгалтын үр дүнд шийдвэр гаргах ажиллагааг иргэдийн гомдол, санал хүсэлтийн үндсэн дээр захиргаанаас явуулж буй арга хэмжээний зорилго болон түүнийг эрх зүйд нийцсэн эсэхийг шалгахад хэрэглэгдэг.

г. Олон нийтэд шууд нөлөөлдөг шийдвэр гаргах ажиллагаа нь иргэдийн эрх ашгийг ямар нэг байдлаар хөнддөг.

д. Захиргааны цуврал шийдвэр гаргах ажиллагаа нь өгүүлж буй ажиллагааны хуулиар тусгайлан зохицуулагдсан ажиллагааны төрөл биш боловч өвөрмөц хэсэг юм. Энэ нь зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтай холбоотой⁵⁰ гэж дурджээ.

Эдгээр судлаачдын бүтээлээс харахад зөвшөөрөл олгох ажиллагаа нь захиргааны эрх зүйн судлагдахуун болох нь тодорхой бөгөөд энэ талаар дэлгэрүүлэн үзэж судалгааны эргэлтэнд оруулах нь зайлшгүй байна.

Зөвшөөрлийн тогтолцоонд лицензийг өргөн хэрэглэдэг. Лиценз нь зөвшөөрлийн тогтолцооны гол агуулгыг бүрдүүлэх бөгөөд энэ нь тодорхой зөвшөөрөл ба иргэд хуулийн этгээдэд тодорхой үйлдвэрлэл эрхлэх, үйл ажиллагаа явуулахад олгож байгаа зөвшөөрлийг хамааруулан авч үздэг.

⁴⁸ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй ба захиргааны процессын ажиллагаа. –УБ, 2001 он, 156, Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. –УБ, 2008, 215н.

⁴⁹ П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. –УБ, 2004 он, 163н.

⁵⁰ Мөн бүтээлийн 164-166 дахь талаас дэлгэрүүлэн харна уу.

Зөвшөөрөл нь гагцхүү тэр чиглэл хүрээнд л үйл ажиллагаа эрхлэх эрх олгодог. Зөвшөөрлийн үндсэн дээр тодорхой үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх нь харьцангуй эрх юм. Тодорхой үйлдвэрлэл, үйл ажиллагааг лицензжүүлэх асуудал нь зөвшөөрлийн тогтолцооны нилээд түгээмэл хэлбэр болдог.

Лиценз нь захиргааны эрх зүйн хувьд эдийн засгийн аргад хамаарна. Нийтийн захиргааны бүрэн эрхт байгууллагаас эсвэл орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас лицензжүүлэлтийн хууль тогтоомжинд хамаарах үйл ажиллагааны төрөлд олгож байгаа зөвшөөрлийг ойлгож болно. Бие хүн, хуулийн этгээдээс тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхэд бүрэн эрхт этгээдээс зөвшөөрөл олгох, зөвшөөрөлгүй эрхэлбэл хууль бусад тооцогдох үйл ажиллагааг хэлнэ.

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлийн тухай хууль⁵¹”-ийн 15 дугаар зүйлд лицензтэйгээр /тусгай зөвшөөрөлтэйгөөр/ эрхлэх үйл ажиллагааны төрлийг заасан байдаг.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэж тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг иргэн, ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгийг⁵² хэлнэ гэж заасан байна. Лиценз нь иргэд, хуулийн этгээдэд хэрэглэгддэг өвөрмөц арга ажиллагаа гэж хуульд тодорхойлжээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийт 17 чиглэлээр 172 нэр төрлийн тусгай зөвшөөрөл олгохоор заасан ч зөвшөөрөл олгох эрх бүхий 54 байгууллага 914 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог байна⁵³.

Нийтийн захиргааны байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл нь өргөн хүрээтэй асуудлыг хамардаг бөгөөд түүнийг олгож байгаа субъектыг авч үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, яам, агентлаг, бүх шатны хурал, Засаг дарга нар байна. Тусгай зөвшөөрөл олгож байгаа төрийн захиргааны байгууллагуудын тогтолцооноос дурдвал:

- *Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хороо*: төрийн өмчийн холбоотой хамтарсан үйлдвэрийг үүсгэн байгуулах гэрээ хэлэлцээрийг хянаж зөвшөөрөл олгодог. Тэдгээрт өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулан шийдвэрлэх, төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, татан буулгах, хамтран хуулийн этгээд байгуулах талаар санал боловсруулдаг.
- *Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Монголын Радио телевизийн хэрэг эрхлэх газар*: Радио телевизийн нэвтрүүлгийг дамжуулах, дахин дамжуулах зөвшөөрлийг зохих журмын дагуу бусад байгууллага, аж ахуйн нэгжид олгодог.
- Санхүү эдийн засгийн сайдын асуудлын хүрээнд: *Засгийн газрын тохируулагч агентлаг Улсын бүртгэлийн алба*: Тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах аж ахуйн үйл ажиллагаа болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн улсын бүртгэлтэй холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий төрийн байгууллагатай хамтарч чирэгдэлгүй зохион байгуулах.
- *Засгийн газрын тохируулагч агентлаг Гаалийн ерөнхий газар*: Монгол Улсын хилээр дамжиж байгаа ховордсон зүйлийн амьтан, ургамлын худалдаанд хяналт

⁵¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль. <http://www.legalinfo.mn/law/details/34?lawid=34>

⁵² Мөн хуулийн 3.1.1 дүгээр зүйл.

⁵³ Зөвшөөрлийг яаж олгох вэ? <http://politics.news.mn/content/182569.shtml>

тавих үүрэгтэй ба хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал эрхлэгчдэд анхан шатны зөвшөөрөл олгодог.

- *Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн улсын хяналтын газар:* Даатгалын үйл ажиллагаа эрхлэх, лиценз олгох үйлдлийг гарган шийдвэрлүүлнэ.
- *Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд: Хууль зүйн яам, Засгийн газрын тохируулагч агентлаг Цагдаагийн ерөнхий газар:* Ангийн буу болон тээврийн хэрэгсэл жолоодох лиценз олгодог.

Хоёр. Зөвшөөрлийн тогтолцоонд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, эрх зүйн зохицуулалт. Цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавихтай холбогдсон харилцаанд тодорхой дэглэм үйлчилдэг. Энэ нь захиргааны зохицуулалтын нэг онцгой төрөл бөгөөд нэг ёсондоо тодорхой нөхцөл байдалд субъектээс баримтлах үйл ажиллагааны эрхийн зохицуулалт болдог. Дэглэм нь хүмүүсийн тодорхой үйл ажиллагааг зохицуулагч хууль зүйн цогц хэм хэмжээгээр баталгаажсан дүрэм журмын нийлбэр юм.

Цагдаагийн байгууллагын зөвшөөрлийн үйл ажиллагаа нь тодорхой хууль зүйн факттай холбогдож, дуусгавар болдог. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагаас зөвшөөрлийн хүрээнд холбогдох иргэн, байгууллагад захиргааны хяналтыг хэрэгжүүлэх боломжийг бий болгодог. Захиргааны хяналт нь нийтээр дагаж мөрдүүлэхээр төрөөс тогтоосон хууль тогтоомж, журмыг байгууллага иргэд хэрхэн сахин биелүүлж байгаад тавих хяналт юм.

Цагдаагийн байгууллагын зөвшөөрлийн систем нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Энэ систем нь иргэд албан тушаалтнаас тодорхой үйлдэл, үйл ажиллагаа явуулахад заавал зөвшөөрөл авах журмыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт боловч захиргааны эрх зүйн үүднээс авч үзвэл явцуу утга нь зөвхөн цагдаагийн байгууллагаас тусгай хяналтын албадаас зөвшөөрөл авах журмыг багтаасан тодорхой ойлголт юм.

Цагдаагийн байгууллагаас олгож буй бүх төрлийн зөвшөөрөл, түүнтэй холбоотой үйл ажиллагаа нь зөвшөөрлийн тогтолцооны нэг гэж ойлгоно. Лиценз, зөвшөөрөл, шийдвэр, дүгнэлт, итгэмжлэл, аккредитаци, гэрчилгээ, мэдэгдэл, эрх олгох г.м. Энэ нь иргэн, аж ахуй эрхлэгч хүсэлт гаргах мөчөөс эхлэн асуудлыг шийдвэрлэхийн тулд цагдаагийн байгууллагас хууль, хууль тогтоомжид заасан зөвшөөрөл олгохтой үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гаргах хүртэлх үйл ажиллагаа юм.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа лицензийн төв нь мэргэжил хяналтын болон зөвшөөрөл хяналтын гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд хяналт тавьж байгаа зөвшөөрлийн тогтолцооны объект нь

1. Зөвшөөрөл хяналтын хэсэгт

- Буу зэвсэг, галт хэрэгсэл
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх
- Тусгай дуут дохио хэрэглэх
- Аюултай ачаа, тээш тээвэрлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хянаж, тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох

2. Мэргэжил хяналтын хэсэгт

- Жолоодох эрхийн гэрчилгээ олгох гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл олгодог байна⁵⁴.

⁵⁴ Лицензийн төв. <http://license.police.gov.mn/> сайтаас дэлгэрүүлэн харна уу.

Цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь Галт зэвсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгохтой холбоотой хууль, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаас бүрдэнэ.

Цагдаагийн байгууллагаас зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлснээр:

- Хууль тогтоомжийн дагуу зөвшөөрлийн тогтолцооны объектод хяналт тогтоож хянан шалгах
- Тэсрэх дэлбэрэх бодисын хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн байдлыг үе үе шалгаж харилцан мэдээлж, хамтран ажиллах
- Зөвшөөрлийн тогтолцооны тогтоогдсон журмыг зөрчигчдөд захиргааны албадлагын урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэл, ногдуулах гэх мэт

Цагдаагийн байгууллагын зөвшөөрөл олгох, хяналт тавих албаны гол зорилт нь зөвшөөрөлтэй эд зүйлийг гэмт зорилгоор ашиглах бололцоо олгохгүй, тогтоогдсон журмыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, ийм зөрчлийг цаг тухайд нь илрүүлж таслан зогсоож байх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлагатай хангах юм.

Цагдаагийн байгууллага нь зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх материал, хүчтэй үйлчлэх хорт бодис болон дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу зөвшөөрлийн тогтолцоонд байвал зохих зүйлсийг олж авах, хадгалах, тээвэрлэх талаар тогтоосон журмын биелэлтийг хангах явдал юм.

Цагдаагийн байгууллага нь галт зэвсэг өмчлөхөөр олгосон үнэмлэхэд уг бууг ямар зориулалтаар ашиглахыг тухайлбал, ан агнах, өмч хамгаалах, өвлөх, түүнчлэн спорт-сургалт, дурсгалын зэргийг заадаг. Нөгөө талаар галт зэвсэг, сум хэрэгслийн эзэмшигч нь энэ талаар тогтоосон журмыг хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавьж, тодорхой хугацаанд үзлэг явуулж зөрчлийг арилгах, буруутай этгээдэд хариуцлага оногдуулж ажиллана.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодолсон барааны жагсаалт”-ын 93.03 дахь хэсэгт заасан “Тэсэрдэг цэнэгээс гал авч ажилладаг, бусад галт зэвсэг болон тэдгээртэй адил төстэй хэрэгсэл (жишээ нь спортын үрлэн сумтай буу болон винтов, хар дариар гол төмрийг нь цэнэглэдэг буу, дохионы гар буу болон зөвхөн дохио өгөхөд зориулагдсан бусад хэрэгсэл, хоосон цэнэгтэй сумтай револьвер болон хийн бууг) зөвхөн Буудлага спорт сургалтын холбоо болон тэдгээрийн гишүүнчлэлтэй иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын Аж Үйлдвэрийн яамны бодлогын зохицуулалтын хэлтсээс лиценз авч улсын хилээр нэвтрүүлж байна гэж заасан байдаг.

Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дугаар тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам"-д заасны дагуу зөвшөөрөл хүссэн иргэд бичгээр хүсэлт гаргасны дагуу хэрэглэдэг.

Гурав. Цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох ажиллагаанд анхаарах зарим асуудал. Зөвшөөрөл олгох ажиллагаа нь бүртгэл, мэдээлэл, стандартчилал зэрэг төрөл хэсгийг өөртөө багтаадаг ажиллагаа бөгөөд цагдаагийн байгууллагаас хийгдэж буй энэхүү ажиллагаа нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг

хангахтай холбоотой үйл баримтыг тооцоолох, баримтжуулах, хянан шалгах зорилготойгоос гадна тайлан тооцоог ил тод байлгах ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд зөвшөөрлийн системийг бий болгосноор дараах ач холбогдолтой:

- Зөвшөөрөл хүсэгчийн зөвшөөрөл авах зардал багасах,
- Зөвшөөрөл авахтай холбогдуулан шаардагдах бичиг баримтын тоо болон шат дамжлага цөөрөх,
- Зөвшөөрлийг олгох хугацааг багасгаснаар төрийн үйлчилгээний үр өгөөж дээшлэх,
- Ил тод байдал, үйл ажиллагаа болон мэдээллийн найдвартай байдал сайжрах,
- Аж ахуйн эрхлэгчдэд үзүүлэх цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмж нэмэгдэх,
- Зохицуулалтын чанар болон эрх зүйн аюулгүй байдлыг хянах тогтвортой систем болох зэрэг болно.

Ийнхүү цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох тогтолцоо удаагүй боловч үйл ажиллагааг нь боловсронгуй болгох, цаашид хөгжүүлэх нь зайлшгүй юм.

Төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгаж, иргэд, бизнес эрхлэгчдэд таатай боломж олгох зорилгоор Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг санаачлан боловсруулсан ажиллаж байгаатай холбоотой цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох ажиллагааг боловсронгуй болгох нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгохдоо дараах үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй.

- Зөвшөөрөл, лиценз олгох олон шат, дамжлагыг улам бүр цөөлөх;
- Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нэг албан хаагчтай харьцах зарчмыг тогтоож, бусад шат дамжлагад төрийн байгууллагууд хоорондоо харьцах замаар иргэдэд үйлчлэх;
- Хуулиар тогтоосон хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг шинээр нэвтрүүлэх;
- Мэдээллийн технологийг ашиглан цаасаар үйлддэг шат дамжлагыг бууруулах,
- “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Ил тод байдлыг бүрдүүлэх зэрэг болно.

Эцэст нь дүгнэн хэлбэл. Цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгох ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох, түүний онолын болон практик асуудлыг гүнзгийрүүлэн судалж, түүнд дүн шинжилгээ хийж, судалгааны эргэлтэнд оруулж, цаашид боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал, галт зэвсэг ашиглах, эзэмших, өмчлөх эрх нь нэг талаас хүний эрх боловч нөгөө талд асар их хор хөнөөл дагуулж болзошгүй тул түүнд зөвшөөрөл өгч, хяналт тавьж, түүний үр нөлөөг дээшлүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай нөхцөл бүрдэнэ. Тухайлбал, цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрлийг ангилж, үйл ажиллагааг тодорхойлж, процессын ажиллагааг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагаас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд заасан зөвшөөрөлд холбогдох ангилал, төрөл, баримт бичгийн бүрдлийг тогтоох, өргөдөл,

хүсэлт хүлээн авч, хянан хэлэлцэх, шийдвэр гаргах илүү нарийвчилсан журам бүхий нийтээр дагаж мөрдөх шинжтэй эрх зүйн актыг батлан гаргах нь зүйтэй.



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧААС ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ш. Чулуун
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага⁵⁵ бөгөөд энэхүү үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай тохиолдолд хүч хэрэглэдэг.

Энэ нь гэмт хэрэг үйлдэж байгаа болон сэжиглэгдэж буй этгээдийг баривчлах, нийгмийн хэв журам зөрчсөн этгээдэд захиргааны таслан зогсоох тусгай албадлага хэрэглэх үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ашиглах байдлаар илэрдэг.

Галт зэвсэгтэй албан үүргээ гүйцэтгэж буй албан хаагч хуульд заасан галт зэвсэг хэрэглэх үндэслэл журам бий болсон тохиолдолд холбогдох хууль, заавар, журмын дагуу галт зэвсэг ашиглаж, хэрэглэж болно. Энэ бол хуулиар олгогдсон эрх байдаг.

Галт зэвсэг хэрэглэх ажиллагаа нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны таслан зогсоох тусгай албадлага бөгөөд захиргааны таслан зогсоох албадлага нь эрх зүйн зөрчил үйлдэгдсэнтэй холбоотойгоор түүнийг үргэлжлэн гаргахгүй болгох, учирч болзошгүй аюулыг зайлуулах зорилготой төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр хэрэглэж байгаа шууд албадах ажиллагаа⁵⁶ учир хүний эрх, эрх чөлөө хөндөгддөг онцгой арга хэмжээ юм.

Энэ нь хуулийн хүрээнд хийгдсэн тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн гэж үзэхгүй. Цагдаагийн албан хаагч нь галт зэвсэг хэрэглэх онцгой эрхийг хуулиар эдэлдэг байна.

Цагдаагийн албан хаагч хуульд заасан чиг үүрэг гүйцэтгэх үедээ өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой аюул бодитойгоор тулгарсан үед галт зэвсэг хэрэглэнэ.

⁵⁵ Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг

⁵⁶ Ж.Долгорсүрэн. “Цагдаагийн эрх зүй”, УБ хот, 2004., 242 дахь тал

Цагдаагийн байгууллага, албан хаагч нь дээрх чиг үүргийг гүйцэтгэхдээ “Албаны зориулалтаар шинээр галт зэвсэг, тусгай хэрэгслийг худалдан авах, албан хэрэгцээнд оруулахаас өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан танилцуулж, зөвшөөрөл авна”, “... бүртгэгдээгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл, сумыг албан хаагчид тавьж олгох, хэрэглэхийг хориглоно”⁵⁷, “хуульд зааснаас гадуурх, цагдаагийн ерөнхий газрын зөвшөөрөлгүй дуурайлган хийсэн галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэхийг хориглоно” гэж заасан.

Галт зэвсгийг хууль тогтоомжид заасан журам, заавар болон үйлдвэрлэгчээс гаргасан ашиглах зааврын дагуу хэрэглэх бөгөөд үйлдвэрлэгчийн зааврыг хавсралт болгож хэрэглэнэ⁵⁸, цагдаагийн албан хаагч өөрт олгогдсон галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгслийг ашиглахын өмнө үйлдвэрлэгчийн заавартай сайтар танилцаж, хэрэглэж сурсан байна гэж тус тус нарийвчлан тусгаж өгсөн байна.

Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүний эрүүл мэнд хохирсон бол эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх үүрэгтэй.

Хууль сахиулах байгууллага, хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтныг зохих журмын дагуу шалгаруулж авах, тэдгээр нь өөрийн үүргийг амжилттай гүйцэтгэх ёс зүй, зан суртахуун, сэтгэл санаа, эрүүл мэнд, бие бялдрын зохих бэлтгэлтэй байх нь зүйтэй.

Галт зэвсгийг хууль зөрчиж хэрэглэх нь хүний эрхийн наад захын үндсэн зарчим болох хүний халдашгүй эрхийг хамгаалах заалтыг ноцтой зөрчсөн хэрэг юм.

Цагдаагийн албан хаагч нь доорх тохиолдолд хүч хэрэглэхдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 40, 42 дугаар зүйлийг баримталж ажиллана.

- Өөрийгөө хамгаалах
- Бусдыг хамгаалах
- Тодорхой гэмт хэргийг таслан зогсоох
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад тохиолдолд

Үүнийг нарийвчлан задалбал цагдаагийн албан хаагч дараах тохиолдлуудад галт зэвсэг хэрэглэх эрхтэй байхаар тусгажээ.⁵⁹ Үүнд:

- Цагдаагийн албан хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон, тээврийн хэрэгсэл унаж зугтаан орчиндоо аюул бий болгосон
- Галт зэвсгийг нь булаахаар довтолсон
- Цагдаагийн хамгаалалтад байгаа бүс, объект руу хууль бусаар зэвсэг хэрэглэн нэвтрэн орсон, эсхүл бүлэглэн довтолсон
- Барьцаанд байгаа хүнийг суллах
- Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтэн болон сэрдэгдсэн этгээд оргон зугтсан бөгөөд түүнийг баривчлах үед хүч хэрэглэн эсэргүүцсэн
- Галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн

⁵⁷Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-р зүйлийн 17.4 дэх заалт

⁵⁸Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-р зүйлийн 17.4 дэх хэсэг

⁵⁹Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсэг

- Хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн довтолсон, эсхүл бүлэглэн довтолсон

- Баривчлах, саатуулах, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон

- Бусдын албаны болон орон байр руу зэвсэглэн, бүлэглэн довтолсон этгээдийн дайралтыг таслан зогсоох, эзлэн авсныг чөлөөлөх

- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, хамгаалсан, хориглосон этгээдэд

- Иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгахад

- Анхааруулга, түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах

- Бэлтгэл, сургуулилтын үед зэрэг болно.

Мөн цагдаагийн албан хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй. Энэ нь цагдаагийн байгууллага, албан хаагчийн албан үүргээ хэвийн гүйцэтгэх, ажлаа хийснээс аливаа нэг сөрөг үр дагаварт өртөхгүй байх, албан хаагчийн аюулгүй байдлыг хангаж өгөх гэх зэрэг нөхцлийг бүрдүүлж өгсөн чухал эрх зүйн батаалгаа болж өгсөн.

Цагдаагийн байгууллага, албан хаагч албаны галт зэвсэг хэрэглэхдээ Цагдаагийн албаны тухай хууль⁶⁰, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль⁶¹ Хууль зүйн сайдын А/126 дугаар тушаалыг⁶² баримтлан түүнд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 38.2.7-д “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”⁶³ тухай тодорхой заажээ.

Энэхүү үүргийг цагдаагийн байгууллага нь хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудад нарийвчлан тусгасан байдаг.

Галт зэвсгийн тухай ойлголт тодорхойлолтыг хууль болон эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлжээ:

Хэл зүйн талаас нь нэрт эрдэмтэн Я.Цэвэл “Галт зэвсэг гэж /галаар тэсрүүлэх зэвсэг”; *галт бөмбөг; галт буу*”⁶⁴ гэсэн бол доктор З.Цэрэнбат “Зэвсэг” гэдэгт юу ч орж болно тухайлбал, галт болон хүйтэн зэвсэг. Харин **“Цагдаагийн зэвсэг” гэж гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын тодорхой үүрэг гүйцэтгэх үед шаардагдах цагдаагийн байгууллагаас олгогдсон, цагдаагийн албан хаагч биедээ авч явах эрх бүхий, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан тохиолдлуудад хэрэглэж болох галт болон бусад зэвсэг юм**”⁶⁵ гэжээ.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд дараах нэр томъёог дор дурдсан утгаар тодорхойлсон байна. Үүнд:

⁶⁰Цагдаагийн албаны тухай хуулийн 8-р бүлгийн 33-р зүйлийн 33.6 дахь хэсэг

⁶¹Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 20-р зүйл

⁶²2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн байгууллагад ашиглах галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт”

⁶³ Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт

⁶⁴Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь., УБ хот., 1966., 135 дахь тал

⁶⁵ Цэрэнбат.З., “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик” 2006, УБ хот, 8 дахь тал

"Галт зэвсэг" гэж дарины шаталтын хийн даралтаар сумны хошуу буюу үрлийг гол төмрөөс их хурдтай гаргаснаар сумны хошуу нь хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулах, ан агнах, бусад зүйлийг хөнөөх чадвар бүхий хэрэгслийг⁶⁶ хэлнэ. Харин АНУ-д хүчийг аминд хүрэх зэвсэг ба аминд үл хүрэх зэвсэг гэж ангилдаг байна. Аминд хүрэх зэвсэгт галт зэвсэг харин аминд үл хүрэх зэвсэг нь хүний бие, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирол, гэмтлийг багасгах замаар бие хүн болон материал хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн зэвсгийн цогцолбор систем юм⁶⁷ гэж тодорхойлжээ.

Тус аминд үл хүрэх зэвсгийг хэрэглэснээр огт хүний амь насыг хохироох, биед гэмтэл учруулахгүй гэсэн баталгаа байхгүй. Зөв зохистой, холбогдох заавар журмын дагуу хэрэглэснээр амь насаа алдах, ноцтой бэртэл гэмтэл учрах эрсдлийг бууруулах нөхцлийг бүрдүүлж өгдөг байна.

Цагдаагийн байгууллагын тусгай албадлагын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аминд үл хүрэх зэвсгийг үхэлд хүргэх зэвсэгтэй цуг ашиглаж болох бөгөөд уг зэвсгийг цагдаагийн албан хаагч эсрэг талын үйл ажиллагааг өөрөөр хэлбэл, гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоохын тулд цагийн нөхцөл байдалд тулгуурлан зохистой хэрэглэх явдал юм.

Цагдаагийн албан хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон өөрөөр хэлбэл, гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол онцгой тохиолдолд галт зэвсгийг хэрэглэнэ.

Энэхүү нөхцөл байдлыг Б.Пүрэвийн Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбарт: Амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах аюул бодитой байхын дээр зодох, шалбалах төдий биш ноцтой хохирол /алах, тахир дутуу болгох, хордуулах, мансууруулах мэт/ учруулахаар довтолсон байвал галт зэвсэг хэрэглэж болно гэж заасан байна⁶⁸.

НҮБ-аас батлан гаргасан Хүч ба галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд эрх зүйн баримт бичгийн 9 дүгээр зүйлд "...албан хаагчид галт зэвсгийг зөвхөн өөрийгөө хамгаалах, эсвэл амь насаа алдах, эсвэл хүнд гэмтэл бэртэл авах эрсдэлд байгаа хүмүүсийг аврахаас бусад тохиолдолд хэрэглэж болохгүй", "...хүмүүсийн амь насанд шууд аюул учруулж буй онц хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ийм гэмт хэрэгтнийг баривчлахад", "ийм үр дүнд хүрэхэд өөр аюулгүй арга хэмжээ үр дүнгүй байгаа тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ гэж заажээ.

Мөн "Аль ч тохиолдолд хүний амийг аврахад зайлшгүй шаардлагатай үед галт зэвсгийг ашиглаж болно" гэжээ.

"Цагдаагийн албан хаагч бол хүний амийг авдаг биш, авардаг байх ёстой" гэсэн энэ үгийг цагдаагийн албан хаагчид тэр дундаа гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх ажиллагаа явуулдаг албан тушаалтан бүр ямагт санаж байх чухал юм.

Цагдаагийн байгууллага, албан хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу зэвсэггүйгээр тулалдах мэх, тусгай хэрэгсэл, **галт зэвсэг** хэрэглэхэд дараах нийтлэг журмыг баримтална гэжээ.⁶⁹

⁶⁶ Галт зэвсгийн тухай Монгол Улсын хууль, УБ, 2001, 3 дугаар зүйл

⁶⁷ Зэвсэгт хүчний жанжин штаб, АНУ-ын сургагч багш нарын хамтарсан "Аминд үл хүрэх зэвсэг" сургалт 2010 он

⁶⁸ Пүрэв.Б., Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар, УБ, 1997, 102 дахь тал

⁶⁹ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 17-р зүйлийн 17.1 дэх заалт

а/ Бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах.

б/ Тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.

в/ Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад мэдэгдэж, эрүүл мэндийн анхан шатны туслалцаа үзүүлэн захирах даргадаа илтгэн, дарга нь прокурорт бичгээр мэдэгдэх зэрэг болно.

Хуулиар эрх олгогдсон цагдаагийн албан хаагч хууль ёсны албан үүргээ биелүүлэхдээ хүчийг тохируулан хэрэглэх ур чадвар, нарийн мэдрэмжтэй байхын тулд дараах зүйлийг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

- Зөрчилдөөнийг уян хатан шийдвэрлэх арга
- Ятгах, ойлгуулан ухамсарлуулах
- Өөрийгөө хамгаалах
- Хамгаалалтын хэрэгсэл ашиглах
- Хүний амь насанд аюулгүй хэрэгсэл ашиглах
- Галт зэвсэг хэрэглэх
- Нийтийн эмх замбараагүй байдлыг зөв үнэлэх, олон нийтийн хандлагыг ойлгох
- Өөрийн сэтгэл зүйд гарч байгаа өөрчлөлт, хувийн зан чанараа зохицуулан удирдах чадвараа дээшлүүлэх
- Анхны тусламж үзүүлэх зэрэг зүйлүүдийг сурсан байх зайлшгүй шаардлагатай.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн өөрийн болон бусдын амь нас аюултай байдалд орсон нөхцөлд галт зэвсэг хэрэглэх шаардлагатай боловч аль болох түүнээс зайлсхийж, бусад амь насанд аюулгүй арга замыг эрэлхийлэх нь чухал юм.

Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлэхгүй байх эсвэл эсэргүүцэх тохиолдолд зөв үнэлэлт дүгнэлт өгч, тухайн нөхцөлд үндэслэлтэй зайлшгүй тохирох хэмжээний хүчийг хэрэглэх ёстой.

Тодорхой нөхцөл байдалд хүч хэрэглэх эрх мэдлийг цагдаад олгодог боловч түүнтэй хамт энэхүү эрх, үүргээ хуулийн хүрээнд, үр дүнтэй биелүүлэх өндөр хариуцлага мөн ноогддог.

Цагдаагийн албан хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үедээ биедээ галт зэвсэг авч явах эрхээ урвуулан ашиглах, ан гөрөө хийх, хувийн асуудлаас болж бусадтай маргалдан зөрчилдөх, сэтгэл хөдлөл, айж сандрах үедээ өөрийн хийсвэр төсөөллөөр албаны галт зэвсгийг ашиглаж хэрхэвч болохгүйг анхаарах хэрэгтэй.

Энэхүү хариуцлагаа ухамсарлан ойлгоход албан хаагчийн ёс зүйн асуудал чухал үүрэгтэй гэдгийг ямагт санах хэрэгтэй.

Дээр дурдсан нөхцөл байдалд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна.

- Цагдаагийн албан хаагч тэр дундаа албан үүргээ биелүүлэхдээ галт зэвсгийг биедээ авч явдаг, хэрэглэх эрхтэй албан хаагчдад энэ чиглэлийн үндэсний хууль тогтоомж шинэчлэгдсэн тухай бүр эрх зүйн баримт бичгийн агуулга, мөн чанарыг судлуулж, хэрэглэх үндэслэл, журмын талаар мэдлэг олгох, хэрэглэх чадвар эзэмшүүлэх,

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс батлан гаргасан галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой эрх зүйн баримт бичигт тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах, олон улсын жишиг стандартын баримтлах шаардлага тавьж, хэрэгжүүлэх,
- Цагдаагийн албан хаагчийн албаны бэлэн байдал, аюулгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд сургалт, дадлагыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухай бүр үр дүнтэй явуулж, галт зэвсэгтэй харьцах ур чадвар, дадлыг бий болгох, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
- Галт зэвсэг хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөнд халддаг албадлагын онцгой арга хэмжээ тул олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагатай хамтарч ажиллах зэрэг болно.



*Б.Баянмөнх
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
цагдаагийн хошууч*

ТЕРРОРИЗМ ГЭЖ ЮУ ВЭ?

XXI зуунд дэлхийн улс орнууд олон улсын терроризмын сүлжээнд автагдаж, түүний аюул занал хаана, хэдийд ч ямар хэлбэрээр илэрч болох эрсдэл бий болох нөхцөл байдал улам бүр нэмэгдсээр байна.

Терроризм түүхэн улбаатай, бүр манай он тооллын I зууны Зилотууд болон Сисариас эхлээд ХҮШ зууны сүүл үеийн Францын хувьсгал, XIX зууны сүүл үеийн анархистууд, XX зууны улс төрийн хэт даврагч бүлгийнхний үйл ажиллагаа тухайлбал, Оросын ардын тэмцэл, Алжирын үндэсний чөлөөлөх хөдөлгөөн, Ирландын улаан арми, Италийн улаан бригадынхан, Колумбын Хувьсгалт зэвсэгт хүчнийхэн зэргээр дамжин илэрсээр өнөө үетэй холбогдож байна.⁷⁰

Хүн төрөлхтөнийг хэрэн сүлжиж, айдаст автуулаад байгаад терроризмын эсрэг тэмцэлд дэлхийн улс орнууд хамтын хүчин чармайлтаар тэмцэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өөрөөр хэлбэл их гүрэн, жижиг, буурай орон гэж ялгалгүй терроризмын болзошгүй аюулаас сэрэмжлэх, урьдчилан сэргийлэх, гарч болох эрсдлийг бууруулах арга хэмжээг эх орон, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь дэлхийн улс орон бүрийн төр, засгийн үүрэг болоод байна.

Терроризмын эсрэг тэмцэлд нийгмийн хэв журмыг хангах болон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хүчтэй тэмцлийг зохион байгуулж, үүнд иргэний байгууллагуудыг оролцуулж чадсан улс үндэстэн ихээхэн амжилт олсоор байна.⁷¹

Терроризм⁷² нь тухайн улс орны хил хязгаар, том жижиг, баян хоосон, хөгжил дэвшил, яс үндэс, цэргийн хүчин чадавхиас үл хамааран хаана ч бий болзошгүйгээрээ хамгийн их аюултайд тооцогдож байна.

Сүүлийн жилүүдэд зарим улс оронд үндэстний цөөнх болсон угсаатан, ястнууд тусгаар тогтнохын төлөө хөдөлгөөн идэвхижүүлж буй хийгээд зарим шашны зүтгэлтнүүд өөрийн шашныхаа “үнэт” гэж үзэх зүйлсийг үндэстэн дамнуулан тархаан түгээх хандлага,

⁷⁰ Ц. Дашзэвэг., Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ. 2004. 29 дэх тал

⁷¹ Ч.Баатар., Ч.Алтангэрэл. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхноо хамгаалах нь. УБ. 2006.3 дахь тал

⁷² Терроризм (англ. terrorism) – 1. Өргөн утгаараа террорист бодлого ба практик, хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл;

оролдлого илт хийх болсон нь улам бүр хурдаа авч буй даяаршлын үр дүн, үйлдэл гэж үзэх үндэстэй байна.

Тэд өөрсдийн хөдөлгөөн, тэмцэлдээ террорист ажиллагаа, террорист үйлдлийг өргөн хэрэглэх болсноор олон улсын терроризмд хил хязгаар гэж байхгүй болж, ажиллагаа нь даяарших шинжийг агуулах болжээ.⁷³

Террорист үйл ажиллагаа⁷⁴ -нд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

1. Террорист явуулгыг зохион байгуулах, төлөвлөх, бэлтгэх ба хэрэгжүүлэх;
2. Террорист зорилгоор хувь хүн буюу байгууллагад хүч хэрэглэх, материаллаг объектыг усгах явуулгад бусдыг өдөөн турхирах;
3. Террорист явуулга үйлдэхийн тулд хууль бус зэвсэгт бүлэглэл, гэмт бүлэглэл, гэмт байгууллага, зохион байгуулалттай бүлэг байгуулсан, ийм явуулгад оролцсон;
4. Террорист этгээдүүдийг элсүүлсэн, зэвсэглэсэн, сургаж бэлтгэсэн ба ашигласан;
5. Үзтэл илэрхий террорист байгууллага буюу террорист бүлгийг санхүүжүүлсэн буюу тэдэнд өөр тус дөхөм үзүүлсэн;⁷⁵

Терроризм нь зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөсөн, хөрөнгө, санхүүгээр дулдуйдсан, зэвсэг, хөнөөх хэрэгслийн хүчинд тулгуурлсан экстремист⁷⁶, салан тусгаарлагч үзэлтэй харгис цөөн хүний хүрээллийн дотор маш нууц бэлтгэгдэж, шуурхай явуулдаг үндэстэн дамжсан эрүүгийн онц ноцтой гэмт хэргийн шинжтэй дэндүү хэрцгий хүчирхийлэл болоод байна.

Терроризмын зорилго нь улс төр, нийгмийн байгууллын тогтолцоог өөрчлөх, төрийн байгууллын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх гэсэн үндсэндээ улс төрийн агуулгатай байна.⁷⁷

2001 оны есдүгээр сарын 11-нд Америкийн Нэгдсэн Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн цуврал халдлагууд хүн төрөлхтөнд терроризмын аюул заналхийллийг гашуунаар мэдрүүлсэн билээ. Аль-Кайда бүлэглэлийн амиа золиослогчид иргэний агаарын тээврийн нисэх онгоцнуудыг барьцаалан аймшигтай террорист халдлага үйлдэж, 2977 хүний амийг хороосон. Амь эрсэдсэн хүмүүсийн дунд АНУ-ын иргэдээс гадна дэлхийн 60 улсын иргэд байсан гэсэн судалгаа байдаг.

Уг халдлагын дараа АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш “терроризмын эсрэг дайн” нэртэй олон улсын цэргийн ажиллагааг санаачлан хэрэгжүүлсэн. Өмнө нь хүн төрөлхтөн терроризм гэгч аюулын эсрэг ийм өргөн хүрээтэй, олон тоглогчтой, зохион байгуулалттай ажиллагаа явуулсан түүх байдаггүй байна.

Терроризм нь хаана хяналт шалгалт сул, сонор сэрэмжгүй, назгай байдал ноёрхож, хүн ард нь түүний эсрэг тэмцэх бэлтгэлгүй байна, тэнд орон зайгаа олон цэцэглэн хөгжиж, нутагшиж байдгийг амьдралаас харж болохоор байна.

Терроризмын эсрэг дайны хүрээнд Америк тэргүүтэй холбоотны цэргүүд Ирак дахь Саддам Хуссейн, Афганистан дахь Талибаны дэглэмийг түлхэн унагасан түүхтэй. Гэвч өнөөдөр Умард Африк, Ойрхи Дорнодын бүс нутагт террорист бүлэглэлүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулсаар байна.

⁷³ Ц. Дашзэвэг., Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ. 2004. 19 дэх тал

⁷⁴ Террорист үйл ажиллагаа - англ. terrorist activity; ор.террорис-мическая деятельность

⁷⁵ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 402 дахь тал

⁷⁶ Хэт даврагч гэсэн агуулгатай үг юм.

⁷⁷ Ц. Дашзэвэг., Д.Чагнаадорж. олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ. 2004. 20 дахь тал

Террорист бүлэг⁷⁸ (англ. *terroristic group*; ор. *террористическая группа*) - гэдэг нь террорист үйл ажиллагаа явуулах зорилгоор нэгдсэн бүлэг этгээд⁷⁹ хэмээн тодорхойлсон байдаг байна.

Айлган сүрдүүлэх, алан хядах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж буй хүчирхийллийн нэг хэлбэр болох терроризм нь ардчилсан нийгмийн улс төр, эдийн засаг, эрх зүй, оюун санааын амьдралд дарамт үзүүлж, өөрийн хүсэл зорилгыг бусдад тулган хүлээлгэхэд чиглэгдсэнээрээ нийт хүн төрөлхтөний аюулт дайсан болж байна.⁸⁰

Нөгөө талаараа терроризм нь нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулах зорилго бүхий сэтгэл зүйн дайралт гэж үзэж болно. Террористууд сэтгэл зүйн дайралт явуулахдаа энгийн номхон иргэдийн эсрэг харгис хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэхээр заналхийлэхийг үндсэн аргаа болгон ашиглаж байна.

Терроризм үүсэх шалтгаан, нөхцөлийг нийгэмд хуримтлагдсан зөрөлдөөн, сөргөлдөөнтэй асуудлыг террорист арга хэрэглүүрээр шийдвэрлэх алхамд хүргэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байгааг судлаачид олж тогтоосон байна. Үүнд:

- Эдийн засгийн гүн гүнзгий хямрал
- Улс төрийн ужгирсан тогтворгүй байдал
- Төр, түүний институт, бүтцийн хямрал
- Түүхийн соёлын, зан суртахууны, хүмүүнлэгийн үнэт зүйлс эвдэгдсэн, буснигдсан
- Төрийн аппарат суларсан, юуны өмнө түүний эрх мэдэлтнүүд авилгад идэгдсэн
- Тусгай албадын мэргэжлийн түвшин нэн доогуур байгаа
- Засаг төр, хуулийн нэр хүнд илт унаж, түүний иргэдийн аюулгүй байдлыг хангах чадварт хүмүүсийн итгэх итгэл суларсан
- Зэвсгийн хууль бус зах зээл хүрээгээ тэлж, түүнийг олж авахад харьцангуй хялбар болсон
- Иргэдийн амьдралын түвшин доройтож, санаа сэтгэлийн ая тухгүй, түгшүүр зовнил, хүн амын үлэмж хэсэгт мэдрэгдэж, нийгмийн төвхнөлөө олоогүй, хамгаалалтгүй байдал улам бүр хурцадмал болсон
- Нийгэмд түрэмгий, хэрцгий, хүмүүнлэг бус явдал хүрээгээ тэлсэн
- Улс төрийн намууд засгийн эрх мэдлийн төлөө улайран тэмцэлдэж, лидерүүд нь амин хувийн зорилгод хөтлөгдсөн
- Шудрага бус явдал нийгэмд газар авч, хүний наад захын эрх зөрчигдөж байгаа
- Эсэргүүцэж буй, гомдож буй, шаардлага тавьж буй хүмүүстэй тайван арга замаар харилцах, эн тэнцүү суваг дутагдалтай байгаа
- Засгийн газар, цагдаа, шүүхийн байгууллага суларч, хүмүүс тэдгээрийг хэрэггүй гэж үзэх болсон⁸¹

Терроризмын талаар дэлхийн олон улс орны эрдэмтэн судлаачид тодорхойлолт өгсөнөөс гадна төрийн байгууллагууд нь мөн адил өөрийн гэсэн онцлог бүхий тодорхойлолтыг хийсэн байдаг байна. Тухайлбал:

- АНУ-ын Холбооны мөрдөх товчооны тодорхойлолт: “Терроризм бол улс төрийн болон нийгмийн зорилгодоо хүрэхийн тулд төр, засагт шахалт үзүүлэх, энгийн

⁷⁸ Террорист бүлэг - англ. *terroristic group*; ор. *террористическая группа*

⁷⁹ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 402 дахь тал

⁸⁰ Терроризмын эсрэг. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ. 2003. 4 дэхь тал

⁸¹ 2003 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Терроризмын эсрэг” олон улсын бага хурал дээр доктор С.Нарангэрэлийн “Монгол Улсад терроризмтой тэмцэх эрүүгийн эрх зүй ба криминологийн зарим асуудал” сэдвээр тавьсан илтгэлийн хэсгээс хэсэгчлэн авав.

иргэдийг айлган сүрдүүлэх аргаар бие хүн, тэдний эд хөрөнгийн эсрэг хууль бусаар хүч хэрэглэх эсхүл хүчирхийлэхийг хэлнэ”

- АНУ-ын Төрийн департаментийн тодорхойлолт: “Үндэстэн дамнасан бүлэглэл эсвэл нууц агентууд улс төрийн сэдэлтэйгээр нийгмийн тодорхой хэсэг, гэмгүй номхон ард иргэд, чухал алба хашдаг эрх мэдэл бүхий хүмүүст нөлөөлөх зорилгоор иргэний байгууламжийг бай болгон зориуд санаатай үйлдэж буй хүчирхийллийг терроризм гэнэ”
- АНУ-ын БХЯ-ны тодорхойлолт: “Улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор төр, засаг, нийгэмд шахалт үзүүлэх, эсвэл тэднийг айлган сүрдүүлэх зорилго бүхий зориуд санаатай үйлдэж буй хүчирхийлэл, хүчирхийлэх аюулыг терроризм гэнэ”
- ОХУ-ын тодорхойлолт: “Терроризм бол хувьсгалт болон экстремист агуулгатай хүчирхийллийн (ялангуяа хүмүүсийг алж хөнөөх, хулгайлах, барьцаалах гэх мэтээр) гэмт үйлдэл мөн. Хууль бус бүлэглэлийн бэлтгэн явуулж буй террорист үйлдэл нь засаглалын ноёрхолын арчаагүй байдлыг харуулах эсхүл засаглалын байгууллагаас сөрөг үйлдэл явуулахыг өдөөн турхирахад оршино. Эдгээрийн аль аль нь эрх барьж буй улс төрийн засаглалын байгууллагын талаар олон нийтэд сөрөг санал сэтгэгдэл бүрдүүлэх зорилго агуулж байдаг”
- Их Британий тодорхойлолт: “Улс төр, шашин, үзэл суртлын зорилгынхоо төлөө, үүний дотор нийгмийг эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар харгис хүчирхийлэл хэрэглэхийг терроризм гэнэ”
- НАТО-гийн тодорхойлолт: “Терроризм гэж хөрөнгө, санхүү, хөнөөх хэрэгслийн хүчинд дулдуйдсан хууль бус зэвсэгт бүлэглэлээс улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөн, нийгэмд бүхэлд нь, эсвэл түүний тодорхой хэсэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгоор энгийн иргэд, иргэдийн эд хөрөнгийн эсрэг зориуд санаатайгаар үйлдэж буй хэт харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх үйлдлийг хэлнэ”⁸² хэмээн тус тус тодорхойлжээ.

Түүнчлэн дэлхийн зарим эрдэмтэн судлаачид терроризмын талаар өөр өөрсдийн зүгээс янз бүрээр тайлбарлан бичиж байна. Тухайлбал,

- Доктор (Sc.D), профессор С. Нарангэрэл “Терроризм бол өргөн утгаараа террорист бодлого ба практик, хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл”⁸³
- Колумбийн их сургуулийн судлаач П. Уилкинсон “Улс төрийн терроризм бол улс төрд айлган сүрдүүлэх аргыг ашигласан, философи үндэслэлтэй, зорилго чиглэл бүхий улс төрийн бодлого юм”
- ОХУ-ын судлаач М.Одесский, Д.Фельдман нар “Нийгмийн тогтвортой, нэгдмэл ухамсрыг айлган сүрдүүлэх хэрэгслээр удирдан залах арга бол терроризм мөн”
- ОХУ-ын эрдэмтэн, судлаач А.С.Ахиезер “Терроризм бол зохион байгуулалттай бүлэглэлийн эцсийн арга, өөрөөр хэлбэл аллаг үйлдэх, дэлбэлэх, барьцаалах гэх мэт аргаар олон түмний сэтгэл зүйг өөрчлөх, нийгмийн амьдралыг хүндрүүлэх, зогсонги байдалд оруулах, эргүүлэх, төрийн байгууламжийг эвдлэх, олон нийтийн амьдралд үл гүйцэтгэлдэх үзэл бодол шингээх, тогтоох гэсэноролдлого”

⁸² Ц. Дашзэвэг., Д.Чагнаадорж. олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ. 2004. 23-24 дэх тал

⁸³ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 401 дэх тал

- ОХУ-ын эрдэмтэн Л.А.Моджоран “Терроризм бол ямар нэгэн улс төрийн зорилгод хүрэхийн тулд үйлдэгдэж буй хүчирхийлэл бөгөөд олон улсын конвенци, нийгмийн амьдралын хэм хэмжээ, хууль журмыг уландаа гишгилсэн үйлдэл мөн”
- Терроризм судлаач Е. Кожушко “Терроризм бол улс төрийн тэмцлийн тактик бөгөөд үзэл суртлын хувьд үйл ажиллагаагаа зөвтгөсөн тогтолцоот шинж чанартай, аллага, хорлон сүйтгэх ажиллагаа, ажил хаялт, хулгайлалт гэх мэт үйл ажиллагаагаар илэрхийлэгдэх хүмүүсийн амьдралын аюулгүй байдал, амьдрал ахуйд заналт учруулалт юм”
- Ираны шашин судлаач Аятулла Таскири “Терроризм бол хүнлэг бус, хууль бус үйл ажиллагаа, хүн төрөлхтөнд тэр тусмаа шашны хувьд ч хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг зөрчсөн хүний аюулгүй байдлын эсрэг чиглэсэн зорилго, чиглэл бүхий бүх л үйлдлийг хэлнэ”
- Доктор Сарфараз Ниази “Терроризм бол улс төрийн зорилгоор үйлдэгдэж буй хүчирхийлэл, тухайлбал аллага, хүн барьцаалах, онгоц барьцаалах, бөмбөгдөх, дэлбэлэх гэх мэт үйлдлийг хэлнэ”⁸⁴ хэмээн тус тус тодорхойлжээ.

Харин Манай улсын хувьд “Терроризмтой тэмцэх тухай хууль”⁸⁵-ийн 3.1.1-д “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагаа” гэж тодорхойлсон байдаг байна.

Энэ тодорхойлолтыг доктор, профессор Ш.Паламдорж АНУ, ОХУ, Их Британи улсууд болон олон улсын судлаачдын тодорхойлолтуудтай харьцуулан үзэхэд нийгэмд бүхэлд нь эсхүл түүний тодорхой бүлэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгын хувьд төсөөтэй боловч төдийлөн оновчтой бус байна хэмээсэн байдаг.

Дэлхийн улс орны олон эрдэмтэн судлаачид “Терроризм” хэмээх энэхүү үгийг янз бүрээр ойлгож, тайлбар хийж, үзэл бодлоо илэрхийлсээр байгаа боловч тодорхой нэгдсэн нэг тодорхойлолтыг одоо хүртэл өгч чадаагүй л байна.

Академич С.Нарангэрэл өөрийн гаргасан “Эрх зүйн эх толь бичиг” бүтээлдээ “Терроризм” гэсэн тодорхойлолтонд:

- Хувь хүн буюу байгууллагад хүч хэрэглэх ба хүч хэрэглэхээр заналхийлэх, түүнчлэн хүмүүсийг үхэлд хүргэх;
- Эд хөрөнгийн үлэмж хохирол аюулыг бий болгосон эд хөрөнгө ба бусад материаллаг объектыг устгах гэмтээх буюу устгаж гэмтээхээр айлган сүрдүүлэх, тэрчлэн нийгэмд аюултай өөр хор уршиг бий болгох;
- Хэрэв өмнө дурдсан үйлдлийг нийгмийн аюулгүй байдал зөрчих, хүн амыг айлгах буюу террористуудад ашигтай шийдвэрийг төр, засгийн байгууллагуудаар гаргуулах, эд хөрөнгийн буюу бусад хууль бус ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхээр нөлөөлөл үзүүлэх;
- Төрийн болон олон нийтийн зүтгэлтний үйл ажиллагааг зогсоох, эсхүл тийм үйл ажиллагаанаас өс авах зорилгоор түүний амь биед халдах;
- Олон улсын хамгаалалтад байдаг гадаад улсын төлөөлөгчид буюу олон улсын байгууллагын ажилтан, тэрчлэн олон улсын хамгаалалтад байдаг этгээдийн албан

⁸⁴ Ц. Дашзэвэг., Д.Чагнаадорж. олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. УБ. 2004. 24-25 дахь тал

⁸⁵ Төрийн мэдээлэл. УБ. 2004. №19

байр, эсхүл тээврийн хэрэгсэлд довтлох эдгээр хэргийг дайн өдөөх буюу олон улсын байдлыг хүндрүүлэх зорилгоор үйлдэх зэрэг үйлдлүүдийг тус тус хамааруулан үзсэн байна.

Иймд терроризм гэдэг төр, олон улсын байгууллага, хуулийн этгээд, хүн амын тодорхой хэсгийг өөрсдийн сонирхолд нийцсэн тодорхой үйл ажиллагаа явуулах, эсхүл ийм үйл ажиллагаанаас татгалзуулах шаардлага тавьж, улмаар нийгмийн тодорхой хэсэг номхон ард иргэд, түүнчлэн төр, засгийн удирдлагад албадлага, шахалт үзүүлэн айдаст автуулахуйц аллага үйлдэх, онц чухал объектуудыг бөмбөгдөх, дэлбэрэх, галдан шатаах, олон зорчигчтой агаарын хөлөг буюу тээврийн хэрэгсэл, барилга байгууламжийг барьцаалах зэрэг нийгэм, хүмүүсийн аюулгүй байдлыг алдагдуулсан, алдагдуулахад чиглэгдсэн харгис хүчирхийлэл юм.⁸⁶

Нөгөө талаараа терроризм гэдэг нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, улс төрийн тэмцлийн арга хэлбэр юм. Түүнчлэн олон улсын терроризм гэсэн ойлголт бас байдаг байна.

Академич С.Нарангэрэл “Олон улсын терроризм”⁸⁷ гэдэг нь улсын ба тэдгээрийн дипломат хэвийн үйл ажиллагааг зөрчиж буюу олон улсын хэлхээ холбоо ба уулзалт, түүнчлэн улс хоорондын тээврийн холбоог хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж, хүмүүсийг утга учиргүй албан хядахад хүргэсэн олон улсын хэмжээний нийгэмд аюултай хэргийн цогц”⁸⁸ хэмээн тодорхойлсон байдаг.

2003 онд болсон “Терроризмын эсрэг” олон улсын бага хурал дээр доктор, профессор, “Терроризмын эсрэг Монголын холбоо”-ны ерөнхийлөгч Ч.Баатар “Олон улсын терроризмын үйл ажиллагаа, түүний мөн чанар” илтгэлдээ “Терроризм – нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах, олон улсын хэмжээний онц чухал объектууд, АЦС, цөмийн болон хими, бактериологийн зэвсгийн үйлдвэрүүдийг эзлэх, халдахыг завдах, ард түмнийг айлган сүрдүүлэх, алан хядах бүлэглэлүүдийн эрх ашгийг хангахуйц шийдвэрийг удирдлагын зүгээс гаргуулах зорилгоор бие хүн болон байгууллагын эсрэг хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгө, бусад материаллаг зүйлсийг гэмтээх, устгах, улс орны дотор улс төр, эдийн засгийн онцгой байдлыг бий болгох, улмаар улс хоорондын харилцааг хүндрүүлэх, дайн үүсгэх эх үүсвэрийг бий болгох, үндэстэн ястнуудын хооронд хагалган бутаргах үйл ажиллагааг санаатайгаар зохион байгуулах явдал юм”⁸⁹ хэмээн тодорхойлсон байна.

Доктор, профессор, Ч.Баатар терроризмын шинж чанар, онцлогийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал:

- Террорист халдлагын онцгой аргууд, түүний дотор хүчирхийлэл үйлдэх, өмч устгах, гэмтээх, эсвэл муу үр дагавар учруулахаар заналхийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл⁹⁰ үйлдэх, тэдний өмч хөрөнгийг устгах аюул учруулах нөхцлийг бий болгох;
- Айдаст автуулах нөхцөл байдлыг зориуд бий болгох
- Террорист халдлагыг нийтэд ил тод сурталчилах
- Зарим нэг субъектын эрх ашигт шууд хор хохирол учруулах

⁸⁶ Ш.Паламдорж. Тэмцлийн шинэ төрлийн хэрэгсэл, түүнээс хамгаалах нь. УБ. 2004. 315 дахь тал

⁸⁷ Олон улсын терроризм - англ. international terrorism; ор. международный терроризм

⁸⁸ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 331 дэх тал

⁸⁹ Терроризмын эсрэг. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ. 2003. 12 дахь тал

⁹⁰ Я. Цэвэл. Тайлбар толь. УБ. 1966. 752 дахь тал. Хүчирхийлэх- хүчирхэх, хүчирхийлэн дарлах, хүчирхийлэх байдал илэрч байна.

- Нийгэмд нэн аюултай байдал бий болох⁹¹

Терроризмтой тэмцэх нь дан ганц нэг улс, байгууллага, хувь хүмүүсийн үйл ажиллагаа бус харин дэлхийн улс орнуудын хамтын идэвхитэй, олон талт арга хэмжээний үр дүнд урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломжтой үйл ажиллагаа юм.

Терроризмтай тэмцэх (англ. *war on terrorism*; ор. *Борьба с терроризмом*) гэдэг нь “террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хор уршгийг саармагжуулах үйл ажиллагаа⁹²” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс гадна терроризм, террор гэсэн 2 ойлголтын талаар хүмүүс тэр бүр ойлгодоггүй. Угтаа “Терроризм” гэсэн ойлголтоос “террор” гэсэн онолын ойлголт үүссэн гэж судлаачын хувьд үзэж байна.

“Орчин үеийн гадаад үгийн оросын тайлбар толь”-д “Террор – улс төрийн дайснаа хүчирхийллийн аргаар дарангуйлах, айлган сүрдүүлэх бодлого, терроризм бол бодлого, террорийн тактик⁹³” гэсэн байхад “Социологийн тайлбар толь”-д нь “Террор нь айлгах, сүрдүүлэх, хүчирхийлэх бодлого, улс төрийн дайснаа алж устгах, гэсгээн шийтгэх, харгис хэрцгий чанар, чиглэл зорилгот байдал, үр дүн зэргээрээ тодорхойлогдох улс төрийн хүчирхийллийн онцгой хэлбэр” гэжээ.⁹⁴

Харин академич С.Нарангэрэл “Террор гэдэг нь эрх баригч дэглэм буюу түрэмгийлэн эзлэн авагчдын зүгээс бөөнөөр нь залхаан цээрлүүлэх арга хэмжээ авах замаар улс төрийн талаар айлган сүрдүүлж, бие махбодийн хувьд устгах, алах хүртэл хүч хэрэглэх”⁹⁵ хэмээн тодорхойлсон байна.

Дээрхи дэлхийн улс орнуудын эрдэмтэн судлаачдын “Терроризм”-ыг тодорхойлсон тодорхойлолтуудаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

Терроризм нь зорилгын хувьд улс төр, шашин, үзэл суртлын агуулгатай байх бөгөөд гүйцэтгэж буй арга нь хүчирхийллийн бүхий л үйлдлийг ашиглаж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдах, нийгэмд айдас, түгшүүр төрүүлэх замаар зорилгодоо хүрч буй хууль бус үйлдэл гэдэг нь харж болох юм.

Гэвч өнөөдөр дэлхийн улс орнуудын эрдэмтэн судлаачид “терроризм”-ын талаар нэгдсэн нэг тодорхойлолтонд хүрч хараахан чадаагүй байгаа ч агуулгын хувьд нэгдмэл нэг ойлголтонд хүрч чадсан гэж үзэж болохоор байна.

⁹¹ Ч. Баатар. Терроризм, аюулгүй байдал. УБ. 2006. 8 дахь тал

⁹² С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 402 дахь тал

⁹³ Словарь иностранных слов. М., “Русский язык”. 1988. – 680 стр

⁹⁴ Ш. Паламдорж. Терроризм, түүнээс сэргийлэх. УБ. 2003. 9 дэх тал

⁹⁵ С. Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008. 402 дахь тал

ОЛОН НИЙТЭД ТҮШИГЛЭСЭН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСОНГУЙ БОЛГОХ НЬ



*Г.Бямбадорж
ХСИС-ийн, Цагаагийн сургуулийн, цагдаагийн
эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант*

Цагдаагийн байгууллагын тухай хууль нь хорь гаруй жил мөрдөгдөн хэрэгжихдээ цагдаагийн байгууллагын бүтэц тогтолцоо, зарчим, чиг үүрэг, эрх хэмжээ, алба хаагчийн эрх зүйн байдал, албаны үйл ажиллагааг тогтворжуулж, материал-техникийн хувьд бэхжүүлэн, цагдаагийн албыг өргөжин хөгжихөд чухал нэмрээ оруулсан юм.

Гэвч өнөөдөр цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа шинэчлэл хийхгүйгээр өнөөгийн шаардлагын түвшинд хүрэхгүй нь ойлгомжтой байна.

Ийм учраас гэмт явдлын шалтгаан, нөхцлийг тогтоох ажлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд олон нийтийг өргөнөөр татан оролцуулж, “Secure alert” буюу цахим хянагч “Электрон гав”, Полиграф, JPS, Comp.stat, Crime mapping, ССТҮ зэрэг орчин үеийн smart системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр хууль сахиулах салбарт иноваци хийх шаардлагатай байна⁹⁶.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол улсын хуулийн 3 дугаар бүлгийн 12 дугаар зүйлийн 1-д “Нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулахыг хуульчлан заасан юм. Үүнд:

1. Иргэдийг нийтийн эргүүлд гаргах
2. Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрийг томилох
3. Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах⁹⁷ гэсэн гурван хэлбэрээр иргэдийн татан оролцуулах тухай заасан байна.

Мөн шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуульд иргэний хяналтын зөвлөл, цагдаагийн албаны үйл ажиллагааны зарчим, нутгийн өөрөө удирдах

⁹⁶ Нийслэл хотын аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сэдэвт зөвлөгөөний эмхтгэл, УБ 2014. 6 дахь тал

⁹⁷ Ж.Долгосүрэн “Монгол улсын Цагдаагийн эрх зүй” УБ хот 2004 он 269 дэх тал

байгууллагаас иргэдтэй харилцан хамтран ажиллах, нийтийн хэв журам сахиулах үүрэг бүхий олон нийтийн цагдаагийн ажилтан ажилуулах зэрэг шинэ заалт оруулсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд түшиглэж, олон нийтийн оролцоотойгоор өргөн хүрээтэй явуулах эрх зүйн үндэсийг шинээр хуульчилжээ.

Мөн олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа буюу “Community oriented policing” анх удаа цагдаагийн албаны тухай хуульд хуульчилж олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг бэхлүүлэн тогтмолжуулах, хөгжүүлэх талаар заасан нь цагдаагийн байгууллагын “Олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах”, “төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан ажиллах” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллах чухал заалт болжээ гэж бид үзэж байна.

Гадаад орнуудын цагдаагийн байгууллага гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхдээ ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ямар туслалцаа дэмжлэг авдаг талаар товчхон авч үзвэл.

Олон нийтийн цагдаа нь: АНУ-д 1994 онд Хууль сахиулах тухай хуульд олон нийтийн оролцоог бодлогоор дэмжих зорилгоор олон нийтийн цагдаагийн албыг бий болгож олон нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, нийгмийн эмх замбараагүй байдал, олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсгэж байгаа нөхцөл байдлыг нэн даруй шийдвэрлэх, олон нийтрүү чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хэв журам сахиулах үүрэгтэй орон нутгийн гишүүдтэй нягт хамтран ажиллахад гол анхаарлаа хандуулж байгаа цагдаагийн нэг стратеги юм⁹⁸.

Сингапур улсын цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цагдаагийн гэрээт ажилтан олноор ажиллуулж цалин олгодог. Мөн “Цагдаагийн фонд” байгуулан цагдаагийн ажилтан илүү цаг ажиллах, тэтгэвэрт гаргах, гачигдалтай үед нь туслах зэргээр зарцуулдаг.

Герман улсад тэнгисийн цагдаа, Оросын холбооны улс татварын цагдаатай бөгөөд тэд цагдаагийн бүрэлдэхүүнд ордоггүй бөгөөд тусгай хуулиар үйл ажиллагааг нь зохицуулдаг.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын үр нөлөө цагдаагийн ажилд иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс үзүүлэх туслалцаа, тэдгээрийн хамтын ажиллагаанаас ихээхэн хэмжээгээр хамаардаг болохын дээрхи улс орнууд харуулж байна.

Иймд аймаг дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллахын тулд хэсгийн ахлагч нарыг цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлд анхаарч дараах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана. Үүнд:

- Сэжигтэй хүн, эд зүйл бүртгэх
- Мэдээ, мэдээлэл олох \шинэ хуучин\
- Тухайн газар оронд шилжин ирсэн хүмүүсийг бүртгэх, тэдгээрийн мэдээлэл цуглуулах, цэг газрын хяналтанд авуулах
- Гэмт хэрэгт хохирсон хүнийг олж тогтоох
- Галт зэвсэг, сум хэрэгсэл, түүх дурсгалын зэрэг бусад эд зүйлийн эзэмшигч
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөл арилгах
- ЦБ-ын хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох гэх мэт.

⁹⁸ n.wikipedia.org/wiki/Community_policing

Гэхдээ эрх үүргийг хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд эерэг үр дүн гарах боломжтой ч гагцхүү үйл ажиллагаагаа хэрхэн яаж олон нийтэд түшиглэн зөв оновчтой зохион байгуулахаас шалтгаална.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа байнгын мэдээлэлтэй байх нь энэхүү үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болно.

Ингэхийн тулд хэсгийн ахлагч цагдаагийн ажилтан нь иргэд оршин суугчидтайгаа холбоотой байж иргэдэд үйлчилснийхээ хэрээр ард иргэдээсээ дэмжлэг тусалцаа авч хамтран ажиллах ажил хэрэгч холбоо тогтоох нөхцлийг бүрдүүлж ажиллах нь чухал юм.

Хэсгийн ахлагч иргэдээс мэдээлэл авч ажиллах нь нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлан мэдэж цагдаагийн байгууллагын хэсгийн байцаагчийн ажилд тусалснаар нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг үнэлэж дүгнэх, гэмт явдлын прогноз гаргах, цаашид гэмт хэрэгтэй тэмцэх ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тодорхойлж, түүнийг цаг алдалгүй таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлнэ.

Үүссэн нөхцөл байдлыг дагаж урьдчилан сэргийлэх ажлыг объектруугаа хандуулж хийнэ гэвэл амжилтанд хүрэхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Харин хэсгийн ахлагч иргэдээс мэдээлэл цуглуулж бусад алба хаагч нарын хамт түүндээ дүн шинжилгээ хийж үүсэх нөхцөл байдлыг урьдчилан мэдэж түүний эсрэг арга хэмжээ авах нь бидний үйл ажиллагаа амжилтанд хүрнэ.

Гэмт хэрэг үйлдэгсдийн дотор орон нутгаас шилжин ирсэн тодорхой оршин суух хаяггүй, ажил сургуульгүй хүмүүсийн эзлэх хувийн жин өсч орон нутгаас нийслэлрүү шилжсэн хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас засаг захиргаа завсардагсад орлогын их үүсвэргүй иргэд бүлэг зохион байгуулалттай хэлбэрт шилжин хот хөдөөг дамжин гэмт хэрэг үйлдэх болсноор хүнд онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт эрүүгийн ба хэв журмын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх боллоо.

Иймд нутаг дэвсгэр хариуцсан алба хаагч, хэсгийн ахлагч нар нь тухайн нутаг дэвсгэрийн онцлог объект, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд, тэдний хань харилцаа, түр оршин суугч явуулын хүмүүсийн үйл хөдөлгөөнд нь анхаарлаа төвлөрүүлж тэднийг хяналтандаа авч онцгой анхаарч ажиллавал гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил болон гарсан гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн тустай.

Шинэчлэн найруулсан цагдаагийн албаны тухай хуулийн 25.2-д “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэний тусалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна” гэж заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд түшиглэх, иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоожээ.

Иймд хэсгийн ахлагч нарыг цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд дараах хэлбэрээр хамтран ажиллаж болно гэж үзэж байна. Үүнд:

1. Гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх үүнд:

- Гэмт хэрэгт хохирсон хүний талаар
- Зөрчил гаргасан этгээдийн талаар
- Эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар
- Тээврийн хэрэгсэл эзэмшигчийн талаар
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналтад байгаа хүний талаар
- Төрийн тусгай хамгаалалтад байгаа хүний талаар

- Галт зэвсэг эзэмшигчийн талаар
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн талаар
- Орчиндоо байнга тааламжгүй байдал гаргадаг хүмүүсийн талаар
- Бүлэг бөөгнөрөл үүсгэж байгаа хүмүүсийн талаар мэдээлэх г.м.

2.Гэмт хэрэг, зөрчил гарах нөхцөл бүрдүүлэхгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах:

- Иргэн өөрийн амьдарч буй орчин тойрондоо гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдүүлэхгүй байх талаар шаардлага тавих, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах
- Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газрын талаар мэдээлэл өгөх
- Ийм нөхцөл бүрдсэн үед үйлдэгдэж болзошгүй газарт тусгай тэмдэглэл хийх, тусгаарлах зурвас татах г.м.

3.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд оролцох:

- Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон бусад зорилгоор зохион байгуулж байгаа төрөл бүрийн нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээнд оролцох
- Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, иргэд байгууллагын эд хөрөнгө, улсын онц чухал объект хамгаалах үүрэг гүйцэтгэхэд оролцох г.м.

4. Олон нийтийн оролцоог хангах

- Иргэдэд цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллахын ач холбогдлыг ойлгуулах
- Урамшуулалын хэмжээг нэмэгдүүлэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд таниулах, ухуулга сурталчилгааг сайтар явуулах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулахад оролцох
- Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14-р зүйлд зааснаар “Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага иргэдээс төлбөртэй авч болно” гэсэн хуулийн заалтыг үндэслэн иргэдээс мэдээлэл авах талаар ухуулан сурталчилж иргэдээс мэдээлэл төлбөртэй авах ажлыг тогтмолжуулах зэрэг болно.

Иргэдээс гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл төлбөртэй авах нь гэмт хэрэг илрүүлэх болон нуугдмал гэмт явдлыг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажил иргэдийг татан оролцуулах чухал ажлын нэг юм.

Цагдаагийн байгууллага иргэдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах ажил төв орон нутгийн цагдаагийн байгууллагын хэмжээнд харилцан адилгүй жигд бус байгаа нь гэмт хэргийн илрүүлэлт, нуугдал гэмт явдлыг илрүүлэх ажилд сөргөөр нөлөөлж байна.

Иймд энэхүү ажлыг улам идэвхижүүлж тогтмолжуулах шаардлагатай байна. Нөгөө талаар энэхүү ажлын үр дүн цагдаагийн байгууллагаас шалтгаалахгүй байж болно. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний

40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалт огт хэрэгжихгүй байна.

Тиймээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.1-д заасан 40 хувьтай тэнцүү хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн цагдаагийн байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ гэж өөрчлөн найруулж, цагдаагийн байгууллагын төсөвт гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгө мөнгийг тусгайлан суулгаж өгөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих сан байгуулж ажиллах шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд хэсгийн ахлагч нарыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд оролцуулахад шат шатны байгууллагууд нэгдсэн нэг зорилго чиглэлтэй ажиллах, иргэдийг цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах хүсэл сонирхлыг нь нэмэгдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцож байгаа иргэдийг урамшуулах тал дээр анхаарах, энэ асуудалд бусад төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжиж оролцуулах нь зүйтэй байна.

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАХ ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ



Б.Нармандах
Монголын Үндэсний тагнуулын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), дэд хурандаа
Г.Хулан
Монголын Үндэсний тагнуулын академийн сонсогч

*“...Хэн боловч өөрийн үзэл бодолтой байж,
түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй...”*
Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал 19 дүгээр зүйл

Оршил

Хүний эрхийн ойлголт, түүнийг тодорхойлох асуудал нь эрх зүй судлалын үндсэн асуудал мөн бөгөөд хүний эрхийг хангахыг хүсвэл нэн түрүүнд түүний агуулга, мөн чанарыг танин мэдэх нь чухал.

Хүний эрхийн мөн чанарын тухайд энэ нь хүний хүсэл, эрмэлзлэл, төрөлх мөн чанараас үүсэлтэй юу, эсхүл нийгэм, хүний хөгжлийн түвшингээс хамааралтай юу гэх зэргээр өөр өөрөөр ойлгож, агуулга, мөн чанарыг адилтган авч үзэх, тэдгээрийн ялгаа заагийг орхигдуулах зэргээр судалж иржээ. Энэ нь хүний эрхийг ойлгож, тодорхойлох онол, арга зүйтэй холбоотой бөгөөд өнөөдөр ч хүний эрх шинжлэх ухааны судлагдахуун болохын хувьд харьцангуй шинэ тутам асуудал байсаар байна.

Бид энэ удаад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн нэг хэлбэр болох **өлсгөлөн зарлах эрх**-ийн хэрэгжилт Монгол Улсад ямар түвшинд байгаа талаар авч үзэж, өөрсдийн байр сууриа илэрхийлэхийг зорилоо.

Ухагдахуун болох талаас нь авч үзвэл:

Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь аливаа үзэгдэл, үзэл санаа, онол, улс төрийн урсгалд итгэх, шүтэн бишрэх, илэрхийлэх эрх чөлөө мөн бөгөөд итгэл үнэмшил нь агуулгын хувьд үргэлж баяжиж, өөрчлөгддөг чанараараа хүнийг нийгмийн бүтээгдхүүн болгох талыг нь түлхүү харуулах хэдий ч үзэл бодлыг бодвол амархан өөрчлөгдөөд байдаггүй нэлээд суурь шинжтэй ойлголт юм. Харин хүний үзэл бодол бол улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөө гэсэн нийгмийн олон хүрээг хамарч байдаг онцлогтой.

Итгэл үнэмшил, үзэл бодол нь ахуйн тусгал боловч хувь хүний ухамсар, боловсролоос хамааран өөр өөрийн онцлогтойгоор төлөвшиж илэрнэ. Ингэхдээ уг эрх нь бүх нийтийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, иргэдийн эрүүл мэнд, ёс суртахуун болон бусдын эрх, эрх чөлөөнд хохирол учруулах ёсгүй гэсэн хязгаартайгаар хэрэгжинэ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь улс гүрний хил хязгаарыг үл харгалзан амаар буюу бичгээр, хэвлэлээр хэвлэн нийтлэх, уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх, ажил хаях, өлсгөлөн зарлах зэрэг хэлбэрээр хэрэгждэг байна.⁹⁹

Монгол хэлний хураангуй тайлбар толь бичигт¹⁰⁰ тодорхойлсноор “Өлсгөлөн” гэдэг нь:

“1. Хоол ундгүй болон хоол ундаар хомс байдал

2. Өлсгөлөн зарлах гэдэг нь эсэргүүцлийн тэмдэг болгон хоол идэхээс татгалзах байдал” хэмээн тодорхойлжээ.

Хүний эрхийн Үндэсний комиссын мэргэжилтэн Б.Батаагийн “Цагдан хорих байранд өлсгөлөн зарлах явдал ба тулгамдаж байгаа асуудлууд” хэлэлцүүлэгт тавьсан “Хүний эрх, эрх чөлөө ба өлсгөлөн” сэдэвт илтгэлд¹⁰¹ “Өлсгөлөн зарлах нь тухайн хүн өөрийн сонголтоор ухамсартайгаар хоол идэхээс татгалзах явдал бөгөөд энэ нь хүчирхийллийн бус аргаар өөрийн үзэл бодлоо хамгаалах, тэмцэх бусдад нөлөөлөх үүднээс ганцаараа буюу бүлэглэн явуулж буй үйл ажиллагаа юм” гэж тодорхойлжээ.

Харин олон улсын чөлөөт тайлбар толь **Wikipedia**¹⁰²-д “Өлсгөлөн зарлах гэдэг нь тайван замаар эсэргүүцлээ илэрхийлэх арга бөгөөд түүнд оролцогчид нь тодорхой зорилгод тулгуурлан улс төрийн эсэргүүцэл үзүүлэх эсвэл бусдын буруутай үйл ажиллагааг илчлэхээр мацаг барих явдал” хэмээн тодорхойлсон байна.

Дээрх хоёр тодорхойлолтоос авч үзэхэд **Өлсгөлөн зарлах эрх нь нэг буюу хэд хэдэн хүн өөрсдийн улс төрийн үзэл бодлоо хамгаалан, хэн нэгний буруутай үйл ажиллагааг илчлэхийн тулд хооллохоос татгалзаж байгаа үйлдэл, эс үйлдлээр илэрнэ.** Өлсгөлөн зарлагч уул эрхэнойтон, хуурай, хагас өлсгөлөн /идэхгүй хоолоо зарлах, идэх хоолоо зарлах/ хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

Эрх зүйн зохицуулалтын талаас нь авч үзвэл:

Өлсгөлөн зарлах эрхийг баталгаажуулсан эрх зүйн баримт бичгийг судлан авч үзвэл олон улсын түвшинд 1975 оны Токиогийн тунхаглал, 1991 онд Мальтад болж өнгөрсөн 43 дугаар их хурлаар баталсан Мальтийн тунхаглал баталж, мөн 1992 оны

⁹⁹ Монгол Улсын Хүний эрхийн комисс. “Хүний эрх” сэтгүүл, У Бхот., 2014. 58 дахь тал

¹⁰⁰ Я.Цэвэл., Монгол хэлий тайлбар толь., 1956 он., Улаанбаатар хот., ... тал

¹⁰¹ http://en.wikipedia.org/wiki/Hunger_strike

¹⁰² Монголын хүний эрхийн үндэсний комисс., Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхтгэл., Улаанбаатар хот., 2014 он., 150 дахь тал

Испанид болсон уг хурлаар оруулсан нэмэлт өөрчлөлт, хамгийн сүүлд 2006 оны Өмнөд Африкт болсон 57 дугаар хурлаар оруулсан өөрчлөлт зэрэг багтана.

Дээрх эх сурвалжуудаас ӨЛСӨГЛӨН ЗАРЛАГЧДЫН ТАЛААРХ МАЛЬТИЙН ТУНХАГЛАЛД өлсгөлөн зарлагчидтай холбоотой гол зарчмууд тусгагджээ. Үүнд:

- ✓ Ёс зүйтэй хандах үүрэг.
- ✓ Бие даасан байдлыг хүндэтгэх.
- ✓ Ач тус ба гэм хор
- ✓ Хосолмол үнэн ч байх үүргээ тэнцвэртэй хадгалах.
- ✓ Эмнэлгийн хараат бус байдал
- ✓ Итгэмжлэл
- ✓ Итгэл хүлээх гэх мэт зарчимуудыг тунхаглажээ.

Мөн уг тунхаглалын 12 дугаар зүйлд Хиймлээр хооллох, 13 дугаар зүйлд Албадан хооллох талаар тусгасан байна.

Хүчээр хооллохыг ёс зүйн хувьд огт хүлээн зөвшөөрч болохгүй. Хэдийгээр сайн санааны тулд байсан ч айлган сүрдүүлэх, шахан дарамтлах, хүчээр буюу биеийг барьж хорьх, хооллох нь хүнлэг бус, гутаан доромжилсон харьцаа мөн. Түүнтэй мөн адилаар өлсгөлөн зарлагчдад шахалт, дарамт үзүүлж, өлсгөлөнг зогсоох зорилгоор бусад хоригдыг албадан хооллох нь хүлээн зөвшөөрөгдөшгүй харьцаа юм.

Өлсгөлөн зарлах эрхийн үндэсний эрх зүйн зохицуулалтын талаар авч үзвэл Монгол улсын Үндсэн хууль¹⁰³, Жагсаал цуглаан хийх журамын тухай хууль¹⁰⁴, Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль¹⁰⁵, Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар¹⁰⁶, Хорих ангиудын дотоод журам, Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам болон ШШГЕГ-аас гаргасан бусад шийдвэр зэрэг эх сурвалж багтаж байна.

Эдгээрээс Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд хүний итгэл үнэмшилтэй байх эрхийг хуульчлан баталгаажуулж, түүний дагуу иргэд үзэл бодлоо өөрийн сонгосон аливаа хэлбэрээр, чөлөөтэй илэрхийлэх, итгэл үнэмшлээ хамгаалах эрхтэй болох нь тунхаглагдсан байна. Энэ эрх нь олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд жагсаал цуглаан хийх, өлсгөлөн зарлах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан өөрийн үзэл бодлоо илэрхийлэх гэх мэт хэлбэрүүдээр илэрч, хэрэгжинэ.

Эдгээрээс өлсгөлөн зарлах нь *Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлд “8.6. Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно.”* Гэсний дагуу хязгаарлагдана. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан *“Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”* хэмээн хуульчилсантай холбоотой байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлд: *“15.4. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчиж өлсгөлөн зарлахыг уриалсан буюу зохион байгуулсан гэм буруутай байгууллагад 150000-250000 төгрөгөөр торгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнд 20000-50000, албан тушаалтанд 25000-50000 төгрөгөөр торгох, эсхүл 14-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна”* хэмээн уг эрхийн хязгаарыг зөрчсөн

¹⁰³Төрийн мэдээлэл, Улаанбаатар хот., 1992 № 01

¹⁰⁴Төрийн мэдээлэл, Улаанбаатар хот., 1994 № 08

¹⁰⁵Төрийн мэдээлэл, Улаанбаатар хот., 1994 № 05

¹⁰⁶<http://www.legalinfo.mn/annex/details/3666?lawid=8362>

тохиолдолд хүлээлгэх санкцыг тодорхойлжээ. Энэ нь Үндсэн хуулийн 19зүйлийн :дахь хэсгийн биелэлтийг хангахад чиглэгдэж байна.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 36 дугаар зүйлд хоригдож байгаа этгээд өлсгөлөн зарласан үед мөрдөх журам, зохион байгуулалтын шинжтэй зарим хэм хэмжээг тусгасан байна.**Түүнчлэн хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журамын тухай хуулийн 2 зүйлд¹⁰⁷, Хорих байрны дотоод журмаар уг эрхийг хангахад чиглэгдсэн зарим хэм хэмжээг тогтоож өгсөний дагуу энэ эрх нь хангагдаж хамгаалагддаг байна.**

Эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг авч үзвэл:

Өлсгөлөн нь янз бүрийн нөхцөл байдалд болдог ч ихэвчлэн хүмүүс эрх чөлөөгөө хязгаарлуулан хоригдсон нөхцөлд /шорон, гяндан, цагаач, дүрвэгчдийг төвлөрүүлсэн хуаран/ түвэгтэй байдал үүсгэдэг. Өлсгөлөн нь ихэнхдээ өөрсдийн шаардлагыг хүргэх өөр бусад арга хэрэгсэл хэрэглэх боломжгүй хүмүүсийн шаардлагаа хүргэх нэг хэлбэр болдог. Өөрөөр хэлбэл өлсгөлөн зарлагчид ихээхэн хугацаагаар хоол тэжээл авахаас татгалзсанаар гол төлөв эрх баригчдын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх замаар тодорхой зорилгод хүрэх найдвар тавьдаг.

Удаан хугацаагаар хоолоо хорих нь амь насанд халтай буюу өлсгөлөн зарлагчид засварлашгүй хохирол учруулах эрсдэлтэй бөгөөд эмч нарын үнэт зүйлд зөрчил үүсгэж болдог. Өлсгөлөн зарлагчид их төлөв үхэх гэж зорьдоггүй боловч зарим нь зорилгодоо хүрэхийн тулд амь насаараа дэнчин тавихад бэлэн байдаг байна.

Өлсгөлөн зарлах эрхийн хэрэгжилтийн талаарх олон улсын нөхцөл байдлыг сурвалжлан үзвэл хамгийн анх Христ Ирландад шударга бус зүйлийг эсэргүүцэн өлсгөлөн зарлаж байжээ.¹⁰⁸ Үүнийг Troscaid эсвэл Cealachan гэж нэрлэдэг бөгөөд өлсгөлөнгийн талаар зохицуулсан зохицуулалт хүртэл байсан ба тухайн үеийн эрдэмтэд хэн нэгэн өлсгөлөн зарласаны улмаас үхэх ёсгүй харин тэдний эрүүл мэндийг анхаарах ёстой хэмээн үзэж байсан юм.¹⁰⁹ Дэлхийн түүхэн дэх өлсөх эрхийн хэрэгжилтийн талаар з сурвалжлан үзвэл:

1. Gandhi and Bhagat Singh /Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө Mahatma Gandhi/
2. Amarajeevi Sriramulu / Энэтхэгийн мужуудыг нэгтгэхийн тулд 57 хоног өлсгөлөн зарласан/
3. British and American suffragettes / Их британ, Америкид хоригдлууд эрхээ хамгаалахын тулд шоронд өлсгөлөн зарласан/
4. Irish republicans / хоригдлууд эрхээ хамгаалахын тулд зарласан өлсгөлөн/ зэргийг нэрлэж болно. /Зарим өлсгөлөнгийн талаарх мэдээллийг хүснэгтлэн оруулав./

Name	Paramilitary affiliation	Strike started	Date of death	Length of strike	Reason for imprisonment
------	--------------------------	----------------	---------------	------------------	-------------------------

¹⁰⁷ 2.11.Хорих ангид бий болсон дараахь нөхцөл байдлыг онцгой учралд тооцно, 2.11.2.хорих ангийн дотоод журам, захиргааны шаардлагыг зохион байгуулалттайгаар эсэргүүцэх, нийтийг хамарсан суулт хийх, өлсгөлөн зарлах;

¹⁰⁸ David Beresford, Ten men Dead, NY.,1987, page 6.

¹⁰⁹ http://en.wikipedia.org/wiki/Hunger_strike

<u>Bobby Sands</u>	IRA	1 March	5 May	66 days	Possession of a handgun
<u>Francis Hughes</u>	IRA	15 March	12 May	59 days	Various offences, including the killing of a soldier
<u>Raymond McCreesh</u>	IRA	22 March	21 May	61 days	Attempted murder, possession of a rifle, IRA membership
<u>Patsy O'Hara</u>	INLA	22 March	21 May	61 days	—Possession of a hand grenade
<u>Joe McDonnell</u>	IRA	8 May	8 July	61 days	Possession of a firearm
<u>Martin Hurson</u>	IRA	28 May	13 July	46 days	Attempted murder, involvement in explosions, IRA membership
<u>Kevin Lynch</u>	INLA	23 May	1 August	71 days	Stealing shotguns, taking part in a punishment shooting
<u>Kieran Doherty</u>	IRA	22 May	2 August	73 days	Possession of firearms and explosives, hijacking
<u>Thomas McElwee</u>	IRA	8 June	8 August	62 days	Manslaughter
<u>Michael Devine</u>	INLA	22 June	20 August	60 days	Theft and possession of firearms

Эдгээрээс Ирландын өлсгөлөн хэмээн алдаршсан 1981оны өлсгөлөн нь Умард Ирландын хоригдлуудын эсэргүүцлийн үйл ажиллагаа байжээ. 1976 оноос Их Британы тусгай ангиллын хагас цэрэгжсэн хоригдлууд эсэргүүцлээ илэрхийлж эхэлсэн бөгөөд 1978 он гэхэд хоригдлуудад ирэх дарамт улам ихэссээр байсан тул хоригдлуудын тэмцэл хүчээ авсан байна. Эхний өлсгөлөн 1980 онд 7 хоригдлын 53 хоногийн өлсгөлөнгөөр дуусгавар болсон бөгөөд өлсгөлөнгийн үер хоригдлууд “таван эрэлт хэрэгцээ” хэмээн алдаршсан дараах асуудлуудыг баталгаажуулахыг хүсч байсан байна. Үүнд:

1. Шоронгийн хувцас өмсөх нь буруу

2. Хорих ангид албадан хөдөлмөр эрхлэх нь буруу
3. Боловсрол, амралт, цэнгээний арга хэмжээ зохион байгуулах, бусад хоригдлуудтай чөлөөтэй харилцах
4. 7 хоногт нэг удаа эргэлт авах
5. Өршөөлд хамрагдах гэх мэт.

Эсэргүүцлийн хоёр дахь өлсгөлөн 1981 онд газар авч уг өлсгөлөнг дэмжин улс төрийн намын 10000 хүн тайван жагсаал хийж дэлхий нийтийн анхаарлыг маш ихээр татаж байжээ.

Монгол Улсын тухайд одоогоос 25 жилийн өмнөх буюу 1990 оны гуравдугаар сарын 7-нд Монголын улс төрийн хамгийн том өлсгөлөнг зохион байгуулсан. МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн 10 гишүүн анх өлсгөлөн зарлахыг санаачилж, Сүхбаатарын талбайд эхлүүлж байжээ. Тодруулбал, энэ өлсгөлөнд Д.Батбилэг, Э.Бат-Үүл, З.Эрдэнэбат, И.Жавхлант, Д.Дорлигжав, Б.Галсандорж, Д.Энхбаатар, Г.Бошигт, Д.Нинж, н.Батцэнгэл нар оролцсон байна.

Энэ нь ардчилагчдын социалист дэглэмийг халах зорилготой өлсгөлөн байсан бөгөөд энэ нь өнөөдрийг хүртэл үнэ цэнээ алдаагүй, хамгийн үр дүнтэй тэмцэл болсон байна. Энэ нь нийтийн эрх ашгийн өмнөөс дуугарч, тэмцлээ илэрхийлснээр бүхэл бүтэн нийгмийн тогтолцоог өөрчилж чадсан үр дүнг авчирсан.

Тэр цагаас хойш өнөөг хүртэл Монгол Улсын тухайд ард түмний анхаарлыг татсан нийгэм, улс төр, хувийн сэдэл бүхий олон олон өлсгөлөн зарлах үйл явдал болж ирсэн бөгөөд заримыг нь тоймлон авч үзвэл:

1. 1998 оны “Г.Бошигтын нэгдсэн хөдөлгөөн” –ийхөний улс төрийн тогтворгүй байдалтай холбогдуулан зарласан өлсгөлөн
2. 2006 оны аравдугаар сарын Дампуурсан ХЗХ-ны болон “САПУ” худалдааны төвийн хохирогчид хамтран Сүхбаатарын талбайд зарласан өлсгөлөн. Тэд хохирлоо барагдуулж авахын тулд ийн тэмцсэн. Гэвч одоо болтол хохирлоо бүрэн барагдуулж аваагүй хүн олон байгаа.¹¹⁰ 2008 оны есдүгээр сарын 5-ны “Долдугаар сарын 1”-ний үймээний үеэр амиа алдсан таван хүний хэрэгт Эргүүл хамгаалалтын газрын VI тасгийн есөн алба хаагчийг сэжигтнээр татаж хорьсон. Тэд прокурорын шийдвэрийг эсэргүүцэн шоронд өлсгөлөн зарлаж байхад ээжүүд нь хүүхдүүдээ суллахыг шаардаж, Сүхбаатарын талбайд гэр барьж өлсгөлөн зарлажээ.
3. 2008 оны долоодугаар сарын 6-ны Жагсаал цуглаан зохион байгуулж, нийтийг хамарсан эмх замбараагүй бий болгосон гэж одоогийн УИХ-ын гишүүн Ж.Батзандан, ШӨХТГ-ын дарга асан О.Магнай, БНН-ын дарга Б.Жаргалсайхан нарыг баривчилж, “зандалчлах” гэсэн зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэснийг эсэргүүцэж “Ганц худаг”-т зарласан өлсгөлөн
4. 2011 оны зургаадугаар сарын 29-нд Уул уурхайн компаниуд гал нээсэн хэргээр хоригдсон “Гал үндэстэн” холбооны Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Мөнхбаяр, Ц.Энхбаяр, Г.Болдбаатар, өмгөөлөгч Г.Дашдэмбэрэл нар Өөрсдийг нь хууль бусаар хорьсон, гадаадын хөрөнгө оруулагчид, уул уурхайн компаниуд ард түмнийг мөлжиж буйг эсэргүүцэн зарласан өлсгөлөн
5. 2010 оны дөрөвдүгээр сарын 8-ны “Амлалт нэхэх ард түмний холбоо”-ны тэргүүн, одоогийн УИХ-ын гишүүн Д.Батцогт, тус холбооны ерөнхий зохицуулагч УИХ-ын гишүүн Г.Уянга, “Миний Монголын газар шороо” хөдөлгөөний тэргүүн П.Болд,

“Үндэсний соёмбо” хөдөлгөөний тэргүүн Б.Лхагважав, “Эрс шинэчлэл” хөдөлгөөний тэргүүн Д.Ганбаатар, “Үндэсний хас” хөдөлгөөний тэргүүн Ш.Нанжид, Ардчилсан хувьсгалын анхны 13-ын нэг гэх Д.Нинж нарын долоон хүн тухайн үеийн хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааг эсэргүүцэж, огцрох шаардлага тавьж Сүхбаатарын талбайд зарласан өлсгөлөн

6. 2012 оны тавдугаар сарын 4-ний Ерөнхийлөгч байхдаа албан тушаалаа урвуулан ашиглаж, төрийн өмчийг хувьдаа завшсан хэргээр Төв аймаг дахь ШШШЕГ-ын харьяа Цагдан хорих төвд хоригдсон МАХН-ын дарга Н.Энхбаярын зарласан хуурай өлсгөлөн
7. 2012 оны тавдугаар сарын 31-ний ШШШЕГ-ын харьяа Багануур дүүрэг дэх 427 дугаар хорих ангид ял эдэлж байгаа “Глоб кредит” ХЗХ-ны захирал асан Ж.Мэндбаяр дэглэм бууруулахыг шаардаж, зарласан өлсгөлөн
8. 2012 оны арван нэгдүгээр сард Хөвсгөл, Говь-Алтай аймаг, Сүхбаатар, Налайх дүүргийн МАХН-ын хорооны гишүүд орон нутгийн сонгуульд нэр дэвшигчээр бүртгэсэнгүй гэж зарласан өлсгөлөн
9. 2013 оны нэгдүгээр сард МАХН-ын дарга, Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг шоронгоос эмнэлэг рүү шилжүүлэх, хэргийг нь цагаатгахыг шаардаж хагас сар орчим үргэлжилсэн ээжүүдээс зарласан нойтон өлсгөлөн¹¹¹ зэргийг дурдаж болно.

Энэ практик нэг талаараа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хамгаалах боломжийг иргэдэд олгож ирснийг харуулж байна. Нөгөө талаас монголчууд энэ эрх чөлөөгөө хэтэрхий их эдэлснээс ч тэр үү, өөрт тулгарсан асуудал бүрийг өлсгөлөн, суултгүйгээр төсөөлж чадахаа болиход хүрээд байгааг харуулж байна.

Монголчуудад өлсгөлөн зарлах шалтгаан мундахгүй болжээ. Тухайлбал:¹¹²

- ✓ сонгуульд нэр дэвшүүлсэнгүй,
- ✓ намыг минь бүртгэсэнгүй,
- ✓ хууль хяналтын байгууллага шударга бус шийдвэр гаргалаа,
- ✓ хийгээгүй хэргийнхээ төлөө өндөр ялаар шийтгүүллээ,
- ✓ бүр хувийн компани лангууныхаа түрээсийн үнийг нэмлээ гэж өлсгөлөн зарлаж, үхэхээрээ айлгасан хүмүүсийн тухай мэдээлэл үргэлжилсээр байна.


Цаашид юм л бол өлсгөлөн зарлаад хэвтчихдэг энэ үйлдэлд хязгаар, хориг тавихгүй л бол үхэхээрээ айлгагсдын тоо олширсоор л байх нь.

Эдгээрээс шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлж байх үедээ өлсгөлөн зарлагчдын талаар тухайлан авч үзвэл :

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын 7 хоног тутмын Харуул хамгаалалт, ялтан, хоригдогсдын хөдөөлгөөний мэдээнд дурдсанаар: ШШШЕГ-ын хэмжээнд давхардсан тоогоор 2012 онд 32, 2013 онд 183, 2014 онд 191 сэжигтэн, яллагдагч зүйл ангиа хүлээн зөвшөөрөхгүй, батлан даалтанд гарах, хэргээ үнэн зөв, шуурхай шийдвэрлүүлэх гэх шалтгаанаар 1-56 хоног өлсгөлөн зарласан ба өлсгөлөн зарласан хохирогчдын 90 орчим хувь нь 1-7 хоногийн хугацаагаар өлсгөлөн зарласан байна.

¹¹¹ www.assa.mn

¹¹² www.assa.mn



Дүгнэвэл:

Дээрхээс харахад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн нэгэн илрэн гарах нэгэн хэлбэр болох өлсгөлөн зарлах явдал нь цоо шинээр үүссэн зүйл биш бөгөөд нийгмийн хөгжлийн явцад хүн төрөлхтөн эрхээ хамгаалахын тулд янз бүрийн шалтгаанар өлсгөлөн зарлаж ирсэнийг харж болохоор байна

Олон улсын байгууллагууд мөн улс орон бүр өлсгөлөн зарлах явдлыг тодорхой хэмжээгээр зохицуулсан байдаг ба манай улсын хувьд хэд хэдэн хуулийн зүйл заалтанд тусгаж өгсөн боловч уг эрхийг бодитой хэрэгжих шаардлагыг төдийлөн хангахгүй байгаа бөгөөд нөгөө талаас иргэд уг эрхийг ёс зүйтэй эдлэх төлөвшил хараахан бүрдээгүй байгаа нь харагдаж байна.

Мөн өлсгөлөн зарлагчдын талаар хийгдсэн нэгдсэн судалгаа тоо баримт байдаггүй, өнөөгийн байдлаар хийгдсэн судалгаа нь зөвхөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны тоо бүртгэлийн тасагт сэжигтэн, хоригдогчийн зүгээс гаргасан өргөдөл гомдлын бүртгэл байдаг нь зөвхөн өргөдөл гаргасан этгээдийн шалтгаан нөхцлийн талаар судлах судлагдахуун мэдээ мэдээллээр хязгаарлагдаж байна. Иймээс өлсгөлөн зарлах үйл ажиллагаа болон өлсгөлөн зарлагчдын эрхийг ханган хамгаалах асуудлаар цогц зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна

Илтгэлийн төгсгөлд бид хийсэн судалгаан дээрээ үндэслэн дараах асуудлуудын хөндөн тавьж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар: “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” хэмээн заажээ. Үүнээс харахад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэлбэрүүд тэр дундаа өлсгөлөн зарласан тохиолдолд бусдын эрх, эрх чөлөөнд халдсан үйлдэд, эс үйлдэхүй гаргаж болохгүй гэдэг нь харагдаж байна. Өлсгөлөн зарласан тохиолдлуудыг судлан авч үзвэл ганцаараа зарласан тохиолдол ховор байгаа бөгөөд ихэнхдээ 3 буюу түүнээс дээш, бүр бүлэглэн өлсгөлөн зарласан байдаг. Тэдгээр хүмүүс өөрсдийн үзэл бодлоо хамгаалах нэг зорилго санааны төлөө нэгдсэн боловч түүнд хүрэх арга зам нь, тухайлбал тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлах явдлыг тэд бүгдээр хүлээн зөвшөөрч байгаа эсэх нь эргэлзээтэй. Магадгүй өлсгөлөнгийн хор уршгийг мэдээгүйгээс сэтгэл хөөрлөөр бусдыг дагалдан өлсгөлөн зарлах, нэгэнт зарлаад

эхэлсэн хойноо цуцлахаас нэрэлхэх байдалд иргэд орж болзошгүй тул өлсгөлөн зарлагчдад өлсгөнгийн хор уршигийн талаар урьдчилан таниулах үйл ажиллагааг эрүүл мэнд, сэтгэл судлалын талаас өгөх ажлыг хариуцсан нэгж бий болгох

2. Мөн өлсгөлөн зарлагчдын талаар хийгдсэн нэгдсэн судалгаа тоо баримт байдаггүй, өнөөгийн байдлаар хийгдсэн судалгаа нь зөвхөн хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны тоо бүртгэлийн тасагт сэжигтэн, хоригдогчийн зүгээс гаргасан өргөдөл гомдлын бүртгэл байдаг. Бусад өлсгөнгийн талаар цахим сүлжээн дэх мэдээллээс түүвэрлэн үзэхэд хүргэж байгаа өлсгөлөн зарлах эрхийн хээрэгжилтийг үнэлэх, үр дагаварыг тодорхойлох зэрэгт хүндрэлтэй байгаа тул энэ талаар нэгдсэн судалгааны санг бий болгох
3. Цаашлаад өлсгөлөн зарлагчийн эрхийг хамгаалах, энэ үйл ажиллагааг ёс кзүйн өндөр түвшинд хяналттай хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангах үүднээс өлсгөлөн зарлах тухай хуулийн төсөл боловсруулан түүндээ өлсгөлөн зарлах шалтгаан, зарласан үед мөрдөх зарчим мөн эмнэлэгийн тусламж үйлчилгээ гэх мэт нарийн төвөгтэй зүйлүүдийг тусгаж өгөх шаардлагатай байна.



ИПОТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ТҮҮНИЙ ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Ц.Мөнхдэлгэр

Сутай дээд сургуулийн ахлах багш, өмгөөлөгч, магистр

Барьцааны тухай ойлголт

Барьцаа нь эрт дээр үеэс хөгжиж ирсэн бөгөөд эртний Ромын эрх зүйд тухайн хөгжлийн үе шат бүрд өөр өөрөөр нэрлэж барьцааны харилцааг зохицуулах үйл ажиллагаа явагдаж байсан байна.

Ромын эрх зүйд фидуци, пигнус, ипотека, антихреза зэрэг олон төрлүүд байсан байна. Барьцааны хөгжлийн нийтлэг нэг зүйл бол барьцаа нь үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг эд зүйлээр хангахад чиглэгдэх бөгөөд үүргийг гүйцэтгэхийн тулд өөрийнхөө эд зүйлсийг барьцаалахыг харилцан тохиролцсоны үндсэн дээр барьцаа хийгдэнэ. Ийнхүү барьцааны үндэс нь үүрэг хүлээгчийн гүйцэтгэл болдог байна. Тухайн үед барьцаалуулагч үүргээ хугацаанд нь биелүүлж чадаагүй бол барьцааны эд зүйл хүссэн хүсээгүй барьцаалагчийн мэдэлд шилждэг байв. Энэ нь үүрэг хүлээгчийн хувьд ихээхэн хүнд тусдаг байсан тул МЭ 326 онд хориглосон зарлиг гарчээ. Үүнээс хойш Императорын газраар дамжуулан шилжүүлэг хийх хүсэлт гаргах замаар эд зүйл шилждэг болгосон байна. Юстинианы үед үүрэг хүлээгч хоёр жилийн хугацаанд өөрийн эд зүйлийг худалдаж авах эрхтэй байсан нь мөнгө хүүлэгчдийн ашиг сонирхолд төдийлөн нийцдэггүй байв.

Барьцааны зүйлийг зарж борлуулах.

Барьцааны эрх зүйн харилцаанд үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх үндсэн эрхийн нэг нь үүрэг хүлээгч зээлсэн мөнгөө хугацаанд нь үүрэг гүйцэтгүүлэгчид эргэж төлөөгүй тохиолдолд барьцааны эд зүйлийг захиран зарцуулах эрхтэй явдал юм. Эртний Ромд эхлээд барьцааны эд зүйлийг худалдан борлуулах эрхийг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлдэг байсан бол яваандаа “Хэрвээ өрөө төлөөгүй бол барьцааны эд зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгч захиран зарцуулах ёстой” гэсэн ойлголт бий болжээ.

МЭ 326 онд үүрэг гүйцэтгэгдээгүй үед барьцааны эд хөрөнгийг худалдаанд гаргах болсон бөгөөд энэ тохиолдолд үндсэн үүрэг болон түүний хүүг төлөөд илүү гарсныг үүрэг хүлээгчид буцаан олгодог байв.¹¹³ Харин барьцааны эд юмсыг борлуулаад олсон мөнгө нь зээлдүүлсэн мөнгөний хэмжээнд хүрэхгүй бол дутууг үүрэг хүлээгчийн эд бараагаар нөхөж авдаг байжээ. Ийнхүү худалдан борлуулах асуудлыг эргэлзэлгүйгээр барьцаалагч шийддэг болсон нь ахуйн хэлбэртэй байсан барьцаа хөгжлийн шинэ түвшинд гарсан байна. Ромд ипотекийн бүртгэл хөтөлдөггүй байсан нь үүрэг хүлээгч барьцааны эд

¹¹³ З.М.Черниловский. Римское частное право. 1998 г. Москва. 79 стр

зүйлийг хэд хэдэн газар барьцаалуулах тохиолдол олон гарч барьцааны эд зүйлийг худалдан борлуулахад нилээн төвөгтөй болох болжээ. Энэ тохиолдолд Претор хамгийн анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг хамгаалах, түүнийг тогтоох боломжгүй үед барьцааны зүйл эзэмшилд нь шилжсэн үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг эхэлж хангах журам баримталдаг байжээ.

Эртний Ромын эрх зүйд барьцааны харилцааны зохицуулалт бүрэн төгс бус ч тухайн үеийн хөгжлийн шаардлагын хангахуйц байсан нь илэрхий байна.

Монгол улсад барьцааны харилцааг зохицуулсан нь.

Монголчууд төр хууль цаазны эртний сонгодог өв уламжлалтай бөгөөд эртний хууль цаазын эх сурвалж бичгүүдээс харахад хуулийг эрүү, иргэн, захиргаа гэх мэтээр ялган системчилж байгаагүй боловч Их Засаг, Алтан хааны цаазын бичиг, Монгол-Ойрадын хууль, Халх журам зэрэг эртний болон дундад зууны үеийн хууль цаазын томоохон сурвалж бичгүүдэд өнөөгийн Иргэний хуулиар зохицуулагдаж буй зарим харилцааг зохицуулсан тодорхой бүлгүүд байжээ.

Чингис хааны Их засаг хуулийг судалж ном зохиолоо хэвлүүлсэн эрдэмтэн мэргэдийн ¹¹⁴ бүтээлээс үзэхэд иргэний эрх зүйтэй холбоотой заалтууд төдийлөн дэлгэрэнгүй бөгөөд барьцааны тухай нарийвчлан заагаагүй байна. Тухайн үед нийгмийн харилцааны тодорхой хэсгийг төрийн хуулиар зохицуулахаас гадна зонхилох хэсэгт нь зан заншлын хэм хэмжээ илүү нөлөөлж байсанаас эрх зүйн зохицуулалт төдийлөн өргөн хүрээг хамарч чадаагүй байна.

Монгол-Ойрадын хууль. 1640 онд Монгол-Ойрадын томоохон ноёд чуулган болж Монгол-Ойрадын хууль буюу 40 Монгол 4 Ойрадын хуулийг тогтоожээ. Уг хуульд мал аж ахуй, ан гөрөө, өртөө улааны алба гүйцэтгэх, гэрлэлт, гэр бүлийн эрх үүрэг, өв өвлөх, өр авлаг, зээлийн талаар тодорхой заалтууд байдаг ч барьцааны харилцааг зохицуулсан хэм хэмжээ нарийвчлан тусгагдаагүй байдаг. Гэвч тухайн үед барьцааг бага ч гэсэн хэрэглэж байсаныг хуульд дурьджээ. Үүнд: Эд юмс зээлдүүлэгч зээлдэгчээс гурван удаа эзний дэргэд нэхэмжлээд өгөхгүй бол отгын даргад мэдүүлж барьцаа авч болох, харин отгын даргад мэдэгдэхгүй авбал хариуцлага хүлээж байхаар заасан байжээ.

Халх журам. Монголчууд өөрсдийн ахуй амьдралаас ургуулан гаргасан тусгаар тогтнол, эдийн засаг, төрт ёс, шашин шүтлэг, зан заншилаа хуульчлан баталгаажуулж байсныг гэрчлэх эрх зүйн гайхамшигт баримт бичиг юм.¹¹⁵

Эрдэмтэн С.Жалан-Аажавын тэмдэглэсэнээр Монгол хууль цаазын шилдэг буюу дээд нь гэж үзэж болно.¹¹⁶ Уг хуулинд барьцааны тухай ямар нэгэн хэм хэмжээ тусгагдаагүй байна.

Манай улсад мөрдөж ирсэн удаа дараагийн Иргэний хуулиудад барьцааны тухай тусгагдаж иржээ. 1926 оны Иргэний хуульд үүргийн эрх зүйд, 1952 оны Иргэний хуульд эд хөрөнгийн эрхэд, 1963, 1994 оны Иргэний хуулиудад үүргийн эрх зүйд, 2002 оны Иргэний хуульд өмчийн эрх зүйд тус тус хамааруулан тусгажээ.

1926 оны Иргэний хууль. 1921 оны ардын хувьсгал ялсаны дараа хуучин хууль журмыг халж үндэсний хууль цаазыг зохиох, шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Үүний үр дүнд 1926 онд анхны Иргэний хуулийг батлан гаргасан юм. Уг хууль нь 10 бүлэг, 267 зүйлтэй байсан бөгөөд “Аливаа эд юмсыг бусад дор барьцаалуулах тухай” хэмээх 7-р бүлгийн 16-р зүйлд барьцааны харилцааг зохицуулж өгчээ. Мөн бүлэгт зээл, түүнтэй холбоотой эд

¹¹⁴ Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй \Ерөнхий анги\ УБ.1997 он

¹¹⁵ Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй \Ерөнхий анги\ УБ.1997 он

¹¹⁶ С.Жалан-Аажав. Халх журам. УБ. 1995 он

юмсыг барьцаалах, барьцаалан авахдаа байгуулсан гэрээ бичиг, барьцаалж зээлдэн авсан эд зүйлдийг авах эрхийг бусдад шилжүүлэх, мөн аливаа эд юмсыг барьцаалуулах ба зээлдэх, авсан эд зүйлийг зохих хугацаандаа эс төлөгсөдийн тухай заасан байна.

Уг хуулийн 136-д "Аливаа хууль дүрэм буюу тусгай гэрээг баримталж зээл авсан зүйлийг хэлэлцсэн ёсоор төлөхийг батлахын тулд эд юмсыг барьцаалдаг бөгөөд хэрэв эс төлөхөд хүрвэл уг барьцаалсан зүйлээс шууд төлүүлвэл зохино" гэж заажээ.

Бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд үүргээ гүйцэтгүүлэх давуу эрхийг орхигдуулсан боловч барьцааны харилцааг анх удаа хуульчлан баталгаажуулж, барьцааг хэрэглэх үед зайлшгүй бий болох анхан шатны үйлдлүүдийг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж өгсөнд энэ хуулийн гол ач холбогдол оршино. Уг хуулиар барьцааны гэрээнд зайлшгүй тусгагдах гол нөхцөлүүд, барьцаалсан эд юмс давагдашгүй хүчин зүйл буюу гал усны сүйрэлд орсон үед барьцаалсан этгээд хэрхэн хохиролоо арилгуулах, барьцааны зүйлийн хүрээ хязгаар, түүнийг уул үнээс хэтрүүлэлгүйгээр хэд хэдэн хүнд буюу газарт барьцаалж болох тухай зохицуулж өгсөн байна.

Энэ хуулийн гол ололттой тал нь барьцаа нь үүргийн болон өмчийн эрх зүйн шинжийг хоёуланг агуулсан болохыг харгалзан үзэж бие даасан тусгай бүлэг болгон зохицуулсанд оршино.

1952 оны Иргэний хууль. 1952 оны 5 сарын 27 өдрийн БНМАУ-ын АИХТ-ийн зарлигаар хоёр дахь Иргэний хуулийг шинэчлэн баталсан байна. Энэ хууль нь ерөнхий анги, Эд хөрөнгийн эрх, Үүргийн эрх гэсэн гурван хэсгээс бүрдэж байсан бөгөөд 3-р бүлэг нь "Эд хөрөнгийн барьцаа, үүргийн эрх" гэдэг нэртэй байв. Уг хуульд барьцааны өвөрмөц нэг төрөл болох боловсруулалтанд байгаа барааны барьцааг тусгаж өгчээ. Хуулийн 74-р зүйлд "Гүйлгээнд явагдаж байгаа буюу улсын ба хоршооллын хийгээд худалдаа үйлдвэрийн борлуулалтанд байгаа тавараар барьцаа өгөх, тэдгээрийг хүлээн авах явдал бол зээлийн байгууллагуудад гүйцэтгэгдэж болно" гэж заажээ.¹¹⁷

1952 оны Иргэний хууль батлагдан гарах үеийн социалист нийгмийн онцлогоос хамааран иргэдийн эрх ашиг, хуулийн этгээд болон төрийн ашиг сонирхолын дараа тавигдаж байсан нь уг "Эд хөрөнгийн барьцаа, үүргийн эрх" бүлэгт тусгалаа олсон байна. Мөн хуулийн 69-р зүйлд "Эд хөрөнгө" бол зөвхөн нэг зээлдүүлэгчид барьцаалах ёстой бөгөөд ямар нэг шалтгаанаар хэд хэдэн зээлдүүлэгч тэдгээрийн дотор Монгол банк буюу хэд хэдэн зээлдүүлэгч байгууллагууд, бусад хүмүүст барьцаалагдсан бол эхлээд:

- Монгол банк
- Зээллэгийн болон албан газрын нэхэмжлэл
- Улс хоршоодын ба ОН-ийн бусад байгууллагуудын нэхэмжлэл
- Энгийн хүмүүсийн нэхэмжлэлийг тус тус хангана гэж дараалал тогтоож өгсөн байв. Энэ нь иргэний эрх, ашиг сонирхол, эрх чөлөөг ноцтой зөрчигдөж байгааг харуулж байна. Тус хуулиар барьцааны зүйлийн хүрээг тодорхойлж "Барьцаалах зүйл бол иргэний гүйлгээнээс хасагдаагүй ямар ч эд хогшил түүнчлэн өрийн шаардлагууд байж болно" гэж заасан боловч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны хувьд зөвхөн барилгын барьцааг ойлгож байв.

Барьцааны зохицуулалтыг 1952 оны Иргэний хуульд эд хөрөнгийн эрхийн хэсэгт оруулсан нь тухайн үеийн ЗХУ-ын Иргэний хуулийн шууд нөлөө тусгалаа олсон явдал юм.

¹¹⁷ Иргэний хууль. 1952 он

1962 оны Иргэний хууль. 1962 оны Иргэний хуулинд барьцаа нь үүргийн эрхийн хэсэгт хамаарч үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэмээн нэрлэж, *торгууль, барьцаа, дэнчин, батлан даалт* зэргийг нэг бүлэгт багтаан хуульчилсан байна.

Энэ хуулиар барьцаалагчийн тэргүүн ээлжинд үүргээ гүйцэтгүүлэх давуу эрхийг шууд тодорхой зааж барьцааны зүйл байж болохгүй эд зүйлсийг тогтоож өгсөн нь нилээд ололттой болсон боловч барьцаа болон ялангуяа үл хөдлөх эд хөрөнгийн зохицуулалт хангалтгүй болсон байна.

2002 оны Иргэний хууль. Уг хуульд барьцааг өмчийн эрх зүйд хамааруулан системчилж анх удаа ипотек хэмээх дэд бүлэг болгон оруулсан байна. Монгол Улсын Иргэний хуулийн 165 дугаар зүйлд: бусад үүрэг гүйцэтгүүлэгчээс тэргүүн ээлжинд өөрийн шаардлагаа хангуулахаар үүрэг гүйцэтгэгч тодорхой үл хөдлөх хөрөнгө барьцаалахыг **ипотек** гэнэ¹¹⁸ гэж заажээ.

Ийнхүү манай улсад удаа дараа мөрдөгдөж ирсэн иргэний хууль тогтоомжид барьцааны харилцаа нь тухайн нийгмийн харилцаанаас хамаарч янз бүрээр зохицуулж улам боловсронгуй болон хөгжсөөр иржээ.

Ипотек. \Үл хөдлөх хөрөнгийн барьцаа

Ипотекийн албан бус хэлбэр МЭӨ III зуунд түрээслэгч, түрээслүүлэгчдийн хооронд байгуулсан түрээсийн гэрээгээр аж ахуйн багаж хэрэгсэл, ажлын мал зэргийг түрээслэгчид шилжүүлэхэд аж ахуйн газрыг үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон түрээслэгч барьцаанд авч болдог байснаар үүссэн гэж үздэг. Тухайн үедээ үл хөдлөх эд хөрөнгийн Ипотек нь түрээсийн төлбөрөө төлөх баталгаа болж итгэлийг нь бэхжүүлдэг байв.¹¹⁹

МЭӨ IV зууны эхээр эртний Грект зээл авсан хүний газрын захад шон босгож, дээр нь тухайн газар нь зээлийн барьцаанд байгаа, хэдий хэмжээний өртөй болох, хэзээ барагдуулах, зээлийн барьцаа болсон бөгөөд зээлээ төлж чадахгүй бол энэ газар зээлдүүлэгчийн өмч болно гэх зэргээр зээлдэгч, зээлдүүлэгчийн нэр устай хамт бичсэн баганат самбар байрлуулдаг байсан бөгөөд энэхүү шонг **"ипотек"** гэж (грек хэлний *hypotheka* - тулгуур, түшиг) нэрлэдэг байсан байна.¹²⁰

Эртний Грекийн долоон суут ухаантны нэг Солон Архонт МЭӨ 594 онд алдарт шинэчлэлээ хийх явцдаа гэрээслэл үлдээх эрх чөлөөг бий болгож, газрын өрийг өөрчилсөн байна. Ийм тэмдэг тавиулсан газрын эзэн тухайн газар дээрээ байгаа эд хөрөнгийг зөөж авч явах эрхгүй, хэрэв зээлээ төлөөгүй тохиолдолд газрын эзэн өмчилж байгаа газраа алдах төдийгүй боол болох ч эрсдэлтэй байсан нь зээл авагчид асар их хариуцлагыг үүрүүлж, зээл олгогчид найдвартай баталгааг илэрхийлэгч нь энэхүү ипотек хэмээх гэрээ байжээ. Чухам энэ үед Солон өрөө төлж чадахгүй хариуцлагаа биеэрээ төлдөг байсныг эд хөрөнгөөрөө төлдөг болгох зорилгоор барьцааны өөр хувилбарыг бий болгосон нь орчин үеийн Ипотекийн эхлэл болжээ. Улмаар энэ ойлголт нь хувьсан өөрчлөгдсөөр ипотек гэдэг үгээр зээлийн барьцаа болсон дурын үл хөдлөх хөрөнгийг нэрлэдэг болжээ. Яваандаа шон босгохоо больж, ипотекийн дэвтэр бий болсон байна.

Мөн эртний Вавилоны хаан Хаммурапигийн (МЭӨ 1793-1750) хуульд барьцааны тухай байдаг бол Энэтхэгийн Манугийн хуульд (МЭӨ II зуун) шүүхээр хэлэлцэх 18 үндэслэлийн нэг нь барьцаа болох тухай дурдсан байдаг байна.

¹¹⁸ МУ-ын Иргэний хууль. 2002 он.

¹¹⁹ З.М.Черниловский. Римское частное право. 1988 г. Москва. 76 стр

¹²⁰ История зарождение ипотека. 2000 г. Москва. 10 стр

Ипотек нь Ромын эзэнт гүрний үед улам илүү хөгжжээ. Манай эриний I зуунд хувь хүмүүст зээл олгодог ипотекийн байгууллагууд бий болж, Антонин Пий хааны (МЭ 86-161) үед ипотекийн банкны тухай хуультай болж, төрийн зүгээс ипотекийн зээлд үргэлж том дэмжлэг үзүүлдэг байжээ. МЭ 53-117 онд Траян хааны үед өнчин хүүхдүүд, бэлбэсэн эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх зорилготой тусгай фонд байгуулж, жилийн 5 хувийн хүүтэй ипотекийн зээл олгодог байжээ.

Ипотек нь харьцангуй богино хугацаанд **фидуци** (латин хэлний *fidusia*- итгэл дээр тулгуурласан хэлцэл), арай боловсронгуй үе шат болох **пигнус** (латин хэлний *pignus*- албан бус барьцаа), цаашлаад **антихрез, ипотека** гэсэн хөгжлийн замыг туулжээ.

Фидуци. Фидуцийн үед барьцаа нь шууд зээлдүүлэгчийн өмчлөлд шилждэг байсан бөгөөд зээлдүүлэгч нь барьцааг зээлдэгч авсан зээлээ төлсний дараа эргүүлж өгөх, эсвэл мөнгө авалгүйгээр зарах эрхтэй байжээ.

Барьцаалагдаж буй эд зүйлсийг үүрэг гүйцэтгүүлэгчийн хувийн өмчлөлд шилжүүлсэнээр үүрэг хүлээгч нь үүрэг гүйцэтгүүлэгчид барьцаагаар хангагдсан үүргийн шаардлагаас илүү эрх олгож байгаа бөгөөд ингэснээр үүрэг хүлээгч гүйцэтгүүлэгчид ихээхэн итгэл үзүүлж өр төлбөрөө хугацаанд нь төлсөн тохиолдолд барьцааны эд зүйлсээ буцаан авна гэж итгэдэг байв. Иймээс барьцааны энэ төрлийг “фидуци”, харин барьцаалах үйл явцыг “фидуциальная” буюу “итгэлтэй байх” гэж нэрлэдэг байжээ.

Пигнус. Энэ нь “тинж” гэсэн утгатай үг бөгөөд ямар нэгэн байдлаар дарамтанд байх гэсэн үг юм. Пигнусийн гэрээнд үүрэг хүлээгч нь үүрэг гүйцэтгүүлэгчид төлбөрийн барьцаанд эд зүйлээ өгөхдөө фидуцийн барьцаа шиг өмчлөх эрхэд бус зөвхөн эзэмших эрхэд шилжүүлдэг байв. Уг барьцаа нь тухайн үеийн Ромын сонирхолд илүүтэй нийцэж харин үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд төдийлөн таалагддаггүй байсан байна. Үүрэг гүйцэтгүүлэгч барьцааны хөрөнгийг өөртөө үлдээх эрхгүй байсан ба зөвхөн үүрэг гүйцэтгэгч авсан зээлээ төлөөгүй тохиолдолд борлуулж, өрийн үлдэгдлийг суутган, илүү мөнгийг нь эргүүлж өгдөг байжээ.

Пигнусын барьцааны эхэн үед барьцаалагч нь өөрийн дураар барьцаалуулагчийн зөвшөөрөлгүйгээр барьцааны эд хөрөнгийг ашиглахыг хулгай хийсэнтэй адилтган үздэг байсан бөгөөд барьцаалагч нь барьцааны эд хөрөнгөд өөрийн эд юмстай адил хандах ёстой байв. Барьцааны эд зүйлс барьцаалагчид заавал шилждэг байсан учир барьцаалуулагчийн эд зүйлсээ ашиглах боломж алдагдаж байсан нь тэдэнд ихээхэн хохиролтой байсны улмаас яваандаа хуульчид доорхи байдлаар засвар хийхэд нөлөөлжээ. Үүнд: Барьцаалагчийн зөвшөөрсний дагуу барьцаалуулагч өөрийн эд зүйлсийг түрээсээр, хугацаатай ашиглаж болохоор өөрчилсөн байна.

Антихреза. Византийн эзэнт гүрний үед эдийн засгийн уналттай холбоотойгоор газрыг түрээсэлж, барьцаалж зээл авах нь хүндрэлтэй болж, үүрэг хүлээгч үүрэгээ биелүүлэх боломжгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч зээлдүүлсэн мөнгөнийхээ оронд үүрэг хүлээгчийн газрыг авахыг зөвшөөрдөг байв. Мөн зээлийн хүүг төлөх асуудал ихээхэн хүндрэлтэй учирдаг байжээ. Бэлэн мөнгөгүй тохиолдолд үүрэг хүлээгч нь газраа үүрэг гүйцэтгүүлэгчийн мэдэлд шилжүүлэн ашиглуулж болох бөгөөд ингэхдээ ашиглуулсны төлбөрийг хүүгийнхээ оронд бодож өгдөг байв. Үүнийг “антихреза” гэдэг бөгөөд гэрээгээр ашиглуулсны оронд буюу зээлийн хүүгийнхээ оронд газраа ашиглуулдаг гэсэн утга илэрхийлдэг байна.¹²¹

Антихрезаар орон байр, газраа барьцаалсан тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь хүүгийн оронд газрыг ашигласан, үр шимийг нь түрээсийн төлбөр болгон авдаг эсхүл

¹²¹ З.М.Черниловский Римское частное право. 1998 г.Москва. 78 стр

тухайн барьцаанд өгсөн байр сууцанд амьдарч ашгийг нь цуглуулах замаар хүүтээ бодож авдаг байв.

Ипотек дундад зуунд Ипотекийн хэлцлийн харьцангуй хүнд тогтолцоо нь боловсронгуй бүртгэлийн систем, зохицуулалт шаардаж байсан тул хэлцэлд оролцогчдыг хууль сахиулахад төрийн үүрэг их байсан байна. Эртний хүчирхэг улсуудын эрин үе дуусгавар болж, төрийн эдгээр үүрэг суларснаар ипотека хэдэн зууны туршид алга болсон юм. Дундад зууны үеийн ипотека нь Ромын эрх зүйн уламжлалыг даган баруун Европын орнуудын хууль тогтоомжинд, тэр дундаа Германы эрх зүйд XIV зуунд орж иржээ.

Германы эрх зүй ипотекийг олон нийтийн болгон хөгжүүлж, улмаар тусгай дэвтэрт бичилт хийсний дараа найдвартай өмчийн эрх зүй болдог болгожээ.

Ипотек XIX-XX зуунд Европ болон АНУ-д хөгжиж, XIX зуунаас өнөөгийн орчин үеийн хэлбэрийг олж, ипотекаар дамжуулан төр болон банкууд газрыг хянадаг болсон байна. XIX зууны дунд үеэс үйлдвэржилт идэвхтэй явагдаж эхлэх үед үйлдвэрийн барилгыг санхүүжүүлэх зорилгоор ипотекийн зээлийг ашиглаж эхэлсэн нь ипотекийн шинэ үе эхэлсэн гэж үздэг.

Ипотекийн зээлийг ашиглах үйл явдал анх ипотекийн хууль тогтоомжтой болсон Германд биш Англи, Голланд, Францад эхлээд хөгжсөн байна. АНУ-д ипотека 1930-аад оны эдийн засгийн хямралын (**great depression**) үед орон сууцны зээл хэлбэрээр анх бий болж тухайн үеийн АНУ-н засгийн газар ипотекийг эрсдэл багатай хөрөнгө оруулалт гэж үзжээ. Америкийн ипотека иргэдийн үл хөдлөх хөрөнгөө чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, шилжүүлэх эрхийг хангахад голлон анхаарч чиглэсэн байна.

Ипотекийн зээлийн системд төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг маш өндөр байсан ба хувийн хэвшлийнхэн, гадаадын хөрөнгө оруулагчид энэ салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болсон байна. Гэвч 2007 оны 8 сарын 9-нд эхэлсэн Америкийн ипотекийн хямрал удалгүй дэлхийн санхүүгийн хямрал болон үргэлжилсэн билээ.

Ипотек: Англиар **Hypothec**-Үл хөдлөх хөрөнгийн барьцаа гэсэн үг бөгөөд Эртний Грекээс гаралтай үг юм. Зээлдэгч зээлдүүлэгч хоёрийн холбоо харилцааг ипотека гэж нэрлэдэг байжээ. Ипотек гэсэн томъёог Европын орнууд, Азийн хойд бүсийн буюу эх газрын хууль үйлчилдэг улс орнуудад өргөн хэрэглэдэг.

Моргэйж: Англиар **Mortgage**-Барьцаа, барьцаат зээл гэсэн утгатай. АНУ, Англи-Саксоны хууль хэрэглэдэг улсууд болон өмнөд Америк, Азийн урд талын зарим оронд Моргейж гэсэн ойлголт түгээмэл байдаг байна.

Энэ хоёр үг нь үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, урт хугацааны зээл олгох, эрх зүйн зохицуулалтын ерөнхий нэг нэр юм. Эх газрын болон Англи-Саксоны хуулийн системд өөрөөр нэрлэгдсэн боловч энэ хоёр үг бол мөн чанартаа нэг үг юм.



ПОНЯТИЕ ЗЕМЛИ (ПОЧВЫ) В ЗАКОНОДАТЕЛЬСТВЕ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ: ОТДЕЛЬНЫЕ ПРАВОВЫЕ АСПЕКТЫ

Воронцова Оксана Викторовна

Кандидат юридических наук

доцент кафедры государственно-правовых дисциплин

Коми республиканской академии государственной службы и управления

Аннотация: В статье проанализированы основные понятия, используемые в исследуемой сфере, такие как «земля», «земли», «почва», «земельный участок», «земельные ресурсы», «участок территории», «плодородный слой почвы» и др. На основании проведенного анализа автор приходит к выводам относительно действия в современном российском законодательстве достаточно объемного понятийно-категорийного аппарата; синонимичности, смежности отдельных понятий; наличие в судебной и административной практике активного использования многих понятий, даже если их значение юридически не закреплено ни в одном нормативном правовом акте; правообразующем характере отдельных понятий.

Характеризуя современное состояние качества земли (почвы), необходимо отметить, что в данной сфере используются несколько смежных понятий, таких как «земля», «земли», «почва», «почвенный очаг»¹²², «земельный участок», «земельные ресурсы»¹²³, «участок территории»¹²⁴, «плодородный слой почвы», «грунт», «пейзажные земли» и др.

В теории советского земельного права П.И. Стучка сформулировал два важных на тот момент положения, касающихся земли. Во-первых, земля в капиталистическом обществе рассматривалась как товар, и поэтому земельные отношения в капиталистических странах регулировались гражданским правом. Во-вторых, в результате

¹²² Постановление Главного государственного санитарного врача РФ от 13 мая 2010 г. № 56 «Об утверждении СП 3.1.7.2629-10» (Профилактика сибирской язвы. Санитарно-эпидемиологические правила) // Российская газета. 2010. № 141.

¹²³ Федеральный закон от 1 мая 1999 г. № 94-ФЗ «Об охране озера Байкал» // СЗ РФ. 1999. № 18. Ст. 2220.

¹²⁴ Федеральный закон от 10 июля 2001 г. № 92-ФЗ «О специальных экологических программах реабилитации радиационно загрязненных участков территории» // Собрание законодательства РФ. 2001. № 29. Ст. 2947.

победы октябрьской социалистической революции 1917 г. в СССР земля перестала быть товаром и поэтому не регулировалась гражданским законодательством¹²⁵.

Сегодня же в соответствии с Гражданским кодексом РФ¹²⁶ земля и другие природные ресурсы могут отчуждаться или переходить от одного лица к другому (ч. 3 ст. 129 ГК РФ). Земельные участки в соответствии с ч. 1 ст. 130 ГК РФ отнесены к недвижимым вещам (недвижимое имущество, недвижимость). Иными словами, с точки зрения цивилистики природные объекты (в том числе и земля) являются вещами.

В Концепции долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года¹²⁷ в сфере формирования институциональной среды инновационного развития приоритетным является развитие рынков земли и недвижимости. При этом подчеркивается важная задача государства — обеспечить равную защиту прав собственности на объекты недвижимости для всех участников рынка, а также снизить издержки граждан и бизнеса при оформлении прав на недвижимость. Это предполагает упрощение процедур вовлечения земель в хозяйственный оборот, формирование эффективных государственных систем кадастрового учета и регистрации прав на недвижимость при развитии конкуренции на рынке кадастровых работ и переходе к саморегулированию кадастровой деятельности, завершение приватизации земельных участков, на которых расположены находящиеся в частной собственности объекты недвижимости и выдела земельных участков в счет земельных долей, образованных в процессе приватизации сельскохозяйственных земель, формирование института массовой оценки недвижимости и введение на этой основе полноценного налогообложения недвижимости.

В связи с этим нельзя не согласиться с М.И. Васильевой, которая подчеркивает, что «гражданско-правовая атрибутивность прав на земельные участки и иные природные объекты отражает лишь одну из возможных характеристик (вещно-правовую) и вряд ли является доминирующей, учитывая наличие целого ряда иных юридически значимых признаков — таких, например, как экосистемная и жизнеобеспечивающая значимость, естественное происхождение, незаменимость и невозобновляемость»¹²⁸.

Об этом же говорит и С.А. Боголюбов, в целом поддерживающий Концепцию развития гражданского законодательства, затрагивающую природоохранную и природоресурсную отрасли законодательства. «Законодателю не стоит уходить от чеканной и оправдавшей себя в теории и на практике формулы ст. 129 действующего ГК РФ (почерпнутой из западноевропейского законодательства), согласно которой оборот земли и других природных ресурсов регулируются ГК РФ постольку, поскольку он не ограничивается законами о земле и других природных ресурсах»¹²⁹. Оптимальным сочетанием гражданско-правовых и земельно-правовых требований в ЗК РФ он считает: 1) прямую ссылку на нормы ГК РФ; 2) пересказ, переложение в ЗК РФ нормы ГК РФ с

¹²⁵ См.: Казанцев Н.Д. Из истории науки советского земельного и природоохранительного права // Экологическое право. 2001. № 2. С.10.

¹²⁶ Собрание законодательства РФ. 1994. № 32. Ст. 3301.

¹²⁷ Собрание законодательства РФ. 2008. № 47. Ст. 5489.

¹²⁸ Васильева М.И. Земельные и природно-ресурсные отношения в концепции развития законодательства о вещном праве // Экологическое право. 2009. № 5/6. Справочно-правовая система «КонсультантПлюс». Комментарии законодательства. Юридическая пресса.

¹²⁹ Боголюбов С.А. Земля — природный ресурс и объект права собственности // Экологическое право. 2009. № 5/6. Справочно-правовая система «КонсультантПлюс». Комментарии законодательства. Юридическая пресса.

учетом специфики землепользования; 3) автономное изложение в ЗК РФ специфических земельно-правовых требований¹³⁰.

М.М. Бринчук также отмечает, что в жизни любого человека и общества земля играет важную экологическую, экономическую и политическую роль. Земля — это территория государства, предел его суверенной власти. Как объект хозяйственной деятельности человека она существует без всякого содействия с его стороны как всеобщий предмет человеческого труда, как основное средство производства в сельском и лесном хозяйстве. Земля используется так же, как фундамент, как пространственный операционный базис для развития городов и других поселений, отраслей народного хозяйства¹³¹.

В ст. 1 Земельного кодекса РФ провозглашены принципы земельного законодательства, в соответствии с которыми земля рассматривается в качестве:

- 1) *основы жизни и деятельности человека;*
- 2) *природного объекта, охраняемого в качестве важнейшей составной части природы, природном ресурсе, используемого в качестве средства производства в сельском хозяйстве и лесном хозяйстве и основы осуществления хозяйственной и иной деятельности на территории Российской Федерации, и одновременно как о недвижимом имуществе, об объекте права собственности и иных прав на землю;*
- 3) *важнейшего компонента окружающей среды и средства производства в сельском хозяйстве и лесном хозяйстве имеющего приоритетное значение перед использованием земли в качестве недвижимого имущества, согласно которому владение, пользование и распоряжение землей осуществляются собственниками земельных участков свободно, если это не наносит ущерб окружающей среде;*

Таким образом, сегодня в соответствии с Земельным кодексом РФ объектами охраны и использования являются: земля как природный объект и природный ресурс (элемент окружающей среды); земельные участки, представляющие собой часть поверхности земли (в том числе почвенный слой), границы которой описаны и удостоверены в установленном порядке; части земельных участков¹³².

Федеральный закон от 18 июня 2001 г. № 78-ФЗ «О землеустройстве»¹³³ использует понятие *земли*, а в ст. 13 ЗК РФ прямо указано, что одной из целей охраны *земли* является сохранение *почв* и их плодородия. Иными словами, содержание понятия «земля» неотделимо от понятия «почвы».

В главе 17 Гражданского кодекса РФ термины *земля, земельный участок, поверхностный (почвенный) слой* используются как синонимы.

Уголовный кодекс РФ, закрепляя наказуемость деяния в данной сфере, использует понятие *земля*.

В свою очередь Федеральный закон «О государственном регулировании обеспечения плодородия земель сельскохозяйственного назначения»¹³⁴ закрепляет понятия *почвенное обследование земель, загрязнение почв на земельных участках*. В Письме же Роскомзема

¹³⁰ Там же.

¹³¹ См.: Бринчук М.М. Экологическое право: Учебное пособие. М., 2010. С. 265.

¹³² См.: Дубовик О.Л. Экологическое право: Учебник. М., 2011. С. 390.

¹³³ Собрание законодательства РФ. 2001. № 26. Ст. 2582.

¹³⁴ Собрание законодательства РФ. 1998. № 29. Ст. 3399.

«О Методических рекомендациях по выявлению деградированных и загрязненных земель» от 27 марта 1995 г. № 3-15/582¹³⁵ указано, что выявление деградированных и загрязненных земель производится путем проведения почвенных, агрохимических, почвенно-мелиоративных и других необходимых обследований.

Во многих источниках¹³⁶ используется понятие *нарушенные земли*. К ним относятся земли, утратившие хозяйственную ценность или являющиеся источником отрицательного воздействия на окружающую среду в связи с нарушением почвенного покрова, гидрологического режима и образованием техногенного рельефа при разработке месторождений полезных ископаемых и торфа, выполнении геологоразведочных, изыскательских, строительных и других работ¹³⁷.

Несмотря на многозначность термина «земля», в юридической литературе высказываются мнения, о том, что речь идет о поверхностном почвенном слое. При этом акцент ставится либо на плодородность этого слоя, либо на функции (эта позиция представляется более точной), которые этот слой призван выполнять (экологические, экономические, рекреационные и др.)¹³⁸. Об этом говорит и О.Л. Дубовик, которая считает, что «смежным с термином “земля” является понятие «почва» как минерально-органическое образование, поверхностный слой земли, характеризующийся плодородием»¹³⁹.

Вышеупомянутый Федеральный закон «О государственном регулировании обеспечения плодородия земель сельскохозяйственного назначения» в ст. 1 дает понятие плодородия *земель* сельскохозяйственного назначения как способность именно *почвы* удовлетворять потребность сельскохозяйственных культурных растений в питательных веществах, воздухе, воде, тепле, биологической и физико-химической среде и обеспечивать урожай сельскохозяйственных культурных растений. Таким же образом урегулирован данный вопрос во многих нормативных правовых актах. Например, в Федеральном законе «О мелиорации земель»¹⁴⁰, где определено, что гидромелиорация *земель* направлена на регулирование водного, воздушного, теплового и питательного режимов *почв* на мелиорируемых землях посредством осуществления мер по подъему, подаче, распределению и отводу вод с помощью мелиоративных систем, а также отдельно расположенных гидротехнических сооружений. В Приказе Минсельхоза РФ от 4 мая 2010 г. № 150 «Об утверждении Порядка государственного учета показателей состояния плодородия земель сельскохозяйственного назначения»¹⁴¹ государственный учет показателей состояния плодородия *земель* сельскохозяйственного назначения включает в себя сбор и обобщение результатов *почвенного*, агрохимического, фитосанитарного и эколого-токсикологического обследований *земель* сельскохозяйственного назначения.

¹³⁵ Справочно-правовая система «КонсультантПлюс». Версия Проф.

¹³⁶ См., например: Государственные доклады Министерства природных ресурсов и экологии РФ о состоянии и об охране окружающей среды с 2003 по 2009 г. URL: <http://www.mnr.gov.ru/regulatory/list.php?part=1101> (дата обращения 14 июля 2011 г.).

¹³⁷ Государственный доклад «О состоянии окружающей природной среды Республики Коми в 2006 году» // URL: <http://www.mprg.rkomi.ru> (дата обращения 20 декабря 2010 г.).

¹³⁸ См.: Лобанова Л, Андреев А. Уголовная ответственность за порчу земли // Законность. 2007. № 12. Справочно-правовая система «КонсультантПлюс». Комментарий законодательства. Юридическая пресса.

¹³⁹ Дубовик О.Л. Экологические преступления. Комментарий к главе 26 Уголовного кодекса Российской Федерации. М., 1998. С. 240.

¹⁴⁰ Собрание законодательства РФ. 1996. № 3. Ст. 142.

¹⁴¹ Бюллетень нормативных актов федеральных органов исполнительной власти. 2010. № 32.

Применительно к охране земель от загрязнения ЗК РФ также содержит положения о сохранении именно почв и их плодородия.

Подтверждение этому можно найти и в КоАП РФ, в ст. 8.6 которого указано, что порчей *земли* является самовольное снятие или перемещение *плодородного слоя почвы* или уничтожение *плодородного слоя почвы*, а равно порча *земель*. В Федеральном законе «О государственном регулировании обеспечения плодородия земель сельскохозяйственного назначения» плодородие *земель* рассматривается сквозь призму способности *почвы* удовлетворять потребность сельскохозяйственных культурных растений в питательных веществах, воздухе, воде, тепле, биологической и физико-химической среде и обеспечивать урожай сельскохозяйственных культурных растений. Аналогично соотносятся между собой исследуемые понятия в Федеральном законе «О мелиорации земель», в котором закреплено, что мелиоративные системы должны обеспечивать создание оптимальных режимов *почв* на мелиорированных *землях*. В Федеральной целевой программе «Сохранение и восстановление плодородия почв земель сельскохозяйственного назначения и агроландшафтов как национального достояния России на 2006–2010 годы и на период до 2013 года»¹⁴² вообще содержится категория «*плодородие почв земель*».

Таким образом, можно говорить о том, что в действующем сегодня законодательстве в большинстве своем исследуемые понятия «земля» и «почва» являются достаточно близкими, а в ряде случаев — синонимичными. Однако существуют и обратные примеры. В частности, Федеральный закон «Об охране окружающей среды»¹⁴³ в ст. 4 закрепляет, что объектами охраны окружающей среды от загрязнения, истощения, деградации, порчи, уничтожения и иного негативного воздействия хозяйственной и иной деятельности являются помимо прочего *земли* и *почвы*. Различия между данными понятиями можно найти в таких источниках, как Приказ МЧС РФ «Об утверждении Правил разработки и согласования планов по предупреждению и ликвидации разливов нефти и нефтепродуктов на территории Российской Федерации» от 28 декабря 2004 г. № 621¹⁴⁴, Письмо Роскомзема «О Методике определения размеров ущерба от деградации почв и земель» от 29 июля 1994 г. № 3-14-2/1139¹⁴⁵ и др.

Для того, чтобы отдельно рассмотреть понятие «почва», необходимо обратиться к Межгосударственному стандарту ГОСТ 27593-88 (2005) «Почвы. Термины и определения (Soils. Terms and definitions)», утвержденному и введенному в действие Постановлением Государственного комитета СССР по стандартам 23 февраля 1988 г. № 326. Он содержит следующее определение *почвы* — самостоятельное естественноисторическое органоминеральное природное тело, возникшее на поверхности земли в результате длительного воздействия биотических, абиотических и антропогенных факторов, состоящее из твердых минеральных и органических частиц, воды и воздуха и имеющее специфические генетико-морфологические признаки, свойства, создающие для роста и развития растений соответствующие условия¹⁴⁶.

Почва представляет собой природное образование, состоящее из генетически связанных горизонтов, формирующихся в результате преобразования поверхностных

¹⁴² Собрание законодательства РФ. 2006. № 10. Ст. 1101.

¹⁴³ Собрание законодательства РФ. 2002. № 2. Ст. 133.

¹⁴⁴ Российская газета. 2005. № 95.

¹⁴⁵ Справочно правовая система «КонсультантПлюс». Версия Проф.

¹⁴⁶ URL: [http://ru.wikisource.org/wiki/ГОСТ_27593-88_\(2005\)](http://ru.wikisource.org/wiki/ГОСТ_27593-88_(2005)) (дата обращения 24 декабря 2010 г.).

слоев литосферы под воздействием воды, воздуха и живых организмов; обладает плодородием¹⁴⁷.

Представление о почве как о самостоятельном природном теле с особыми свойствами, отличающими его от материнской (почвообразующей) породы, развивающемся в результате взаимодействия факторов почвообразования, было создано в последней четверти XIX в. В.В. Докучаевым — основателем современного почвоведения¹⁴⁸.

В приказе Минприроды РФ № 525 и Роскомзема № 67 от 22 декабря 1995 г. «Об утверждении Основных положений о рекультивации земель, снятии, сохранении и рациональном использовании плодородного слоя почвы» *плодородный слой почвы* определен как верхняя гумусированная часть почвенного профиля, обладающая благоприятными для роста растений химическими, физическими и агрохимическими свойствами¹⁴⁹. Гумификация представляет собой превращение растительных и животных остатков и микроорганизмов, а также продуктов их жизнедеятельности в почве в гумусовые вещества¹⁵⁰. В том случае, если гумусный слой достигает 30 см, то можно уже говорить о том, что почва достаточна плодородна. В этом слое живут микроорганизмы, которые перерабатывают растительные и органические остатки в минеральные ингредиенты. За гумусным слоем располагаются уже минеральная и материнская породы (верхний слой горной породы, в котором могут происходить почвообразовательные процессы).

Плодородный слой в свою очередь подразделяется по видам. И это не только деление на поверхностный (плодородный слой почвы) и подпахотный слой. В законодательстве закреплены следующие виды плодородных слоев почвы¹⁵¹: *верхний плодородный слой, почвенный покров, потенциально-плодородные слои и породы* (лесс, лессовидные и покровные суглинки¹⁵² и др.). Как отмечает Е.А. Колеватых, «ареалы распространения покровных суглинков занимают значительную часть средней и южной тайги, зоны смешанных и лиственных лесов, следовательно, являются материнскими породами для дерново-подзолистых, серых лесных и ряда других типов почв, широко эксплуатируемых в сельском и лесном хозяйстве Нечерноземья»¹⁵³.

В связи с этим необходимо отметить, что редкие и находящиеся под угрозой исчезновения почвы в соответствии со ст. 62 Федерального закона «Об охране окружающей среды» подлежат охране государством. В целях их учета и охраны учреждаются Красная книга почв Российской Федерации и красные книги почв субъектов Российской Федерации, порядок ведения которых определяется законодательством об охране почв. Несмотря на то что еще к 2003 г. был подготовлен проект федерального

¹⁴⁷ Советский энциклопедический словарь. М., 1983. С. 1044.

¹⁴⁸ URL: <http://www.cultinfo.ru/fulltext/1/001/008/092/082.htm> (дата обращения 27 декабря 2010 г.).

¹⁴⁹ Бюллетень нормативных актов федеральных органов исполнительной власти. 1996. № 4.

¹⁵⁰ ГОСТ 20432-83. Удобрения. Термины и определения. URL: http://tekstert-nb.gubkin.ru/gost/pages_gost/21598.htm (дата обращения 15 декабря 2010 г.).

¹⁵¹ Приказ Минприроды РФ № 525, Роскомзема № 67 от 22 декабря 1995 г. «Об утверждении Основных положений о рекультивации земель, снятии, сохранении и рациональном использовании плодородного слоя почвы» // Бюллетень нормативных актов федеральных органов исполнительной власти. 1996. № 4.

¹⁵² Суглинок — осадочная горная порода, состоящая из глинистых, песчаных и пылеватых частиц // URL: <http://ru.wikipedia.org/wiki/> (дата обращения 15 декабря 2010 г.).

¹⁵³ Литосфера. 2010. № 6. С. 55.

закона «Об охране почв»¹⁵⁴, в котором предлагалось законодательно закрепить такие понятия, как почвы, плодородный слой почвы, деградированные почвы, почвенные карты, красная книга почв и т.д., до настоящего времени данный закон не принят. Но существуют и позитивные примеры правового регулирования в данной сфере. Так, 4 июля 2007 г. был принят закон г. Москвы № 31 «О городских почвах»¹⁵⁵. Данный закон регламентирует отношения по охране, рациональному использованию, восстановлению, улучшению городских почв и направлен на обеспечение выполнения городскими почвами экологических функций, в том числе произрастания травянистой и древесно-кустарниковой растительности, а также на сохранение благоприятной окружающей среды в г. Москве. В ст. 1 перечислены основные понятия, используемые в данном законе, а именно: «почвы», «городские почвы», «искусственно созданные почвы», «плодородный слой почвы», «почвогрунт» и др., «охрана городских почв» — комплекс правовых, организационных, экономических и других мер, направленных на сохранение, восстановление, улучшение качества городских почв, недопущение их нерационального использования, а также предотвращение загрязнения, захламления и других негативных воздействий на состояние городских почв; «рациональное использование городских почв» — экономически, экологически и социально обоснованное использование почв собственниками земельных участков, землепользователями, землевладельцами и арендаторами земельных участков на территории г. Москвы без снижения плодородия почв, способности выполнять ими экологические функции; «восстановление городских почв» — меры, осуществляемые при проведении рекультивации земель, санации (очистки) и реабилитации загрязненных, захлавленных, нарушенных или подвергшихся иным видам деградации городских почв и направленные на восстановление утраченной способности почв выполнять экологические функции и многих других. Учитывая также принятие 19 декабря 2007 г. закона г. Москвы № 48 «О землепользовании в городе Москве»¹⁵⁶, можно сделать вывод о том, что многие вопросы правового регулирования охраны и рационального использования почв уже давно разрешены и, более того, — законодательно закреплены. Необходимо использовать накопленный в данной сфере опыт и в первую очередь в правоприменительной практике.

Таким образом, на основании проведенного анализа можно сделать следующие выводы:

1. В современном российском законодательстве в исследуемой сфере действует достаточно объемный понятийно-категорийный аппарат;
2. Некоторые понятия являются близкими по значению, синонимичными, смежными;
3. В ряде источников категории земля и почва в рассматриваемой области являются равнозначными.

¹⁵⁴ URL: <http://asozd.duma.gov.ru/work/dz.nsf/ByID/0AC7D6B3159BDFFA432571BB005797DF?OpenDocument>. (дата обращения 15 декабря 2010 г.).

¹⁵⁵ URL: <http://www.garant.ru/products/ipo/prime/doc/287750/>

¹⁵⁶ Ведомости Московской городской Думы. 2008. № 2. Ст. 290.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТӨРИЙН АЛБАНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

З.Дашидаваа

*Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн захирал,
цагдаагийн хурандаа*



Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг бүрдүүлэгч нэг хэсэг болсон **“Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх”** гэсэн асуудлыг тодорхойлохдоо *“Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг гишүүнээр бүрдүүлэх бодлого баримтлана. Мөн төрийн албан хаагчдад тавигдах ёс зүй, мэдлэг чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин хангамжийн нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллах нөхцлийг бүрдүүлнэ”* гэж заажээ.¹⁵⁷

Эндээс үзэхэд, төрийн албаны тогтвортой байдал, төрийн албан хаагчийн мэдлэг чадвар нь төрийн залгамж чанар цаашилбал, Монгол Улсын дотоод аюулгүй байдалтай холбогдох чухал асуудал гэдэг нь харагдаж байна. Тиймээс бид энэ удаад Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг тодорхойлогч төрийн албаны тогтвортой байдал, төрийн алба хаагчийн мэдлэг чадварын шалгуурын асуудлыг тухайлан авч үзэж, түүний хүрээнд хийгдэж буй шинэчлэлт, анхаарах зарим асуудлыг хөндөхийг зорьлоо.

Аливаа улс орны төрийн алба хэдий чинээ мэргэшсэн, тогтвортой байх тусам тухайн орны улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээг хамарсан өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн төдий чинээ сайжирч, нийгмийн хөгжлийн хөтөч болж чаддаг байна. 1883 онд АНУ-ын Ардчилсан намын сенатч Жорж Пендлтоны санаачилж батлуулсан Төрийн албаны шинэтгэлийн акт (“Пендлтоны хууль” гэж алдаршсан)-аар тус улсад улс төрийн намуудад сонгуулийн үр дүнгээр төрийн албан тушаалыг хуваарилдаг, төрийн албанд улс төр хүчтэй нөлөөлдөг шударга бус тогтолцоог өөрчилсөн бөгөөд энэ үеэс эхлэн АНУ-д төрийн албаны мерит тогтолцоо бүрдсэн байдаг.

Манай улсад бүс нутгийн хувьд хамгийн ойрын жишээ бол Япон, Өмнөд Солонгос зэрэг Азийн өндөр хөгжилтэй орнууд дэлхийн II дайны дараа Пендлтоны

¹⁵⁷ Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол улсын Их Хурлын тогтоол №48 2010 он,

хуулийн үзэл баримтлалыг нутагшуулан хэрэгжүүлж, мерит зарчмыг төрийн албандаа баримталж цэгцэлсэн нь тийнхүү хурдтай хөгжих бололцоо олгосон гэж судлаач, шинжээчид үздэг байна.¹⁵⁸

Төрийн албаны шинэтгэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мерит зарчмыг тууштай хэрэгжүүлэх замаар аль болох түргэн урагшлуулах, олсон ололтоо бататган, цаашид улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой, чадварлаг төрийн албыг бэхжүүлэн хөгжүүлэх ашиг сонирхол төр засгийн түвшинд ч, олон нийтийн хүрээнд ч нэгдмэл байна. Бид мерит зарчмыг баримтлан төрийн албаны шинэтгэлээ үргэлжлүүлэхийн тулд үүнд таатай нөхцлийг цогцоор нь бүрдүүлэх явдлыг ч орхигдуулж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт¹⁵⁹ *"Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана"*, мөн зүйлийн 3 дахь хэсэгт *"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно"* гэж тус тус заасан билээ.

Үндсэн хуулийн дээр дурдсан зүйл, заалтыг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийг боловсруулан баталж, 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөнөөс хойш мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албанд чадварлаг боловсон хүчнийг шилж сонгон ажиллуулах үйл явц гараагаа эхэлсэн юм.

Төрийн албан хаагч гэдэг ойлголтыг өргөн, явцуу гэсэн хоёр утгаар авч үзэж, өгөн утгаар нь зөвхөн төрийн эрх мэдлийн байгууллагад төдийгүй, нийгмийн өөрөө удирдах болон төрийн өмчийн үйлдвэр, албан газар, байгууллагад төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчийг хамруулан ойлгохын зэрэгцээ явцуу утгаар нь төрийн албан тушаал, өөрөөр хэлбэл зөвхөн төрийн эрх мэдлийн /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн/ байгууллагад албан тушаал эрхэлж байгаа этгээд гэж ойлгож иржээ.¹⁶⁰

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд төрийн албанд баримтлахаар тунхагласан зарчмуудын дотор "Төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх" буюу Мерит зарчим онцгой байр суурийг эзлэх бөгөөд түүний хүрээнд Төрийн албаны тухай хуульд дор дурдсан харилцааг хуульчилсан.

Үүнд:

-Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэхмэдлэг, боловсрол, туршлага, урчадвартай, мэргэшсэнбайх явдал мөн;

- Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно;

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

¹⁵⁸ Д.Зүмбэрэлхам "Монгол Улсын төрийн албаны шинэчлэл: Сорилт, Боломж" сэдэвт үндэсний чуулганы үндсэн илтгэл

¹⁵⁹ Монгол Улсын Үндсэн хууль. Улаанбаатар хот. 1992он

¹⁶⁰ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Судалгааны тайлангийн эмхтгэл 2003-2009. 316тал

- Төрийн жинхэнэ албан хаагч нь харъяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх; албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөл давтахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх; албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх зэрэг нийтлэг үүрэг хүлээнэ;

- Төрийн жинхэнэ албан хаагч албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцохыг болон ажил хаялт, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг дагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээг төлөвлөх зохион байгуулах, тэдгээрт оролцох зэргийг тус тус хориглоно;

- Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших болсон бол хуульд заасан нэр дэвших ажлыг эхлэх өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн байгууллагаас чөлөөлөхөд саад болохгүй.

Төрийн алба тогтвортой байх гэдэгт төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдал, төрийн албан хаагчийн тогтвортой ажиллах баталгааны аль аль нь багтана.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд тусгагдсан "Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх" буюу мерит зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дээр дурдсан харилцааг өндөр хөгжилтэй орнуудын төрийн албаны хуулийн ижил төрлийн харилцаатай харьцуулан үзвэл дутуу зүйлгүй мэт сэтгэгдэл төрөх боловч тэдгээрийн хэрэгжилт нь ямар түвшинд байна вэ гэдэг үүднээс авч үзвэл анхаарал татсан асуудал олон байгааг сүүлийн жилүүдийн практикаас харж болохоор байна. Энэ нь:


Нэгдүгээрт: Өнөөгийн байдлаас харахад сонгууль болгоны дараа шинэ тутам үүссэн Засгийн газар нь яам, агентлагуудыг шинээр нэмэх, татан буулгах, өөрчлөн байгуулах, нэгтгэх үйл явц хэвийн хэмжээнээс буюу зайлшгүй шаардлагаас хэтэрсэн дүр төрх харагддаг. Энэ нь захиргааны шинэчлэл, төрийн албаны эрх ашиг гэхээс илүүтэй улс төрийн намуудын явцуу ашиг сонирхолтой холбоотой байдаг нь нууц биш. Байгууллагын тогтворгүй байдлаас төрийн байгууллагын үйл ажиллагааны залгамж чанар, мэргэшүүлж ажиллуулах зэрэг төрийн албаны үнэт зүйлс доголдоход хүрдэг ба төрийн албан хаагчийн хувьд ч урам зоригтой ажиллах сэтгэл нь мохож, итгэл нь алдрахад хүргэж байна.

Иймээс төрийн байгууллагуудын бүтцийг өөрчлөх үндэслэлийг хуульд маш тодорхой зааж тусгах шаардлага гарч байна. Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг хуульчлан тогтоох, хэрэв татан буугдах, нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх бол ямар нөхцөлд энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ тохиолдолд тэнд ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын цаашдын ажил эрхлэлтийн асуудлыг ямар зарчмаар шийдэхийг Төрийн албаны тухай хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна. Ингэснээр төрийн байгууллага хоорондын ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, зохион байгуулалтын бүтэц, орон тоог үндэслэлтэй тогтоох, төвлөрлийг сааруулах замаар орон нутгийн эрх мэдлийг өргөтгөх асуудлыг оновчтой шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Үүнийг дагаад Монгол улсад сүүлийн жилүүдэд төрийн албан хаагчдын тоо өссөн нь дараах сөрөг талыг дагуулж байна.

Нэгдүгээрт. Төрийн албаны бүтэц орон тоо нэмэгдсэнээр зардал өснө. Жишээлбэл төрийн албан хаагчийн нэг сарын цалинг дунджаар зургаан сая төгрөгөөр тооцож үзэн мөн жил бүр хэдэн мянган төрийн албан хаагч нэмэгдэж байгаа. Гэтэл энэ мөнгөөр хэдэн ерөнхий болосвролын сургууль, хэдэн цэцэрлэг, хэдэн км автозам барих боломжтой.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс явуулсан судалгаагаар¹⁶¹ 2007оны байдлаар төрийн нийт албан хаагчдын тоо 142258 байсан бол 2013 оны байдлаар 196448 болж даруй 54490 албан хаагчаар нэмэгдэж сүүлийн 5 жилийн хугацаанд огцом өссөнийг харуулж байна. Үүнийг графикаар харуулбал:



Хоёрдугаарт: Төрийн албан хаагчдыг хуульд заасан үндэслэлээс гадуур халж, чөлөөлөхийг бүр мөсөн таслан зогсоох шаардлагатай байгаа бөгөөд энэ талаар зөрчил гаргасан удирдах албан тушаалтныг томилох эрх бүхий албан тушаалаас нь шууд өөрчилдөг болгон хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна. Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээс ажлаас чөлөөлөх, халах, өөрчлөх нь төрийн албаны тогтвортой байдалд ихээхэн хортой үйл ажиллагаа гэдгийг онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Цаашид ийм эрүүл биш сэтгэлгээтэй, ардчилал, шударга ёсны зарчмыг уландаа гишгэдэг удирдах албан тушаалтан төрийн алба удирдах нь байтугай төрд алба хаших боломжгүй байх хэмжээнд асуудлыг тавьж шийдвэрлэх нь шинэтгэлийн шаардлагад бүрэн нийцнэ.

Иймд төрийн улс төрийн албан тушаалаас бусад албаны томилгоонд улс төрийн намуудын зүгээс огт оролцдоггүй, улс төрийн сонгууль ба түүний үр дүн төрийн албаны томилгоо болон хэвийн үйл ажиллагаанд нь огт нөлөөлөлдөггүй байх нөхцөл баталгааг бүрдүүлэх явдал мерит зарчмыг хэрэгжүүлэх хамгийн эхний нэн чухал зорилт гэж үзэж байна. Үүний тулд Төрийн албаны тухай хуулиас гадна Улс төрийн намуудын тухай хуульд ч төрийн албанд нөлөөлөхийг хориглосон заалт нэмж, аль аль талын хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

АНУ төрийн иргэний алба нь 1978 онд конгрессоор батлагдсан Төрийн иргэний албаны шинэтгэлийн тухай хуулийн дагуу өрсөлдөөн болон тусгайлсан гэсэн хоёр хэсгээс бүрддэг байна. Нийт төрийн албан хаагчдын 90% нь өрсөлдөөнт системээр дамжин

¹⁶¹ [www.http://: csc.gov.mn](http://csc.gov.mn)

томилогддог. Мөн өрсөлдөөнт согон шалгаруулалтаар шууд томилдоггүй ба 120 хоног хүртэл хугацаагаар ажиллуулах түр түр албан тушаалууд байдаг.

Японд төрийн албанд орохдоо өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар ордог. Нэг албан тушаалын төлөө өрсөлдөх иргэний тоо 100 хүртэл байх нь энэнүүхэнд. Зөвхөн Япон улсын иргэн уг шалгалтанд орох эрхтэй бөгөөд шалгалтыг аман болон бичгээр гэсэн хоёр төрөлүүдтэй. Японы төрийн албаны нэг онцлог нь насан туршид нь ажиллуулах баталгаар хангадаг байна.

Гуравдугаарт: Төрийн албаны чанар хүний нөөцийн чанараас шууд шалтгаална. Жишээ нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан **“Том төрөөс ухаалаг төр лүү”** Үндэсний зөвлөлдөх уулзалт дээр Төр томорч буй нэг шалтгааныг Төрд мэдлэг, технологийн дэвшил орж ирэхгүй байгаа бөгөөд зөвхөн бүтэц орон тооны механик өсөлтөөр л асуудлыг шийдвэрлэх гэж оролдож байна гэж үзжээ¹⁶². Үүнийг диаграмаар харуулсныг ишлэвэл:



Чанарын тухай авч үзэхэд зөв хүнийг зөв албан тушаалд томилох асуудал гол нь юм. Үүний тулд албан тушаал бүрийн зорилго, зорилт, эрх, үүрэг, хариуцлага, түүнд ажиллах хүнд тавигдах шаардлагуудыг хэм хэмжээ тогтоосон актын дагуу тодорхой болгох учиртай. Өнөөгийн байдлаар сул орон тоо гарсан тохиолдол болгонд тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг ажил олгогч өөрийн сонирхож байгаа хүндээ тохируулан өөрчилж болох бололцоо олгосон эрх зүйн орчинтой байгаа нь хүний нөөцийн чанарын шаардлага хангахад хамгийн их саад болж байна. Иймд ажлын байр

¹⁶² Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж-ийн хийсэн танилцуулга, хэлсэн үг. “ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ” үндэсний зөвлөлдөх уулзалт. Улаанбаатар хот. 2013.11.16

болгонд ажиллах албан тушаалтанд тавигдах шаардлагууд маш тодорхой, тогтвортой байх баталгааг эрх зүйн хувьд бүрдүүлэх нь чухал байна.

Эцэст нь дүгнэхэд Төрийн албаны тогтворгүй байдал, төрийн алба хаагчийн мэдлэг чадварын өсөлт хөгжилтийн өнөөгийн дүр төрх Монгол улсын төрийн байгууллын буюу дотоод аюулгүй байдлыг ганхуудахад нөлөөлж болох дотоод гол шалтгааны нэг болох нь харагдаж байна.

Иймд энэ асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Төрийн байгууллагуудийн бүтцийг өөрчлөх үндэслэлийг хуульд тодорхой зааж тусгах. Тухайлбал, Яам агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой тусгах шаардлагатай.
2. Төрийн албаны тухай хуулиас гадна **Улс төрийн намуудын тухай хуульд** ч төрийн албанд нөлөөлөхийг хориглосон заалт нэмэх, аль аль талын хүлээх хариуцлагыг тогтолцоог бүрдүүлэх,
3. Төрийн албан тушаал бүрийн зорилго, зорилт, эрх, үүрэг, хариуцлага, түүнд ажиллах хүнд тавигдах **шаардлагуудыг хэм хэмжээ тогтоосон актын** дагуу тодорхой болгох зэрэг болно.

Ном зүй:

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл №1. Улаанбаатар., 1992
- Монгол Улсын Төрийн Албаны тухай хууль. УИХ тогтоол. Улаанбаатар., 2002
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. Судалгааны тайлангийн эмхтгэл 2003-2009
- Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хийсэн танилцуулга, хэлсэн үг. “ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ” үндэсний зөвлөлдөх уулзалт. Улаанбаатар., 2013
- Д.Зүмбэрэлхам. “Монгол Улсын төрийн албаны шинэчлэл: Сорилт, боломж” сэдэвт үндэсний чуулганы илтгэл
- Х.Наранбаатар. Төрийн алба. Улаанбаатар., 2010
- www.csc.gov.mn

